



2020

МОНГОЛ УЛСЫН САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТАЙЛАН

ЭРСДЭЛ БОЛОН ЭМЗЭГ БАЙДАЛ

Улаанбаатар хот

2020 он

ГАРЧИГ

ХУРААНГУЙ	3
1. ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛ, ЭМЗЭГ БАЙДАЛ	7
1.1 Дэлхийн эдийн засгийн эрсдэл, эмзэг байдал	7
1.2 Дэлхийн санхүүгийн зах зээлийн эрсдэл, эмзэг байдал	11
2. КОВИД-19 ЦАР ТАХЛЫН МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН САЛБАРТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ	15
2.1 Ковид-19 цар тахлын Монгол Улсын эдийн засагт үзүүлэх нөлөөлөл	15
Төлбөрийн тэнцлийн суваг	15
Орлогын суваг	18
Зээлийн суваг	21
Шигтгээ 1. Зээлийн төлөвийн түүвэр судалгааны үр дүн	23
2.2 Ковид-19 цар тахлын Монгол Улсын санхүүгийн салбарт үзүүлэх нөлөөлөл	24
Банкны салбарт үзүүлэх нөлөөлөл	28
Шигтгээ 2. Санхүүгийн системийн эрсдэлийн зураглал	30
Банкнаас бусад санхүүгийн салбарт үзүүлэх нөлөөлөл	32
3. МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН САЛБАРЫН ГОЛЛОХ ЭРСДЭЛ, ЭМЗЭГ БАЙДАЛ	48
3.1 Монгол Улсын санхүүгийн салбарын эрсдэл, эмзэг байдал	48
Банкны салбарын эх үүсвэрийн долларжилт	48
Банкны салбарын эх үүсвэрийн төвлөрөл	55
4. МОНГОЛБАНКНААС ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ МАКРО ЗОХИСТОЙ БОДЛОГЫН АРГА ХЭМЖЭЭ	64
ХАВСРАЛТ	82

Хураангуй

Санхүүгийн тогтвортой байдлын тайлангийн 14 дэх дугаарыг Монголбанкнаас боловсруулж олон нийтэд хүргэхэд бэлэн боллоо. Уг тайлан нь (1) Дэлхийн эдийн засаг, санхүүгийн зах зээлийн эрсдэл эмзэг байдал, (2) Ковид-19 цар тахлын Монгол Улсын эдийн засаг, санхүүгийн салбарт үзүүлэх нөлөөлөл, (3) Монгол Улсын эдийн засаг, санхүүгийн салбарын голлох эрсдэл, эмзэг байдал, (4) Монголбанкнаас хэрэгжүүлж буй макро зохистой бодлогын арга хэмжээний тухай нийт дөрвөн бүлгээс бүрдэж байгаа бөгөөд Санхүүгийн Зохицуулах Хорооны зүгээс банкны бус санхүүгийн салбарын нөхцөл байдал, авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар дэлгэрэнгүй мэдээллийг бэлтгэн ирүүлсэн болно.

Гадаад эрсдэл

Цар тахлын улмаас улс орнуудад хөл хорио тогтоож, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа доголдсон нь эдийн засгийн идэвхжилд сөргөөр нөлөөлөв. Олон улсын байгууллагуудын зүгээс 2020 оны дэлхийн эдийн засгийн өсөлтийн таамаглалыг -4.9 хувь буюу 4 дүгээр сарын төсөөллөөс 1.9 нэгж хувиар бууруулсан нь 2008-2009 оны дэлхийн санхүүгийн хямралаас улбаатай эдийн засгийн уналтаас ч хүнд цохилт болж байна. 2020 оны хувьд хөгжингүй орнуудын ДНБ 6.1 хувиар, харин хөгжиж буй орнуудын ДНБ 2020 онд 1 хувиар тус тус агшихаар хүлээгдэж байна.

Улс орнууд хямралын давхар давлагаатай тулгарч болзошгүй байна. Эрүүл мэндийн системийн хувьд үүссэн хүндрэл бэрхшээл, дотоод хүчин зүйлсээс үүдэлтэй эдийн засаг дахь доголдлууд, гадаад эрэлтийн огцом агшилт, хөрөнгийн гадагшлах урсгал, биржийн барааны үнийн огцом уналт нөхцөл байдлыг улам хүндрэх төлөвийг дохиолж байна. Иймд улс орнууд хямралыг даван туулах эдийн засгийг сэргээх төсвийн шинжтэй багц хөтөлбөрүүдийг зарлаж эхлээд байна.

Эдийн засгийн уналтыг сөрөх үүднээс Герман, Итали, Их Британи, АНУ, Франц, Япон зэрэг улсууд төсөв татвартай холбоотой томоохон арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж байна. Энэтхэг, Индонез, Хятад, Өмнөд Африкийн Бүгд найрамдах улс зэрэг хөгжиж буй улс орнууд цар тахлын нөлөөнд хамгийн ихээр өртсөн эдийн засгийн сектор, ажиллагсдад төсвийн дэмжлэг үзүүлж эхлээд байна. Эдгээр арга хэмжээ нь итгэлийг сэргээж, нийт эрэлтийг бэхжүүлэх замаар гүнзгий уналтаас зайлсхийх боломжийг бүрдүүлэх учиртай юм.

Дэлхийн нийтээр төв банкууд бодлогын хүүгээ түүхэн бага түвшинд хүргэх замаар мөнгө зээлийн дэмжлэгийг идэвхжүүлж, нээлттэй захын үйл ажиллагаа эрхлэх замаар нөөц нийлүүлж банкны системийн дарамтыг бууруулахаар ажиллаж байна. Хөгжиж буй орнуудын төв банкууд бодлогын хүүг бууруулах арга хэмжээг авч эхэлсэн бөгөөд эдгээр арга хэмжээ нь итгэлийг сэргээх замаар системд үүссэн сөрөг шокийг хязгаарлахад эерэгээр нөлөөлж байгаа билээ. Үүний сацуу хэд хэдэн төв банк своп хэлцлийн үндсэн дээр зээлийн сувгийн механизмуудыг ашиглан ам.долларын нөөц нийлүүлж байна. Төв банкууд 2008-2009 оны арга хэмжээг,

тухайлбал компанийн бонд зэрэг эрсдэлтэй активыг худалдаж авах арга хэмжээг авав. Төв банкууд ийнхүү “эцсийн худалдан авагч”-ийн үүрэг гүйцэтгэснээр өрхийн аж ахуй, компаниудын хувьд зээлийн олдцыг хэвийн байлгахыг зорьж байгаа билээ. Төв банкууд зээллэг, активын худалдан авалтаар дамжуулан 6 их наяд ам.долларын нөөц нийлүүлэхээ мэдэгдэж байгаа нь хөрөнгө оруулагчдын итгэлцэлд эерэгээр нөлөөлж байна. Ингэснээр зарим зах дээр үүссэн хурцадмал байдал намжиж, эрсдэлтэй активуудын үнэ тогтворжих хандлага ажиглагдаж буй хэдий ч зах зээлд ихээхэн хэмжээний тодорхойгүй байдал хадгалагдсаар байгаа төдийгүй санхүүгийн захын нөхцөл байдал 2020 оны эхэнтэй харьцуулахад чангарлаа.

Цар тахал хүчээ авснаас хойш эрсдэлтэй активын үнэ 2008-2009 онтой харьцуулахад 50 гаруй хувиар унажээ. Хөрөнгийн биржүүд дээр үнийн бууралт доод цэгтээ хүрч, 30 ба түүнээс илүү хувиар унасан байна. Зээлийн спредүүд ялангуяа зээлжих зэрэглэл доогуур компаниудын хувьд огцом нэмэгдэв. Түүнчлэн богино хугацаат санхүүжилтийн томоохон захуудад, үүний дотор ам.долларын зах дээр хүндрэл, бэрхшээл ажиглагдаж, үүссэн савалгаа нь үнэ огцом өсөхөд нөлөөлж байна.

Хүү маш бага түвшинд байгаа нь цаашид эмзэг байдлыг нэмэгдүүлж байгаа ба үүнтэй зэрэгцэн санхүүгийн захын нөхцөл байдал үргэлжлэн чангаран эдийн засгийн уналт гүнзгий төдийгүй, удаан хугацаанд үргэлжлэх эрсдэлийг дагуулж байна.

Дэлхийн санхүүгийн зах хямралд өртөхөд юуны түрүүнд хөгжиж буй орнуудаас хөрөнгө гадагшлах зүй тогтол энэ удаа ч ажиглагдаж ДНБ-ий 0.4 хувьтай тэнцэх буюу 100 орчим тэрбум ам.долларын багцийн хөрөнгө оруулалт гадагшлах нь түүхэнд байгаагүй өндөр үзүүлэлт болов.

Цар тахлын Монгол Улсын эдийн засагт үзүүлж буй нөлөө

Монгол Улсын гадаад худалдааны гол түнш улс болох Хятадын ДНБ энэ оны эхний улиралд 6.8 хувиар буураад байсан бол 2 дугаар улиралд 3.2 хувиар өсөв. Зээлжих зэрэглэл тогтоогч S&P агентлагийн таамаглалаар Хятадын ДНБ-ий өсөлт 2020 онд 2.7 хувьд хүрэхээр байна. Хятадын эдийн засгийн өсөлт ийнхүү удааширч буй нь Монгол Улсын экспортын орлогын 87.1 хувийг бүрдүүлдэг уул уурхайн бүтээгдэхүүний экспортод сөргөөр нөлөөлөв. Түүхий эдийн үнэ болон эрэлтийн бууралт дэлхийн зах зээл дээрх нүүрс, зэс, төмрийн хүдэр, цинк, түүхий нефтийн экспортыг хумих замаар экспортлогч орнуудын эдийн засгийн өсөлтийг сааруулав.

Нүүрсний үнэ харьцангуй тогтвортой байгаа хэдий ч, Хятадын нүүрсний хэрэглээ 30 гаруй хувиар буурч, цар тахлын нөлөөгөөр Монгол Улс энэ оны эхний улиралд нүүрсний экспорт тасалдсан. Монгол Улсын экспортын орлогын 40 хувь, төсвийн орлогын 15 хувийг бүрдүүлдэг зэсийн үнэ 6300-аас 5700 ам.доллар болтлоо буурав. Түүнчлэн экспортын бас нэгэн чухал бүтээгдэхүүн болох төмрийн хүдрийн үнэ Хятад улсын эрэлт саарч байгаатай холбоотойгоор 119 ам.доллараас 2020 онд 89 орчим ам.доллар болтол буурч, энэ түвшнээс өсөхгүй байж болзошгүй байна.

Цар тахал, гадаад болон дотоод орчны тодорхойгүй байдал нэмэгдсэнтэй холбоотойгоор ДНБ 2020 оны эхний улиралд 10.7 хувиар буурлаа. Цар тахлын “цохилтод” юуны түрүүнд уул уурхай болон үйлчилгээний салбар (нүүрсний тээвэрлэлт, агаарын тээвэр, аялал жуулчлал) нэрвэгдэв. Уул уурхайд шаардлагатай тоног төхөөрөмж, түлшний хэрэглээ буурч, худалдааны компаниуд ашиг орлогоо алдав. Монгол Улсад ирсэн гадаад иргэдийн тоо өмнөх оноос 21 хувиар цөөрч, аялал жуулчлалын орлого 28 хувиар буурсан бол агаарын тээврийн салбарын орлого 28 хувиар буурсан бол агаарын тээврийн салбарын орлого даруй 21.7 хувиар буурчээ. Цар тахлын нөлөөнд шууд өртсөн компаниудын борлуулалт буурснаар банкны зээл, түрээс, ажилчдын цалин олголтод доголдол үүсэв.

Монгол Улсын нэгдсэн төсвийн орлогын 23.7 хувийг бүрдүүлдэг эрдэс баялгийн салбараас төсөвт төвлөрүүлсэн орлого 347.3 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 32.9 хувиар буурав. Ингэснээр Засгийн газрын хэрэглээ, хөрөнгө оруулалтын эдийн засгийн өсөлтөд оруулах хувь нэмэр буурахаар хүлээгдэж байна.

Монгол Улсын ДНБ 2020 онд 1-2 орчим хувиар агшихаар хүлээгдэж байгаа боловч 2021 онд 7-8 хувиар өсч сэргэх төсөөлөлтэй байна. Гэвч энэхүү таамаглал хэрэгжих эсэх нь цар тахлын төлөв, нийлүүлэлтийн сүлжээний доголдол, дэлхийн санхүүгийн захын нөхцөл байдал хэр чангарах, зардлын бүтцэд гарах өөрчлөлт, хөрөнгө оруулагчдын итгэл, бирж дээр зарагдаж буй барааны үнэ зэрэг олон хүчин зүйлсээс хамаарахаар байна.

Засгийн газраас эдийн засгийг дэмжих 1.8 тэрбум ам.долларын багц хөтөлбөрийг зарлав. Энэ хүрээнд 18-аас доош насны хүүхэд бүрт олгох сар бүрийн тэтгэмжийг зургаан сарын турш 100000 төгрөг болгон нэмэгдүүлэв. Үйл ажиллагаа нь тасалдсан хэдий ч ажлын байраа хадгалсан ААН-ийн ажилчдад сар бүр 200 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг 6 сарын турш үзүүлж байна. Засгийн газраас нийгмийн халамжийн тэтгэмжийг 5 сарын турш 100000 төгрөгөөр нэмэгдүүлэв. Аж ахуйн нэгж, байгууллагуудыг 4-р сарын 1-ээс 10-р сарын 1-ний хооронд нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөв. Багц хөтөлбөрийн үр дүнд хувийн хэрэглээ өссөн нь эдийн засагт эергээр нөлөөлж байна.

Цар тахлын санхүүгийн салбарт үзүүлж буй нөлөө

Ковид-19 цар тахлын тархалтаас урьдчилан сэргийлэхтэй холбогдуулан Засгийн газраас авсан арга хэмжээний хүрээнд хил хааж, хорио цээрийн дэглэм тогтоосноор экспортын үйл ажиллагаа зогсонги байдалд орох, бөөний болон жижиглэн худалдааны нийлүүлэлт буурах, хүнсний бус худалдааны салбар, тээвэр, түрээс, үйлчилгээний салбарын орлого тасалдах сөрөг үр дагаврууд гарав. Үүнтэй холбоотойгоор 2020 оны 6 дугаар байдлаар банкны салбарт иргэдийн 126 мянган зээлдэгчийн 1.8 их наяд, ААН-ийн 2672 зээлдэгчийн 3.1 их наядын зээлийн эргэн төлөлтөд хүндрэл үүсээд байна. Үүнтэй холбоотойгоор Монголбанкнаас зээлийн эргэн төлөлтийг хойшлуулах, зээлийн ангиллыг тодорхой хугацаанд бууруулахгүй байх арга хэмжээг авч хэрэгжүүлсэн бөгөөд 2020 оны 6 дугаар сарын байдлаар банкны системд 92.8 мянган зээлдэгчийн 2.6 их наяд төгрөгийн зээлийн бүтцэд өөрчлөлт оржээ.

Ковид-19 цар тахлаас шалтгаалан зээл олголт болон эргэн төлөлтүүд тасалдан хойшлогдох, Ковид-19-т өртсөн зарим зээлдэгчийн хувьд цаашид үйл ажиллагаа явуулах боломжгүй болох буюу эрсдэлийн сангийн зардлыг нэмэгдүүлэх зэрэг хувилбаруудаар банкны системд стресс тестийн шинжилгээ хийхэд үр дүнд нь банкны системийн хэмжээнд өөрийн хөрөнгийн хүрэлцээ болон төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт алдагдахааргүй байна. Банкуудын ашигт ажиллагаа буурч, алдагдалтай ажиллах, зээл олголт багасч, санхүүгийн салбар болон бодит сектор хоорондын харилцан уялдаа буурч, улмаар эдийн засгийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх үр дүн гарав.

Банк бус санхүүгийн салбарт 2020 оны 1 дүгээр улирлын байдлаар Ковид-19 цар тахлаас шалтгаалсан өөрчлөлт гараагүй. 2020 оны 1 дүгээр улиралд банк бус санхүүгийн байгууллагын нийт зээлийн өсөлт 30.3 хувь буюу өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 8.3 хувиар буурсан байна. Хадгаламж зээдийн хоршоодын олгосон нийт зээлийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10.4 хувиар өсч үүнээс чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 0.4 нэгж хувиар өсч 4.3 хувьд хүрэв.

Зах зээлд тодорхой бус байдал үүссэн өнөө үед иргэдийн зээлийн төлбөрийн дарамтыг бууруулах, зээлийн мэдээллийн санд муу зээлдэгчээр бүртгэгдэхээс сэргийлэх зорилгоор Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайдын 2020 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн 122/58 дугаар хамтарсан тушаалаар “Банк бус санхүүгийн байгууллагын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”, “Хадгаламж, зээлийн хоршооны активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж зарцуулах журам”-д түр хугацаанд өөрчлөлт оруулсан билээ.

Монгол Улсын хөрөнгийн зах зээл дээрх компаниудын хувьцаа нь хувьцаа эзэмшигчдийн төвлөрөл өндөртэй, хоёрдогч зах зээлд арилжаалагддаг хувьцааны хэмжээ бага, зах зээлийн идэвх сул зэрэг шалтгааны улмаас зах зээл аливаа нөлөөнд харьцангуй мэдрэг бус байх хандлага ажиглагддаг. Монголын хөрөнгийн зах зээлийн хувьд зах зээлийн үнэлгээ 1 дүгээр улиралд өөрчлөлтгүй боловч, 4 дүгээр сараас уналт үзүүлж эхлэв. Зах зээлийн үнэлгээ 2020 оны 6 дугаар сарын байдлаар 9.5 хувиар буурч ДНБ-тэй харьцуулахад 6.6 хувьтай тэнцэж байна. Даатгалын салбарын хөгжлийн гол хэмжүүр даатгалын гүнзгийрэлт буюу ДНБ-д эзлэх хураамжийн орлогын хувь хэмжээ манай улсын хувьд олон улсын түвшинтэй харьцуулахад нэлээдгүй доогуур буюу 2020 оны 1 дүгээр улиралд даатгалын гүнзгийрэлт 0.44 хувьд хүрч өмнөх оны мөн үеэс 0.01 хувиар буурсан байна. Даатгалын салбарт хураамжийн орлого тасалдах, нөхөн төлбөрийн зардал давах, нөхөн төлбөрийн зардал багасах, улмаар нөөц сангийн хэмжээ багасах, валютын ханшийн дарамт нь сөргөөг нөлөөлөгч гол хүчин зүйл болж байна.

ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛ, ЭМЗЭГ БАЙДАЛ

1


1.1 ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ЭРСДЭЛ, ЭМЗЭГ БАЙДАЛ

Ковид-19 цар тахлаас үүдэлтэй дэлхий дахинд үүсээд буй хямралт нөхцөл байдал нь Монгол Улсын эдийн засагт сөргөөр нөлөөлж байна. Энэхүү нөлөөлөл нь юуны түрүүнд гадаад худалдааны нөхцөл муудах, БНХАУ руу гаргадаг уул уурхайн экспортын орлого буурах байдлаар илэрч байна. Гадаад худалдааны алдагдал нэмэгдсэнээр Монгол Улсын эдийн засгийн бүхий л салбарт сөргөөр нөлөөлж ДНБ-ий өсөлтийг сааруулав. Монгол Улс хилийн хяналт тавьж, дотооддоо хөл хорио тогтоосонтой холбоотойгоор санхүүгийн болон санхүүгийн бус сектор, иргэд, Засгийн газрын орлого буурч байгаа нь эдийн засгийн идэвхжлийг сааруулж байна. Цаашид гадаад худалдааны нөхцөл үргэлжлэн муудаж, төлбөрийн

тэнцлийн дарамт нэмэгдвэл санхүүгийн секторт сөргөөр нөлөөлж, улмаар эдийн засгийн уналтын далайцыг нэмэгдүүлэх эрсдэлтэй.

Олон улсын байгууллагууд 2020 онд дэлхийн эдийн засаг агшина хэмээн таамаглаж байна. Ковид-19 цар тахлын дэлхийн эдийн засагт үзүүлж буй сөрөг нөлөөллийг харгалзан үзэж, Олон улсын валютын сан (ОУВС), Дэлхийн банк, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (ЭЗХАХБ) зэрэг олон улсын байгууллагуудын зүгээс 2020 оны дэлхийн эдийн засгийн өсөлтийн таамаглалаа огцом бууруулаад байна.

Дүрслэл 1.1 Дэлхийн эдийн засгийн өсөлтийн төсөөлөл



Эх сурвалж: ОУВС-гийн төсөөлөл, "Дэлхийн эдийн засгийн хандлага (World economic outlook update)" тайлан.
Тэмдэглэл: "2020-1 сар" болон "2020-6 сар" нь ОУВС-гаас 2020 оны 1 дүгээр сар болон 6 дугаар сард хийсэн эдийн засгийн өсөлтийн төсөөллүүд болно.

Дүрслэл 1.2 Дэлхийн аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн болон худалдааны хэмжээний индексийн жилийн өөрчлөлт



Эх сурвалж: СРВ Неделанд улсын эдийн засгийн бодлогын шинжилгээний товчоо.
Тэмдэглэл: Хамгийн сүүлийн статистик нь 2020 оны 3 дугаар сарын статистик болно.

Тухайлбал, 2020 оны 6 дугаар сард ОУВС-гийн шинжээчид 2020 оны дэлхийн эдийн засгийн өсөлтийн төсөөллийг 2020 оны 1 дүгээр сарын төсөөллөөс 8.2 нэгж хувиар бууруулж, -4.9 хувь болгосон байна.

Цар тахлын тархалтыг хязгаарлах зорилгоор дэлхийн улс орнуудад хөл хорио, хилийн хяналт тогтоох арга хэмжээг нийтлэг авч хэрэгжүүлж байна. Үүнээс шалтгаалан аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа доголдон нийлүүлэлт тасалдаж, өрх, аж ахуйн нэгжийн орлого буурч, эрэлт агшсанаар эдийн засгийн идэвхжилд сөргөөр нөлөөлсөн байна. 2020 оны 1 дүгээр улиралд АНУ-ын эдийн засаг 4.8 хувиар 2 дугаар улиралд 9.5 хувиар, Евро бүсийн орнуудын эдийн засаг 3.8 болон 12.1 хувиар тус тус агшив. Харин БНХАУ-ын эдийн засаг 2020 оны эхний улиралд 6.8 хувиар буурсан ч, 2 дугаар улиралд 3.2 хувиар өссөн бөгөөд цар тахал болон худалдаа, эдийн засгийн тодорхойгүй байдалтай холбоотойгоор 2020 оны ДНБ-ий өсөлтийн хувьд тодорхой зорилт дэвшүүлээгүй байна.


Дэлхийн аж үйлдвэрлэл болон худалдааны хэмжээ буурав. Дэлхийн томоохон аж үйлдвэржсэн орнууд болох АНУ болон БНХАУ-ын хооронд үүссэн технологи, гадаад худалдааны маргаан зэргээс

шалтгаалан дэлхийн аж үйлдвэрлэл болон худалдааны өсөлт 2018 оноос саарч эхэлсэн билээ. Ковид-19 цар тахлын нөлөөгөөр улс орнуудад зарим аж үйлдвэрүүд түр хугацаанд үйлдвэрлэлээ зогсоож, үйлдвэрлэлийн хэмжээгээ танаснаар 2020 оны 5 дугаар сард дэлхийн аж үйлдвэрлэл өмнөх оны мөн үеэс 13.8 хувиар буурсан байна.

Түүнчлэн цар тахлын нөлөөгөөр дэлхийн худалдааны хэмжээ 2020 оны 5 дугаар сард өмнөх оны мөн үеэс 17.7 хувиар буурсан бөгөөд Дэлхийн худалдааны байгууллагын төсөөллөөр 2020 онд 13-32 хувиар буурах таамагтай байна.

Монгол Улсын нийт экспортын орлогын 90 орчим хувийг БНХАУ руу гаргасан экспортын орлого бүрдүүлдэг. Иймд дэлхийн аж үйлдвэрлэл, худалдааны нийт эргэлт саарч, БНХАУ-ын эдийн засгийн өсөлт удааширч байгаа нь Монгол Улсын экспортын орлогыг бууруулах, төлбөрийн тэнцлийн хүндрэлийг үүсгэх замаар эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлж байна. Түүнчлэн “Санхүүгийн системийн эрсдэлийн зураглал”-аас үзэхэд экспортын хэмжээ, экспортын бүтээгдэхүүний үнэ, урсгал дансны тэнцэл, БНХАУ-ын эдийн засгийн өсөлт зэрэг үзүүлэлтүүд санхүүгийн системийн эмзэг байдлыг нэмэгдүүлж байна (Дүрслэл 1.3).

Дүрслэл 1.3 Санхүүгийн системийн эрсдэлийн зураглал (Гадаад секторын задаргаа)



Эх сурвалж: Монголбанк


Дэлхийн зах зээл дээрх металл, түүхий эдийн үнэ огцом унав. Цар тахлын нөлөөгөөр дэлхийн эдийн засгийн төлөв муудаж, Нефть экспортлогч орнуудын байгууллага (ОПЕК)-ын гишүүн орнуудын хэлэлцээр амжилтгүй болсон нь металл, түүхий эдийн үнийн бууралтад голлох нөлөөг үзүүлэв. 2020 оны 2 дугаар улиралд суурь металлын¹ үнэ 8 орчим хувиар, түүхий нефтийн үнэ 40 орчим хувиар тус тус унажээ. ОУВС-гийн төсөөллөөр дэлхийн аж үйлдвэрлэл огцом муудсанаас шалтгаалан суурь металлуудын үнийн индекс 2020 онд 10.2 хувиар, 2021 онд 4.2 хувиар тус тус буурах хүлээлттэй байна. Металлын хэрэглээ өндөр салбаруудын эдийн засгийн идэвхжил илүү удаан хугацаагаар муудаж болзошгүй байгаа нь металлын үнэд голлох эрсдэлийг үүсгэж байна.

Ирэх жилүүдэд түүхий нефтийн эрэлт дорвитой нэмэгдэхгүй байх хүлээлттэй байгаа тул 2020-2023 онд 1 баррел түүхий нефтийн үнэ 45 ам.доллараас давахгүй байх төлөвтэй байна.

Нүүрсний үнэ харьцангуй тогтвортой байгаа ч БНХАУ-ын нүүрсний хэрэглээ 30 гаруй хувиар буурсан төдийгүй Монгол Улс цар тахалтай холбоотойгоор нүүрсний экспортоо түр зогсоогоод байсан билээ. Монгол Улсын экспортын орлогын 40 хувь, төсвийн орлогын 15 хувийг бүрдүүлдэг зэсийн үнэ олон улсын түүхий эдийн зах зээлд үүссэн тодорхой бус байдлаас шалтгаалж 2020 оны 3 дугаар сард 6300-аас 4700 ам. доллар хүртэл буурсан байна.

Түүнчлэн төмрийн хүдрийн үнэ БНХАУ-д эрэлт саарч байгаатай холбоотойгоор 1 тонн нь 119 ам.доллараас 2020 онд 80 ам.доллар хүртэл буурч болзошгүй байна. Харин


Дүрслэл 1.4 Зэс, нүүрс, төмрийн хүдэр, Brent нефтийн үнэ



Эх сурвалж: Блүүмберг.

Тэмдэглэл: Нүүрсний үнийн хувьд МУ-ын экспортын нүүрсийн дундаж үнэ болно. Бусад үзүүлэлтүүдийн үнийн төсөөллийг Bloomberg-ийн жигнэсэн дундажийг ашиглав

Дүрслэл 1.5 Алтны үнэ



Эх сурвалж: Блүүмберг.

Тэмдэглэл: Үнийн төсөөллийг саарал өнгөөр тодотгов.

¹ Үүнд төмрийн хүдэр, зэс, хөнгөн цагаан, никел зэрэг металлууд орно.


эрсдэлээс зайлсхийх үзэгдлээс шалтгаалан алтны үнэ 2020 оны 1 дүгээр улиралд огцом өслөө.

Монгол Улсын нийт экспортын 90 гаруй хувийг уул уурхайн салбарын бүтээгдэхүүний экспорт эзэлдэг бөгөөд үүний 70 орчим нэгж хувийг зэс, нүүрс, төмрийн хүдрийн экспорт бүрдүүлж байна. Иймд эдгээр металл, түүхий эдийн үнэ буурвал Монгол Улсын уул уурхайн экспортын орлого буурч, гадаад худалдааны алдагдал нэмэгдэж, эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй юм.

Эдийн засгийн өсөлтийг дэмжих, хямралын эсрэг авч хэрэгжүүлэх макро бодлогын орон зай улс орнуудад хязгаарлагдмал байна. Ковид-19 цар тахлын сөрөг нөлөөг бууруулах, зах зээлийн итгэлийг сэргээж, нийт эрэлтийг тэтгэн эдийн засгийн огцом уналтаас зайлсхийх зорилгоор хөгжингүй болон хөгжиж буй улс орнуудад төсвийн тэлэх бодлогыг хэрэгжүүлэх нь түгээмэл байна. Энэ хүрээнд дэлхий даяар нийт 8 их наяд ам.долларыг зарцуулсан бөгөөд цаашид зардлын хэмжээ өсч болзошгүй байгаа нь улс орнуудын Засгийн газрын өрийн хэмжээг огцом нэмэгдүүлэх суурь шалтгаан болов.


ОУВС-гийн тооцооллоор 2020 онд дэлхийн нийт улс орнуудын Засгийн газрын өрийн хэмжээ өмнөх оноос 13 хувиар нэмэгдэх төсөөлөлтэй байгаа нь дэлхийн санхүү, эдийн засгийн хямрал нүүрлэсэн 2009 онтой харьцуулахад 2.5 нэгж хувиар өндөр үзүүлэлт юм. Ийнхүү Засгийн газрын өрийн түвшин нэмэгдэж байгаа нь Ковид-19 цар тахлын сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн

Дүрслэл 1.6 Монгол Улсын экспортын хэмжээ, голлох улсуудаар /сая ам.доллар, 2020 оны эхний 6 сарын байдлаар/




Эх сурвалж: Монголбанк.

Дүрслэл 1.7 Дэлхийн улс орнуудын Засгийн газрын өрийн өсөлт /улсуудаарх хувь оролцоо/



Эх сурвалж: ОУВС.

Дүрслэл 1.8 Зарим улсуудын бодлогын хүүний динамик (2020 оны 6 дугаар сарын байдлаар)



Эх сурвалж: Блүүмберг

төсвийн бодлогын орон зайг багасгаж байна (Дүрслэл 1.7).

Улс орнууд цар тахлын сөрөг нөлөөллийг хязгаарлах зорилгоор төсвийн бодлоготой зэрэгцүүлэн мөнгөний зөөлөн бодлогыг хэрэгжүүлж байна. Тухайлбал, дэлхийн томоохон орны төв банкууд бодлогын хүүгээ түүхэнд байгаагүй бага түвшинд хүргэн

бууруулж, мөн нээлттэй захын үйл ажиллагаагаар зах зээлийн хөрвөх чадварыг дэмжиж байна. Ийнхүү Ковид-19 цар тахлын тархалт, түүний эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг хязгаарлах хүрээнд хөгжингүй орнууд бодлогын хүүгээ түүхэн доод түвшинд хүргэн бууруулаад байгаа нь цаашид мөнгөний бодлогыг зөөлрүүлэх орон зайг хязгаарлаж байна (Дүрслэл 1.8).

1.2 ДЭЛХИЙН САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛ, ЭМЗЭГ БАЙДАЛ

Дэлхийн санхүүгийн нөхцөл² чангарч байна. Дэлхийн санхүүгийн нөхцөл 2019 оноос 2020 оны эхэн үе хүртэл суларч байсан бол Ковид-19 цар тахалтай холбоотойгоор энэ оны 3 дугаар сараас эхлэн огцом чангарч эхэллээ. Тодруулбал, хөгжингүй орнуудад хөрөнгийн үнэ унах, корпорацийн бондын зөрүү нэмэгдэх зэрэг үзүүлэлтүүд санхүүгийн нөхцөл чангарахад голлох нөлөө үзүүлсэн бол БНХАУ-аас бусад хөгжиж буй орнуудын хувьд гадаад санхүүжилтийн зардал огцом өсч байгаа нь санхүүгийн нөхцөл чангарахад голлон нөлөөлжээ. БНХАУ нь Ковид-19 цар тахлын тархалтад хамгийн эхэнд өртсөн орон боловч бусад улс орнуудтай харьцуулахад санхүүгийн нөхцөл тогтвортой үзүүлэлттэй байна.

Хөрөнгийн зах зээлийн хэлбэлзэл өндөр байна. 2020 оны 3 дугаар сараас эхлэн олон улсын санхүүгийн захын голлох индексүүд хэлбэлзэл өндөртэй байлаа. Тухайлбал, S&P 500 индекс түүхэн дэх хамгийн огцом уналт хийж, 16 арилжааны өдрийн хугацаанд 20

хувиар буурсан ч 2 дугаар улирлаас сэргэж эхлээд байна.

Хөрөнгө оруулагчид эрсдэлтэй хөрөнгөөс дайжиж, эрсдэлгүй, хөрвөх чадвар сайтай хөрөнгө рүү хошуурч байна. Дэлхийн санхүүгийн зах зээлд тодорхой бус нөхцөл байдал бүрэлдэж, 2020 оны 2, 3 дугаар сард зах зээлийн хэлбэлзэл нэмэгдсэн нь хөрөнгө оруулагчдыг эрсдэлгүй, хөрвөх чадвар сайтай хөрөнгө оруулалтууд руу чиглүүлж байна. Тухайлбал, хөгжингүй орнуудын Засгийн газрын бондын эрэлт нэмэгдэж, улмаар өгөөж буурах хандлагатай байхад хөгжиж буй орнуудын бондын хүү өсч байна.

² Санхүүгийн нөхцөл нь санхүүгийн эх үүсвэр (funding)-ийн олдоц болон зардал хэр зэрэг байгааг илтгэх гол үзүүлэлт юм. Санхүүгийн нөхцөл чангарснаар олон


улсын санхүүгийн зах зээл дээрээс санхүүгийн эх үүсвэр татахад хүндрэлтэй, санхүүжилтийн өртөг өндөр болно.

2020 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар АНУ, Англи, Герман зэрэг улсуудын засгийн газрын бондын өгөөж өмнөх оны эцсээс харгалзан 1.26 нэгж хувиар, 0.65 нэгж хувиар, 0.27 нэгж хувиар тус тус буурчээ. Мөн ойрын жилүүдэд хөгжингүй орнуудын бондын өгөөж 0-1 хувийн түвшинд хадгалагдах хүлээлттэй байна. Түүнчлэн “Санхүүгийн системийн эрсдэлийн зураглал”-аас үзэхэд Чингис бондын өгөөж болон АНУ-ын Засгийн газрын бондын өгөөжийн зөрүү нэмэгдэж, гадаад секторын эмзэг байдлыг нэмэгдүүлжээ (Дүрслэл 1.3).

Хөгжиж буй улсуудаас хөрөнгийн урсгал ихээр гадагшилж байна. Оршин суугч бусын хөрөнгө оруулалт нь хөгжиж буй улсуудын хувьд санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх, санхүүжилтийн зардлыг бууруулах, улмаар эдийн засгийн өсөлтөд чухал нөлөө үзүүлдэг. Гэсэн хэдий ч улс орнуудын хооронд өрнөх худалдааны дайн, геополитикийн сөрөг үйл явдлууд, дэлхийн хэмжээний цар тахал зэрэг хүчин зүйлсээс шалтгаалан дэлхийн эдийн засагт тодорхой бус байдал үүсэх нь хөгжиж буй улсуудаас гэнэт хөрөнгө гадагшлах урсгалыг бий болгож, санхүүгийн системд эрсдэл учруулдаг. Тухайлбал, Ковид-19 цар тахалтай холбоотойгоор дэлхийн эдийн засагт үүсч буй тодорхой бус нөхцөл байдлын улмаас хөгжиж буй улсуудад хөрөнгийн гадагшлах урсгал давамгайлж буй бөгөөд 2020 оны оны 3 дугаар сарын байдлаар 100 тэрбум ам.долларын хөрөнгийн гадагшлах урсгал бий болсон нь түүхэн дэх хамгийн өндөр үзүүлэлт юм.


Түүнчлэн 2008 оны дэлхийн санхүү эдийн засгийн хямралын үед хөгжиж буй улсуудын

Дүрслэл 1.9 Санхүүгийн нөхцөлийн индекс




Эх сурвалж: ОУВС.

Дүрслэл 1.10 Хөрөнгийн захын индекс



Эх сурвалж: Блүүмберг.

Дүрслэл 1.11 Хөрөнгийн зах зээлийн хэлбэлзлийн индекс (VIX)



Эх сурвалж: Блүүмберг.


хөрөнгийн гадагшлах урсгалын 28 хоногийн гулсах дундаж утга хамгийн ихдээ 0.8 тэрбум ам.долларт хүрч байсан бол 2020 оны 3 дугаар сарын 23-ны өдөр 4.1 тэрбум ам.долларт хүрч огцом нэмэгдсэн байна.

Хөрөнгийн гадагшлах урсгал нэмэгдсэнтэй холбоотойгоор хөгжиж буй орнуудын валютын ханш суларч байна.

2020 оны эхний хагас жилийн байдлаар зарим хөгжиж буй орны үндэсний мөнгөн тэмдэгтийн ам.доллартай харьцах ханш ихээхэн суларсан байна. Тухайлбал, эрдэс бүтээгдэхүүн экспортлогч Бразил, Мексик, Өмнөд Африк зэрэг улсуудын валютын ханш ам.долларын эсрэг огцом сулрав (Дүрслэл 1.15).


Санхүүгийн нөхцөлийн чангаралт цаашид үргэлжилбэл Монгол Улсын эдийн засаг, санхүүгийн салбарт сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна. Санхүүгийн нөхцөл чангарч, хөрөнгө оруулагчид эрсдэлтэй хөрөнгөөс эрсдэлгүй, хөрвөх чадвар сайтай хөрөнгө рүү дайжиж байгаа нь эрсдэлтэй хөрөнгүүдийн эрсдэлийн урамшууллын түвшин өсөхөд нөлөөлж байна.

Дүрслэл 1.12 Засгийн газрын бондын өгөөжийн түвшин




Эх сурвалж: Блүүмберг

Дүрслэл 1.13 Хөгжиж буй улсуудын хөрөнгийн урсгалын ДНБ-д эзлэх хувь (хуримтлагдсан дүнгээр)



Эх сурвалж: ОУВС.


Дүрслэл 1.14 Хөгжиж буй улсуудын хөрөнгийн урсгалын цэвэр дүн (28 хоногийн гулсах дундаж, тэрбум ам.доллар)



Эх сурвалж: ОУВС.

Монгол Улсын Засгийн газар 2021 онд Мазаалай 500 сая ам.доллар, 2022 онд Чингис 1,000 сая ам.доллар, 2023-2024 онд Гэрэгэ, Хуралдай төслүүдийн хүрээнд арилжаалсан 1,400 сая ам.долларын үнэт цаасны төлбөрүүдийг хөрөнгө оруулагчдад эргэн төлнө. Иймд ирэх жилүүдэд дэлхийн санхүүгийн нөхцөлийн чангаралт үргэлжилбэл дээрх өр төлбөрүүдийг дахин санхүүжүүлэх зардлыг нэмэгдүүлэх эрсдэлтэй юм. Мөн түүнчлэн уул уурхайн томоохон төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалтыг олон улсын санхүүгийн зах зээлээс татахад сөргөөр нөлөөлж болзошгүй байна.

Дүрслэл 1.15 Хөгжиж буй улсуудын валютын ханшийн өөрчлөлт



Эх сурвалж: Блүүмберг.

МОНГОЛ УЛСЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ЭРСДЭЛ, ЭМЗЭГ БАЙДАЛ

2

2.1 КОВИД-19 ЦАР ТАХЛЫН МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ

ТӨЛБӨРИЙН ТЭНЦЛИЙН СУВАГ

Монгол Улсын экспортын голлох түүхий эдүүд, металлын үнэ унав. Ковид-19 цар тахлын нөлөөгөөр дэлхийн эдийн засгийн төлөв улам хурдацтайгаар муудаж, ОПЕК-ийн орнуудын хэлэлцээр амжилтгүй болсон нь түүхий эд, металлын үнийн бууралтад голлох нөлөөг үзүүлэв.

2020 оны 2 дугаар улиралд суурь металлын³ үнэ 17 орчим хувиар, түүхийн нефтийн үнэ 40 орчим хувиар уналаа. Тухайлбал зэс болон төмрийн хүдрийн дундаж үнэ 6 дугаар сард харгалзан 5,754; 105.59 ам.долларт хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад зэс 2.1 хувиар буурсан бол төмрийн хүдэр 3 хувиар өссөн байна. Чулуун нүүрсний экспортын


хилийн үнэ 2020 оны 6 дугаар сард 54 ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 9 хувиар

буурсан бол 3 дугаар улирлаас эхлэн голлох түүхий эдийн үнэ өсч эхлээд байна.

Харин эрсдэлээс зугтаах үзэгдлээс шалтгаалан алтны үнэ 2020 оны 2 дугаар улиралд огцом өслөө. Дэлхийн зах зээл дээрх 1 унц алтны дундаж үнэ 2020 оны 2 дугаар улирлын эцсийн байдлаар 1,780 ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 22 хувиар өссөн байна.


Энэ онд дэлхийн эдийн засгийн өсөлтийн төлөв саарч, түүхий эдийн эрэлт буурах хандлагатай тул зэс, төмрийн хүдэр, газрын

Дүрслэл 2.1 Голлох түүхий эдийн үнийн индекс (2014.03.31=100)



Эх сурвалж: Блүүмберг

Дүрслэл 2.2 Худалдааны нөхцөл, экспорт, импортын үнийн өөрчлөлт



Эх сурвалж: Блүүмберг


³ Үүнд төмрийн хүдэр, зэс, хөнгөн цагаан, никел зэрэг металлууд орно.

тосны үнийн төсөөлөл буурч, алтны үнэ нэмэгдэх хандлагатай байна.

Экспортын үнийн индекс 2020 оны 6 дугаар сарын байдлаар 17 хувиар буурсан бол импортын үнийн индекс 23 хувиар тус тус буурсанаас шалтгаалж гадаад худалдааны нөхцөлийн индекс 2020 оны 6 дугаар сард өмнөх оны мөн үеэс 7 хувиар өсөхөд нөлөөлөв. Голлох экспортын түүхий эдийн үнийн төсөөлөл муудаж, цаашид буурах эрсдэл өндөр байгаа тул 2020 онд худалдааны нөхцөл сайжрахааргүй байна.


2020 оны 2-4 дүгээр сард нүүрс, газрын тосны экспорт тасалдав. Энэ оны эхний 6

Дүрслэл 2.3 Уул уурхайн экспорт, задаргаа (жил бүрийн эхний 6 сар)



Эх сурвалж: YCX.

Дүрслэл 2.5 Импортын хэмжээ, задаргаа (жил бүрийн эхний 6 сар)




Эх сурвалж: Монголбанк.

сарын гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 22.6 хувиар буюу 1,544.3 сая ам.доллараар буурч 5,288.5 сая ам.долларт хүрэв.

Экспорт 28.2 хувиар буюу 1,110.7 сая ам.доллараар буурсан нь голлон нөлөөлөв. Улмаар 2020 оны 6 дугаар сарын байдлаар худалдааны тэнцэл өмнөх оны мөн үеэс 677.0 сая ам.доллараар буурч 368.2 сая ам.долларын ашигтай гарлаа.


Экспортын өөрчлөлтийг шинжилбэл уул уурхайн бүтээгдэхүүний экспорт буурсан нь нийт экспортыг 21.8 нэгж хувиар бууруулах чиглэлд нөлөөлсөн байна. Тодруулбал,

Дүрслэл 2.4 Уул уурхайн экспорт, задаргаа (сарын дүнгээр)



Эх сурвалж: YCX.

Дүрслэл 2.6 Импортын хэмжээ, задаргаа (сарын дүнгээр)




Эх сурвалж: Монголбанк.

Ковид-19 цар тахлаас шалтгаалан БНХАУ-руу хийгдэх нүүрс, газрын тосны экспорт 2020 оны 2-4 дүгээр сард тасалдсан нь уул уурхайн экспортын хэмжээг ихээхэн бууруулав.

Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн, нефтийн бүтээгдэхүүний импорт агшсанаар нийт импорт буурав. Импорт 2020 оны эхний 6 сарын гүйцэтгэлээр өмнөх оны мөн үетэй харьцуулахад 15 хувиар буюу 434 сая ам.доллараар буурав. Импортын


бууралтыг ерөнхий ангиллаар задалж үзвэл хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний бууралт 7.9 нэгж хувийг, нефтийн бүтээгдэхүүний бууралт 4.5 нэгж хувийг, хэрэглээний бүтээгдэхүүний бууралт 2.8 нэгж хувийг тус тус бүрдүүлж байна. Нефтийн бүтээгдэхүүний импортын хилийн үнэ 2020 оны 6 дугаар сард өмнөх оны мөн үеэс 54 хувиар буурч тонн тутамд 310 ам.долларт хүрсэн нь томоохон нөлөө үзүүлжээ.

Дүрслэл 2.7 Хөрөнгийн урсгал (жил бүрийн I улирал)




Эх сурвалж: ҮСХ.

Дүрслэл 2.8 Санхүүгийн данс, задаргаа (улирлаар)⁴




Эх сурвалж: ҮСХ.

Дүрслэл 2.9 Төлбөрийн тэнцэл, сая ам.доллар (улирлаар)



Эх сурвалж: Монголбанк.

Дүрслэл 2.10 Хөрөнгийн урсгал



Эх сурвалж: Монголба

⁴ МУ-ын төлбөрийн тэнцлийн статистикийн 2020 оны 6 дугаар сарын урьдчилсан гүйцэтгэлийг ашиглав.

Хөрөнгийн дотогшлох урсгал саарав. Цар тахал эхэлснээс хойш хөгжиж буй эдийн засгуудын экспортын орлого унахын зэрэгцээ хөрөнгийн урсгал гадагшилж, үндэсний мөнгөн тэмдэгтийн ханш унах хандлага ажиглагдаж байна.

Монгол Улсын хувьд мөн хөрөнгийн урсгалыг илэрхийлэх үндсэн үзүүлэлт болох төлбөрийн тэнцлийн санхүүгийн дансны ашиг 2020 оны 1 дүгээр улиралд өмнөх оны мөн үеэс 237 сая ам.доллараар буурч, 320 сая ам.долларын ашигтай гарав. Үүнд цэвэр гадаадын шууд хөрөнгө оруулалтын дүн 115 сая ам.доллараар, бондын төлбөр тооцоог илэрхийлэх багцын хөрөнгө оруулалтын дүн 291 сая ам.доллараар буурсан нь голлон нөлөөлсөн байна. Санхүүгийн дансны тэнцлээр төлөөлүүлэн авч үзсэн хөрөнгийн цэвэр орох урсгалын дүн 2020 оны 1 дүгээр улиралд (улирлын) нэрлэсэн ДНБ-ий 11.9 хувьтай тэнцэж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс даруй 6.7 нэгж хувиар буурсан үзүүлэлт болж байна.

“Санхүүгийн системийн эрсдэлийн зураглал”-аас үзэхэд төлбөрийн тэнцэл муудаж, тодорхой бус байдал хэвээр байна. Урсгал ба хөрөнгийн данс 2020 оны 2 дугаар улиралд 32.4 сая ам.долларын


алдагдалтай, санхүүгийн данс 79 сая ам.долларын ашигтай, нийт төлбөрийн тэнцэл 329 сая ам.долларын алдагдалтай гарлаа. Энэ нь өнгөрсөн оны мөн үеэс 565 сая ам.доллараар муудсан боловч өмнөх улирлаас 21 сая ам.доллараар сайжирсан үзүүлэлт юм (Дүрслэл 2.11).

Энэхүү төлбөрийн тэнцлийн хүндрэл нь гадаад валютын ханшид дарамт үзүүлэх нөлөөтэй ба он гарснаас хойш 6 дугаар сарын байдлаар Монголбанк валютын захад цэвэр дүнгээр 1.9 тэрбум орчим ам.долларыг нийлүүлсэн байна. Улмаар энэ оны эхний 6 сарын байдлаар төгрөгийн ам. доллартай харьцах ханш 3.5 орчим хувиар суларсан нь бусад ижил төстэй хөгжиж буй орнуудтай харьцуулахад харьцангуй тогтвортой үзүүлэлт болж байна.

ОРЛОГЫН СУВАГ

Монгол Улсын нэгдсэн төсвийн орлого буурав. Эхний 6 сарын байдлаар тэнцвэржүүлсэн орлого 4'100 тэрбум төгрөг буюу 79.6 хувийн гүйцэтгэлтэй байсан нь өмнөх оны мөн үеэс 25.9 хувиар буурсан үзүүлэлт юм. Ийнхүү төсвийн орлого буурч байгаа нь төсвийн алдагдлыг нэмэгдүүлж, санхүүгийн системийн эмзэг байдлыг бий болгож байна (Дүрслэл 2.11).

Дүрслэл 2.11 Санхүүгийн системийн эрсдэлийн зураглал (Макро эдийн засгийн орчны задаргаа)



Ковид-19 цар тахал, түүнээс сэргийлэх хорио цээрийн арга хэмжээний нөлөөгөөр эдийн засгийн идэвхжил саарч, нүүрс, газрын тосны экспорт саатсан, барааны импортоос орох татварын орлого буурсан зэрэг нь орлого буурахад нөлөөлөв.

Хүснэгт 2.1: Төсвийн үзүүлэлтүүд

тэрбум төгрөг	2019	2019.1	2020	2020.06		2020.06/
	Гүй	Гүй.	Бат.	Гүй.	гүй. %	2019.06
Нийт орлого	11937	5549	12900	4359	78.2	78.6
Ирээдүй өв сан	1040	617	977	246	67.4	40.0
Тогтворжуулалтын сан	95	32	125	12	21.3	37.6
Тэнцвэржүүлсэн орлого	10802	4900	11798	4100	79.6	83.7
Татварын орлого	9749	4446	10656	3743	81.5	84.2
Татварын бус орлого	1053	454	1142	357	64.0	78.7
Нийт зардал	11429	4708	13873	6298	82.2	133.8
Анхдагч зардал	10568	4271	12913	5873	81.9	137.5
Урсгал зардал /хүүний зардал/	7347	3525	9060	4626	86.7	131.2
Хөрөнгийн зардал	2818	636	3806	1229	70.2	193.2
Цэвэр зээл	403	110	47	19	20.9	17.0
Хүүний зардал	861	437	960	425	87.6	97.4
Нийт тэнцвэржүүлсэн тэнцэл	-628	192	-2075	-2198		
ДНБ-д эзлэх хувь	-1.7%		-5.1%			
Анхдагч тэнцэл	233	629	-1115	-1773		
ДНБ-д эзлэх хувь	0.6%		-2.7%			

Эх сурвалж: Сангийн яам

Монгол Улсын төсвийн орлого буурсан нь Засгийн газрын хэрэглээ болон хөрөнгө оруулалт агшихад хүргэж байна. Улмаар хөрөнгө оруулалтын эдийн засгийн өсөлтөд оруулах хувь нэмэр буурахаар хүлээгдэж байна. Төсвийн зардлын гүйцэтгэл төлөвлөсөн дүнгээс бага байхад урсгал зардал 86.7 хувь, хөрөнгийн зардал 70.2 хувийн гүйцэтгэлтэй байсан нь нөлөөлөв.

ҮСХ-ны мэдээлснээр 2020 оны 1 дүгээр улиралд өрхийн сарын дундаж орлого өмнөх оны мөн үеэс өссөн байна. 2020 оны 1 дүгээр улирлын байдлаар өрхийн сарын бодит орлогын⁵ хэмжээ 1.2 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 12.6 хувиар, өмнөх улирлаас 6.6 хувиар өссөн аж. Уг өсөлтөд

мөнгөн орлого болох цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмж нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

Нөгөө талаас 2020 оны 2 дугаар улирлын “Инфляцийн хүлээлт”-ийн судалгаанд хамрагдсан иргэдийн 68 хувь нь цар тахлаас шалтгаалж орлого буурсан, 41 хувь нь цалин буурсан гэж хариулжээ. Ялангуяа бага орлоготой буюу 500.0 мянган төгрөг хүртэл орлоготой өрхүүдийн санхүүгийн байдал хамгийн их муудсан байна. Судалгаанаас харахад өрхүүдийн 53 хувь нь хэрэглээгээ бууруулсан байна.

Ковид-19 цар тахлын “цохилтод” уул уурхай болон нүүрсний тээвэрлэлт, агаарын тээвэр, аялал жуулчлал зэрэг үйлчилгээний салбарын ажиллагсад хамгийн ихээр өртсөн байна. ҮСХ-ны 2020 оны эхний хагас жилд өгсөн мэдээллээр ажилгүйдлийн даатгалын сан эхний 6 сарын байдлаар 10.6 мянган хүнд 26.1 тэрбум төгрөг олгосон нь өмнөх оны мөн үеийнхээс 6.9 тэрбум төгрөгөөр өссөн байна. Ажилгүйдлийн тэтгэмж авсан иргэдийн тоо өмнөх оны мөн үеэс 1.0 хувиар буурч, олгосон тэтгэмж 35.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Өрхийн санхүүгийн дарамт нэмэгдсэнтэй холбоотойгоор банкуудад зээлийн нөхцөлийг сулруулах, хугацааг хойшлуулах хүсэлт олноор ирэх болжээ. 2020 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн байдлаар нийт хэрэглээний зээлийн багцын 11 хувь буюу 56591 зээлдэгчийн 493.5 тэрбум төгрөгийн хэрэглээний зээлийн нөхцөлд өөрчлөлт орж хугацаа дунджаар 6.6 сараар сунгасан байна.

⁵ Цалин, тэтгэвэр, оюутны тэтгэлэг, үндсэн хөрөнгө түрээслүүлсний орлого, хадгаламжийн хүү, гэрээгээр ажил гүйцэтгэсний хөлс.

ААН-үүдийн орлого буурав. 2020 оны 2 дугаар улирлын “Инфляцийн хүлээлтийн тайлан”-гаас харахад Ковид-19 цар тахал нь ААН-үүдийн 45 хувьд нь маш ихээр, 28 хувьд нь дунд зэрэг, 15 хувьд нь бага зэрэг нөлөө үзүүлжээ. Аялал жуулчлал, боловсрол, зочид буудал, нийтийн хоол болон тээвэр агуулахын үйлчилгээний салбарт үйл ажиллагаа эрхэлж буй ААН-үүд цар тахлын нөлөөнд хамгийн их өртсөн байна. Харин хөдөө аж ахуй, эрүүл мэнд, үл хөдлөх хөрөнгө, барилга болон мэдээлэл харилцаа холбооны салбарын ААН-үүдийн үйл ажиллагаанд харьцангуй бага нөлөөлжээ.

Ашиг орлогын хувьд ААН-үүдийн 37 хувь нь “орлого 30 хувь ба түүнээс дээш хэмжээгээр буурна”, 32 хувь нь “30 хүртэлх хувиар буурна” гэж хариулсан байна. ААН-үүдийн 60 хувь нь хэвийн үйл ажиллагаанд шилжихэд 1 ба түүнээс дээш жил шаардлагатай хэмээн

хариулжээ. ААН-үүд ирэх 3 сарын хугацаанд эрэлт буурна гэсэн хүлээлттэй байна.

Аж үйлдвэрийн салбарын ААН-үүдийн борлуулсан бүтээгдэхүүн 2020 оны эхний 6 сард 7.1 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 30.3 хувиар буурсан байна. Үүний дотор уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын борлуулалт 39.0 хувиар, боловсруулах аж үйлдвэрийн салбарын

борлуулалт 15.6 хувиар тус тус буурсан байна. Уул уурхайн компаниудын борлуулсан бүтээгдэхүүн 39.0 хувиар буурахад нүүрс олборлолт 66.7 хувиар, металлын хүдэр олборлолт 15.3 хувиар тус тус буурсан нь голлон нөлөөлжээ.

Төмөр замын тээврийн орлого 2020 оны эхний 5 сард 8.8 хувиар өссөн бол агаарын үндэсний тээвэрлэгчдийн орлого 60.5 хувиар буурсан байна.

Хүснэгт 2.2: Компаниудын борлуулалтын орлого, жил бүрийн эхний 6 сарын байдлаар, тэрбум төгрөгөөр

Салбар	2018	2019	2020	2020/ 2019
	тэрбум төгрөг			хувь
Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний борлуулалт	8,658.9	10,154.4	7,073.7	69.7
Уул уурхай	5,998.8	7,081.0	4,318.7	61.0
Боловсруулах салбар	2,112.3	2,464.0	2,079.2	84.4
Цахилгаа, дулаан	547.9	609.5	675.8	110.9
Төмөр замын тээврийн орлого*	236.8	277.2	301.7	108.8
Агаарын тээврийн орлого*	138.6	158.5	62.6	39.5
Худалдаа*	7,818.1	9,719.5	8,638.1	89.3
Бөөний	3,894.7	4,976.4	4,562.7	91.7
Жижиглэнгийн	3,923.5	4,743.1	4,120.4	86.9


Эх сурвалж: УСХ.

Тэмдэглэл: Төмөр зөм, агаарын тээврийн орлого болон худалдааны статистик жил бүрийн эхний 5 сарыг хамарсан болно.

Дотоодын худалдааны салбарын борлуулалтын орлого 2020 оны эхний 5 сард 8.6 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 10.7 хувиар, үүний дотор бөөний худалдаа 8.3 хувиар, жижиглэн худалдаа 13.1 хувиар тус тус буурсан байна.

Цар тахлын улмаас дотоодод хөл хорио тогтоосонтой холбоотойгоор нийт эдийн засаг, ялангуяа уул уурхай болон түүнтэй

Дүрслэл 2.13 Санхүүгийн системийн эрсдэлийн зураглал (Мөнгөний үзүүлэлтийн задаргаа)




Эх сурвалж: Монголбанк

холбоотой бусад салбарын өсөлт буурсан. 2020 оны эхний улирлын байдлаар дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) 10.7 хувиар агшаад байна.

Санхүүгийн салбар

Ковид-19 цар тахалтай холбоотойгоор эргэн төлөлтийн хүндрэлд орчихсон байгаа хэрэглээний зээлийн хугацааг 12 хүртэлх сараар 1 удаа сунгах, иргэдийн ипотекийн хөнгөлөлттэй хүүтэй зээлийн эргэн төлөлтийг хойшлуулах шийдвэрийг гаргасан. Гэсэн хэдий ч хадгаламжийн байгууллагуудаас олгосон хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдлийн хэмжээ 2020 оны 6 дугаар сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 34.1 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Чанаргүй зээлийн түвшинд томоохон өөрчлөлт гараагүй ч 2020 оны 6 дугаар сарын байдлаар энэ оны эхний сарын үзүүлэлттэй харьцуулахад улсын байгууллагын чанаргүй зээл 13.8 хувиар буурч, иргэдийн чанаргүй зээл 29.2 хувиар өссөн байна.

Дүрслэл 2.12 Эдийн засгийн өсөлтийн задаргаа, салбарын ангиллаар



Эх сурвалж: УСХ.


Арилжааны банкуудын хүүгийн орлого 2020 оны 6 дугаар сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 21.9 хувиар буурчээ. Үүнд Ковид-19 цар тахлын санхүүгийн зах зээлд үзүүлж буй сөрөг нөлөө, 2020 оны 2 дугаар сард 677 тэрбум төгрөгийн тэтгэврийн зээл тэглэсэн, зээлийн эргэн төлөлтийн хүндрэлд орсон иргэд аж ахуйн нэгжийн зээлийн хугацааг сунгасан зэрэг хүчин зүйлс нөлөөлж байна.

ЗЭЭЛИЙН СУВАГ

Ковид-19 цар тахалтай холбоотойгоор эдийн засаг, санхүүгийн зах зээлд тодорхой бус байдал

үүсч байгаа тул банкуудын зээл олгох шалгуур⁶ бага зэрэг чангарсан байна. Цар тахлыг хязгаарлах зорилгоор Засгийн газрын зүгээс хэрэгжүүлж буй хориг арга хэмжээ нь эдийн засгийн зарим салбаруудад сөргөөр нөлөөлж, тухайн салбарт үйл ажиллагаа эрхэлж буй ААН, хөдөлмөр эрхлэгчдийн орлогыг бууруулах нөлөө үзүүлж байна. Орлогын бууралтын үргэлжлэх хугацаа, хөл хорио хэзээ тавигдах нь тодорхойгүй байгаа

Дүрслэл 2.14 Банкуудын нийт хүүгийн орлого, тэрбум төгрөгөөр



Эх сурвалж: Монголбанк.

⁶ Зээлийн шалгуур (Credit standards): Зээлдэгчийг зээлийн шаардлага хангах эсэхийг тодорхойлдог банкны дотоод журам, аргачлал.

нь 2020 оны эхний саруудад банкнаас ААН, иргэдэд олгох зээлийн шалгуурыг бага зэрэг чангаруулсан байна. Түүнчлэн ирэх сард ААН-үүд болон иргэдийн зээлийн шалгуурыг хэвэнд нь хадгалах хүлээлттэй байна.


Банкнаас шинээр олгосон зээлийн хэмжээ 2020 оны эхний 6 сард 9.4 их наяд төгрөгтэй тэнцэж, өнгөрсөн оны дүнтэй харьцуулахад 7.7 хувиар буурчээ. Зээлийн төлөвийн судалгааны үр дүнгээс үзэхэд банкуудын зээл олголт буурахад Ковид-19 цар тахалтай холбоотойгоор бизнесийн үйл ажиллагаа хумигдсан, эдийн засгийн идэвхжил буурсан зэрэг хүчин зүйлс голчлон нөлөөлжээ. Хэдийгээр ирэх сард банкууд зээлийн шалгуурыг өөрчлөх хүлээлтгүй байгаа ч зээлийн нөхцөлийг⁷ чангаруулах магадлалтай байна. Тухайлбал, Зээлийн төлөвийн судалгаанд зээлийн хэмжээ, хугацаа, барьцаа хөрөнгийн нөхцөлийг 2020 оны 7 дугаар сард бага зэрэг чангаруулна гэж банкууд үзэж байна. Энэ нь шинээр олгох

зээлийн хэмжээг бууруулах нөлөө үзүүлж болзошгүй юм.

“Санхүүгийн системийн эрсдэлийн зураглал”-аас үзэхэд зээлийн зардал буурч байгаа ч зээл олголт нэмэгдэхгүй байна (Дүрслэл 2.13). Тухайлбал, иргэдэд шинээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү 2019 оны эцсээс хойших хугацаанд тогтвортой буурч, 2020 оны 6 дугаар сарын байдлаар 17 хувь хүрсэн бол ААН-д олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү 15.9 хувьтай тэнцэж байна. Ингэснээр нийт зээлийн жигнэсэн дундаж хүү 2020 оны 6 дугаар сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 0.7 нэгж хувиар буурч, 16.3 хувьд хүрэв.


Зээлийн төлөвийн судалгааны үр дүнгээс үзэхэд 2020 оны 7 дугаар сард банкууд ААН-д олгох зээлийн хүүг бага зэрэг өсгөх, иргэдэд олгох зээлийн хүүг бага зэрэг бууруулах төлөвтэй байна.

Дүрслэл 2.15 Банкуудын шинээр олгосон зээлийн хэмжээ (тэрбум төгрөг)



Эх сурвалж: Монголбанк.

Дүрслэл 2.16 Шинээр олгосон төгрөгийн зээлийн хүү (хувь)




Эх сурвалж: Блүүмберг.

⁷ Зээлийн нөхцөл (Credit terms and conditions) Зээлдүүлэгч болон зээлдэгчийн харилцан тохиролцсон зээлийн дүн, хугацаа, хүү болон бусад нөхцөлийг ойлгоно.


Шигтгээ 1: Зээлийн төлөвийн түүвэр судалгааны үр дүн

ААН-үүдийн зээлийн шалгуурын индекс нь 2019 оны эцэст 0 буюу өөрчлөлтгүй байсан бол 2020 оны эхнээс бага зэрэг чангарсан төлөвт шилжээд байна. Харин сүүлийн судалгааны дүнгээр ирэх 1 сарын хугацаанд банкууд ААН-үүдийн зээлийн шалгуурыг өөрчлөх төлөвгүй гэж хариулсан байна (Дүрслэл 2.17).

Дүрслэл 2.17 ААН-д олгох зээлийн шалгуурын индекс




Дүрслэл 2.18 Иргэдэд олгох зээлийн шалгуурын индекс



Эх сурвалж: Монголбанк, Банкны зээлийн төлөвийн түүвэр судалгаа


Иргэдэд олгох зээлийн шалгуурын индекс 2020 оны 6 дугаар сарын байдлаар “бага зэрэг чангарх” интервалд хадгалагдаж байна. Түүнчлэн ирэх 1 сарын хугацаанд банкууд иргэдийн зээлийн шалгуурыг өөрчлөх төлөвгүй байна (Дүрслэл 2.18).

Дүрслэл 2.19 ААН-ийн зээлийн эрэлтийн төлөв



Эх сурвалж: Монголбанк, Банкны зээлийн төлөвийн түүвэр судалгаа

Дүрслэл 2.20 Иргэдийн зээлийн эрэлтийн төлөв



ААН-үүдийн зээлийн эрэлт сул бөгөөд цаашид ч буурахаар байна. Зээлийн эрэлтийн ерөнхий индексийн утга өмнөх оны эцэст хэвийн түвшинд байсан бол 2020 оны 6 дугаар сард -0.4-т хүрч, зээлийн эрэлт бага зэрэг буурсан төлөвт шилжлээ (Дүрслэл 2.19). Уул уурхай, Боловсруулах үйлдвэрлэлийн зээлийн эрэлт бусад салбаруудтай харьцуулахад их хэмжээгээр буурчээ. Банкуудын хүлээлтээс үзэхэд ирэх 1 сарын хугацаанд Уул уурхай, Боловсруулах, Барилгын салбарын зээлийн эрэлт муудахаар байна.

Иргэдийн зээлийн эрэлт буурах хүлээлттэй байна. Иргэдийн зээлийн эрэлт 2018 онд хэт ихээр өсч байсан боловч 2019 оноос эхлэн тогтворжсон байна. Зээлийн эрэлтийн төлөвийн индекс 2018 оноос хойш тогтвортой байсан хэдий ч 2020 он гарснаар бага зэрэг буурсан төлөвт шилжив. Мөн банкуудын хүлээлтээр ирэх сард иргэдийн зээлийн эрэлт бага зэрэг буурахаар байна.


2.2 КОВИД-19 ЦАР ТАХЛЫН МОНГОЛ УЛСЫН САНХҮҮГИЙН

САЛБАРТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ

БАНКНЫ САЛБАРЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Ковид-19 цар тахлын тархалтаас урьдчилан сэргийлэхтэй холбогдуулан Засгийн газраас авсан арга хэмжээний хүрээнд хил хааж, хорио цээрийн дэглэм тогтоосноор экспортын үйл ажиллагаа зогсонги байдалд орох, бөөний болон жижиглэн худалдааны нийлүүлэлт буурах, хүнсний бус худалдааны салбар, тээвэр, түрээс, үйлчилгээний салбарын орлого тасалдах зэрэг сөрөг үр дагаврууд гарч байна. Үүнтэй холбоотойгоор 2020 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн байдлаар нийт 129.2 мянган зээлдэгчийн 5.06 их наяд төгрөгийн зээлийн эргэн төлөлтөд хүндрэл үүсээд байна. Улмаар зээлдэгчдэд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах зорилгоор Монголбанкнаас зээлийн эргэн төлөлтийг хойшлуулах, зээлийн ангиллыг тодорхой хугацаанд бууруулахгүй байх арга хэмжээг авч хэрэгжүүлсэн бөгөөд 2020 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн байдлаар банкны системд 92.8 мянган зээлдэгчийн 2.6

Дүрслэл 2.21 Ковид-19-ийн нөлөөтэй зээлийн нийт зээлд эзлэх хэмжээ



Эх сурвалж: Монголбанк.


их наяд төгрөгийн зээлийн бүтцэд өөрчлөлт оржээ.

Том аж ахуйн нэгж (ААН)-үүдийн үйл ажиллагаа доголдож, зээл төлөх чадамж муудаж байна. Ковид-19 цар тахлын нөлөөнд өртсөн зээлүүдийн 53.7 хувийг том ААН-үүдийн, 36.9 хувийг иргэдийн, 8.4 хувийг жижиг, дунд ААН-үүдийн зээл тус тус бүрдүүлсэн байна.

Аж ахуйн нэгжүүдэд олгосон зээлийн эрсдэл.

2020 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн байдлаар банкны системийн нийт зээлийн 48.3 хувийг (8.6 их наяд төгрөг) ААН-д олгосон зээл бүрдүүлж байна. Үүнээс 36.6 хувь буюу 3.2 их наяд төгрөгийн зээл Ковид-19 цар тахалд өртжээ. Монголбанкны зүгээс зээлдэгчдэд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах зорилгоор зээлийн эргэн төлөлт доголдож буй бизнесийн зээлийн бүтцэд өөрчлөлт оруулсан тохиолдолд тухайн зээлийг түр хугацаанд анхаарал хандуулах болон

Дүрслэл 2.22 Ковид-19-ийн нөлөөтэй зээл (зээлдэгчийн төрлөөр)



Эх сурвалж: Монголбанк

чанаргүй ангилалд бүртгэхгүй байх, чанарын үнэлгээ хийхгүй байх зэрэг тодорхой зохицуулалтын арга хэмжээг холбогдох журмуудад түр хугацаагаар орууллаа. Эдгээр зохицуулалтын хүрээнд банкууд 1059 аж ахуйн нэгжийн 1.1 их наяд төгрөгийн зээлд бүтцийн өөрчлөлт хийжээ. Тус арга хэмжээтэй холбоотойгоор 296 тэрбум төгрөгийн зээлийн үндсэн болон хүүгийн төлбөр төлөгдөөгүй байна.

Ковид-19 цар тахалтай холбоотойгоор худалдааны салбарын үйл ажиллагаа бусад салбаруудтай харьцуулахад их хэмжээгээр хязгаарлагдаж байна. Үүнээс шалтгаалан тухайн салбарт үйл ажиллагаа явуулж буй ААН-үүдийн зээлийн эргэн төлөлтөд хүндрэл учирч байна (Дүрслэл 2.23).

Иргэдэд олгосон зээлийн эрсдэл. Банкны системийн зээлийн үлдэгдлийн 51.7 хувь буюу 9.3 их наяд төгрөгийн зээлийг иргэдэд олгосон зээл эзэлж байна. Энэ төрлийн зээлийн 20.7 хувь буюу 1.9 их наяд төгрөгийн зээл Ковид-19 цар тахлын нөлөөнд өртжээ. Монголбанк нь эдийн засгийн гадаад, дотоод орчинд учирч буй онцгой нөхцөл байдлыг харгалзан үзэж, санхүүгийн системд үүсч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх үүднээс иргэдийн хэрэглээний зээлийн эргэн төлөлтийг хойшлуулах, зээлийн ангиллыг тодорхой хугацаанд бууруулахгүй байх, чанарын үнэлгээ хийхгүй байх зэрэг тодорхой зохицуулалтын арга хэмжээг авч ажиллаж байна. Түүнчлэн, орон сууцны ипотекийн 8 эсхүл 5 хувийн хүүтэй зээл авсан иргэн зээлийн эргэн төлөлтийн хуваарьт өөрчлөлт оруулах хүсэлт гаргасан тохиолдолд зээлийн үндсэн болон хүүгийн

төлбөрийг нэг удаа 6 хүртэлх сараар хойшлуулж, тухайн хугацаагаар зээлийн эргэн төлөлтийн хуваарийг уртасгах боломжийг олгосон юм.


Дээрх зохицуулалтуудын хүрээнд 2020 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн байдлаар банкууд 91.7 мянган иргэдийн 1.4 их наяд төгрөгийн зээлд бүтцийн өөрчлөлт хийжээ. Тус арга хэмжээтэй холбоотойгоор 73 тэрбум төгрөгийн зээлийн үндсэн болон хүүгийн төлбөр төлөгдөөгүй байна.

Түүнчлэн, Ковид-19 цар тахлын нөлөөнд өртсөн зээлийн үлдэгдлийн 85.7 хувийг төгрөгийн зээл, 14.3 хувийг гадаад валютын зээл бүрдүүлж байна.

Банкны системийн зээлийн чанарын талаар. Банкны системийн зээлийн үлдэгдлийг 2020 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар авч үзэхэд нийт зээлийн багцын 83.1 хувь буюу 14.3 их наяд төгрөгийн зээл хэвийн ангилалд, 5.8 хувь буюу 1 их наяд төгрөгийн зээл анхаарал хандуулах ангилалд, 11.1 хувь буюу 1.9 их наяд төгрөгийн зээл чанаргүй ангилалд бүртгэгдсэн байна.


Банкны системийн зээлийн чанарыг эдийн засгийн салбараар нь авч үзвэл 2020 оны 6 дугаар сарын байдлаар уул уурхайн салбарын зээлийн үлдэгдлийн 61.5 хувь буюу 862.3 тэрбум төгрөгийн зээл хэвийн ангилалд, 8.7 хувь буюу 122.6 тэрбум төгрөгийн зээл анхаарал хандуулах ангилалд, 29.8 хувь буюу 417.7 тэрбум төгрөгийн зээл чанаргүй ангилалд бүртгэгдсэн байна. Боловсруулах салбарын зээлийн хувьд 68.9 хувь буюу 957.5 тэрбум төгрөгийн зээл хэвийн ангилалд, 4.1 хувь буюу 56.4 тэрбум төгрөгийн зээл анхаарал хандуулах ангилалд, 27.0 хувь буюу 375.0 тэрбум төгрөгийн зээл чанаргүй ангилалд бүртгэгдсэн байна.

Дүрслэл 2.23 Ковид-19-ийн нөлөөтэй бизнесийн зориулалттай зээл (зээлдэгчийн төрлөөр)




Эх сурвалж: Монголбанк

Дүрслэл 2.24 Ковид-19-ийн нөлөөтэй иргэдийн зээл (зээлдэгчийн төрлөөр)



Эх сурвалж: Монголбанк

Дүрслэл 2.25 Ковид-19-ийн нөлөөтэй зээл (валютын төрлөөр)



Эх сурвалж: Монголбанк

Бөөний болон жижиглэнгийн салбарын хувьд зээлийн үлдэгдлийн 89.3 хувь буюу 2.5 их наяд төгрөгийн зээл хэвийн ангилалд, 6.1 хувь буюу 174.2 тэрбум төгрөгийн зээл анхаарал хандуулах ангилалд, 4.6 хувь буюу 132.0 тэрбум төгрөгийн зээл чанаргүй ангилалд бүртгэгдсэн байна. Барилгын салбарын зээлийн үлдэгдлийн 71.4 хувь буюу 1.2 их наяд төгрөгийн зээл хэвийн ангилалд, 14.8 хувь буюу 252.0 тэрбум төгрөгийн зээл анхаарал хандуулах ангилалд, 13.8 хувь буюу 233.5 тэрбум төгрөгийн зээл чанаргүй ангилалд байна. Түүнчлэн, үл хөдлөх хөрөнгийн салбарын зээлийн 90.2 хувь буюу 1.9 их наяд төгрөгийн зээл хэвийн ангилалд, 2.2 хувь буюу 46.6 тэрбум төгрөгийн зээл анхаарал хандуулах ангилалд, 7.6 хувь буюу 157.1 тэрбум төгрөгийн зээл чанаргүй ангилалд бүртгэгдсэн байна.

Банкны салбарын эрсдэл, эмзэг байдал.

Банкны салбарын зээлийн үлдэгдэл нь хэрэглээ, худалдаа, барилга, үл хөдлөх

Дүрслэл 2.26 Зээлийн чанарын мэдээлэл




Эх сурвалж: Монголбанк.

хөрөнгө, уул уурхай, боловсруулах үйлдвэрийн салбарт төвлөрсөн буюу эдгээр салбаруудад илүү **мэдрэмтгий** байна.

Харин хөдөө аж ахуй, тээвэр ба агуулах эрхлэх үйл ажиллагаа, үйлчилгээний салбарт тус тус **бага мэдрэмтгий** байна.

Мөн боловсрол, мэдээлэл технологи, эрүүл мэнд, санхүү болон даатгал, төрийн үйлчилгээний салбарт **мэдрэмтгий** бус байна (Дүрслэл 2.28).

Дүрслэл 2.27. Чанаргүй зээлийн хувь (Эдийн засгийн салбаруудаар)



Эх сурвалж: Монголбанк


БАНКНЫ САЛБАРЫН БУСАД ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Банкуудын төлбөр түргэн гүйцэтгэх чадвар. Банкуудын төлбөр түргэн гүйцэтгэх чадварт Ковид-19 цар тахал сөрөг нөлөө үзүүлж байгаа ч харьцангуй тогтвортой түвшинд байна (Дүрслэл 2.31). Банкуудын төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцааны үзүүлэлт 2020 оны 6 дугаар сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 1.1 нэгж хувиар буурч, 40.6 хувь байна. Гэсэн хэдий ч тус үзүүлэлт нь Монголбанкнаас тогтоосон доод хязгаараас 15 нэгж хувиар өндөр байна. Цаашид шинэ төрлийн корона вирусын тархалт үргэлжлэх хугацаа уртсах тохиолдолд банкны системийн зохистой харьцааны үзүүлэлтүүдэд сөргөөр нөлөөлөх бөгөөд банкны салбарын ашигт ажиллагаа муудах, өөрийн хөрөнгийн хүрэлцээ багасах, хөрвөх чадвар муудах эрсдэлтэй байна.

2020 оны 6 дугаар сарын байдлаар банкны салбар нь 61.3 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан байна⁸. Ашигт ажиллагааны үзүүлэлт болох активын өгөөж 6 дугаар сарын байдлаар -0.4 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 1.0 нэгж хувиар буурчээ. Тайлант хугацаанд сангийн зардал өссөн нь ашигт ажиллагаа огцом буурахад нөлөөлөв.

Түүнчлэн банкны системийн өөрийн хөрөнгө, ашигт ажиллагааны үзүүлэлтүүд түүхэн дунджаас бага зэрэг буурсан үзүүлэлттэй байна. Банкны салбарын эрсдэл даах чадварыг харуулдаг үзүүлэлтийг

Дүрслэл 2.28. Зээл олголт салбараар




Эх сурвалж: Монголбанк

Дүрслэл 2.29. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа



Эх сурвалж: Монголбанк

Дүрслэл 2.30. Ашигт ажиллагаа⁷



Эх сурвалж: Монголбанк.

⁸ Хяналт шалгалтын зорилгоор тохируулгын гүйлгээ хийгдсэн тоон мэдээлэл болно.

авч үзэхэд 2020 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар нийт өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 15.6 хувь байгаа нь Монголбанкнаас тогтоосон шалгуур үзүүлэлтээс 3.6 нэгж хувиар өндөр байна (Дүрслэл 2.32).


Зээлийн эрсдэлийн сангийн хүрэлцээ.

Банкны системийн зээлийн эрсдэлийн сангийн хэмжээ 2020 оны 6 дугаар сарын байдлаар 1.43 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 139.87 тэрбум төгрөгөөр өслөө. Ингэснээр эрсдэлийн сангийн хүрэлцээ 8.3 хувьтай тэнцэж байна.

Гадаад валютын позицын үзүүлэлт. Банк нь гадаад валютын нээлттэй позиц, өөрийн хөрөнгийн харьцааг нийт валютын хувьд +/- 30 хувийн дотор тус тус барьж байх шаардлагатай байдаг. 2020 оны 6 дугаар сарын байдлаар банкны салбарын гадаад валютын зохистой харьцааны үзүүлэлт нийт валютын хувьд 9.0 хувь байгаа нь Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж байна.

Банкны системд хийсэн стресс тестийн талаар. Ковид-19-ийн нөхцөл байдлын хүрээнд банкны системийн зээл олголт болон зээлийн эргэн төлөлт буурах буюу хойшлогдох хандлага гарч байна. Иймд зээл олголт болон эргэн төлөлтийг харилцан хамааралтайгаар бууруулах, зээлийн хүүгийн орлого тасалдах буюу хойшлогдох, Ковид19-т өртсөн зарим зээлдэгчийн хувьд цаашид үйл ажиллагаа явуулах боломжгүй болох буюу эрсдэлийн сангийн зардлыг тодорхой хувиар нэмэгдүүлэх зэрэг сценариудын дагуу стресс тестийн шинжилгээ хийв. **Тус стресс тестийн үр дүнд банкны системийн хэмжээнд өөрийн хөрөнгийн хүрэлцээ болон төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт алдагдахааргүй байна. Гэсэн хэдий ч банкуудын ашигт ажиллагаа буурч, алдагдалтай ажиллах, зээл олголт багасч, санхүүгийн салбар болон бодит сектор хоорондын харилцан уялдаа буурч, улмаар эдийн засгийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх үр дүн гарч байна.**

Дүрслэл 2.31 Санхүүгийн системийн эрсдэлийн зураглал
(Банкны системийн хөрвөх чадварын үзүүлэлтүүд)



Дүрслэл 2.32 Санхүүгийн системийн эрсдэлийн зураглал
(Банкны системийн өөрийн хөрөнгө, ашигт ажиллагааны үзүүлэлтүүд)



Эх сурвалж: Монголбанк

Шигтгээ 2: Санхүүгийн системийн эрсдэлийн зураглал

Бусад улсуудын туршлагаас үзэхэд санхүүгийн системийн шинжилгээнд “Санхүүгийн тогтвортой байдлын эрсдэлийн зураглал”⁹-ыг түгээмэл ашиглаж байна. Тус аргачлал нь санхүүгийн системийн эмзэг байдлын талаарх ерөнхий дүр зургийг харуулах бөгөөд бодлого боловсруулагч болон зах зээлд оролцогчдод эрсдэлийн чиг хандлагыг тодорхойлоход дэмжлэг үзүүлдэг.

Шинжилгээний эхний алхам нь тухайн улсын эдийн засаг, санхүүгийн зах зээлийн онцлогт тохирсон хувьсагчдыг сонгох юм. Улмаар сонгон авсан хувьсагчдыг An & Choi (2018)-ийн стандартчилах аргыг ашиглан 0-1 хооронд орших утгуудад хувиргах бөгөөд энэ нь хувьсагчдыг бүлэглэх үйлдлийг хялбаршуулдаг.

$$z_t = (x_t - \bar{x})/\sigma_x \quad \text{Тэгшитгэл (1)}$$

x_t – сонгон авсан хувьсагч


$\bar{x}$ – арифметик дундаж

σ_x – стандарт алдаа

Гарсан үр дүнг дараах томъёогоор 0-ээс 1 хооронд хэлбэлзэх үзүүлэлтүүдийг үүсгэнэ:

$$y_t = (z_t - \min(z_t))/(\max(z_t) - \min(z_t)) \quad \text{Тэгшитгэл (2)}$$


Үүний дараа ижил төстэй шинж чанараар хувьсагчдыг бүлэглэж, бүлэг тус бүрийн нэгдсэн индексийг тооцдог. Нэгдсэн индексийн босго утгыг McLaughlin et. Al (2018)-ийн аргачлалын дагуу буюу индекс тус бүрийн эмпирик тархалтаас тооцоолдог. Ингэснээр тоон цуваа шинэчлэгдэх бүрт босго утгууд өөрчлөгдөх юм. Түүнчлэн индексийн тоон цувааг эмзэг байдлын түвшингээр эрэмбэлж, эрсдэлийн хэмжээст зураглал руу хөрвүүлэх бөгөөд өнгө тус бүр нь нийт тархалтад тэнцүү хувь эзэлдэг.



Олон улсын туршлага, Монгол улсын санхүүгийн системийн онцлог, санхүүгийн хямралуудын үе дэх хариу үйлдлүүд болон тоон мэдээллийн хүртээмжтэй байдал зэргийг харгалзан үзэж нийт 38 үзүүлэлтийг тодорхойлж, эрсдэлийн зураглал байгуулав (Дүрслэл 2.33). Энэхүү зураглалыг тооцохдоо тухайн үзүүлэлт өндөр эрсдэлтэй тохиолдолд улаан өнгөөр, дундаж эрсдэлтэй тохиолдолд шар өнгөөр, бага эрсдэлтэй тохиолдолд хэвийн гэж үзэн ногоон өнгөөр тэмдэглэсэн болно.

⁹ Financial stability heatmap

Дүрслэл 2.33: Монгол Улсын санхүүгийн эрсдэлийн зураглал (2020 оны 5 дугаар сарын байдлаар, улирлаар)



- ДНБ-ний өсөлт түүхэн доод утгадаа хүрсэн нь “Макро эдийн засгийн эмзэг байдал”-ын дийлэнх хэсгийг бүрдүүлж байна. Үүнээс гадна төсвийн алдагдлын хэмжээ тус бүлгийн эмзэг байдлыг нэмэгдүүлэх нөлөөтэй байна.
- Ковид-19 цар тахлаас шалтгаалан БНХАУ-ын эдийн засагт үүсч буй хүндрэл болон экспортын агшилт, түүхий эдийн үнийн бууралт нь гадаад секторын эмзэг байдлын томоохон хэсгийг бүрдүүлж байна.
- Мөнгөний нийлүүлэлт болон зээлийн өсөлт буурч байгаа нь “Мөнгөний үзүүлэлтүүд”-ийн эмзэг байдлыг нэмэгдүүлэх нөлөө үзүүлжээ.
- “Банкны салбарын хөрвөх чадварын үзүүлэлтүүд” тогтвортой байна. Гэсэн хэдий ч банкуудын төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа буурч байгаа нь тус бүлгийн эмзэг байдлыг нэмэгдүүлж байна.
- Банкны секторын зээлийн чанар муудаж, ашигт ажиллагаа буурч байгаа нь тус салбарын эмзэг байдлын шалтгаан болж байна.
- “Хөрөнгийн зах зээл” бүлэг тогтвортой байгаа хэдий ч Топ 20 индексийн утга буурч байгаа нь тус бүлгийн эмзэг байдлыг нэмэгдүүлэх нөлөөтэй байна.
- “Монгол Улсын санхүүгийн эрсдэлийн зураглал”-аас үзэхэд нийт санхүүгийн системийн эмзэг байдал 2017-2019 онуудтай харьцуулахад нэмэгдсэн дүр зурагтай байна.

Банкнаас бусад санхүүгийн салбарт үзүүлэх нөлөөлөл

Хөрөнгийн зах зээлийн төлөв байдал.

Олон улсын зах зээл. Дэлхийн банкнаас гаргадаг “Дэлхийн эдийн засгийн төлөв байдал тайлан”-гийн 2020 оны 6 дугаар сарын дугаарт нийтлэгдсэнээр 2020 оны дэлхийн эдийн засгийн өсөлтийн таамаг буюу ДНБ-ийн төлөв байдал өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5.2 хувиар унана хэмээн тооцоологджээ. 1870 оноос хойш дэлхийн эдийн засаг нийт 14 удаа уналтад орсон бөгөөд 2020 онд тохиож буй бууралт нь Дэлхийн 2 дугаар дайнаас хойш тохиож буй хамгийн том уналт болж байна.

2007-2009 онд тохиож байсан санхүүгийн хямралтай харьцуулахад дэлхийн эдийн засаг илүү гүн гүнзгий хямралд өртөж байгаа ч олон улсын хөрөнгийн зах зээлийн томоохон индексүүд санхүүгийн хямралын үетэй харьцуулахад харьцангуй бага уналттай байна. Тухайлбал 2009 оны хямралын үеэр Шанхайн хөрөнгийн биржийн индекс 2007 оны эхэн үеэс хамгийн ихдээ 64.1 хувиар унасан бол 2020 оны 3

дугаар сард АНУ-ын хөрөнгийн биржүүд дээр арилжаалагддаг Dow Jones индекс оны эхэн үеэс хамгийн ихдээ 35.6 хувиар унасан байна. Дэлхийн томоохон индексүүд 2020 оны 3 дугаар сард 30 гаруй хувийн уналтыг үзүүлсэн ч 6 дугаар сарын сүүлийн байдлаар уналтын хурд саарч индексүүд цаашид өсөх хандлагатай байна.


Хүснэгт 2.3: Дэлхийн томоохон индексүүдийн уналтын хувь

Голлох индексүүд	2007-2009 оны Санхүүгийн хямрал /2008 оны эхэн үеэс/	3 дугаар сар /оны эхэн үеэс/	6 дугаар сарын 30 /оны эхэн үеэс/
S&P 500	54.4%	31.3%	4.0%
FTSE 100	39.5%	31.6%	18.2%
Dow Jones	45.6%	35.6%	9.6%
Nikkei	50.1%	28.7%	5.8%
Shanghai	64.1%	13.8%	2.1%
Hang Seng	55.0%	20.4%	13.3%

Эх сурвалж: Market Insider


Монгол Улсын хөрөнгийн зах зээл. Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн хувьд зах зээлийн үнэлгээ, Монголын хөрөнгийн биржийн ТОП 20, MSE А болон MSE Б индексүүд зэрэг зах зээлийн төлөв байдлыг илэрхийлэх голлох үзүүлэлтүүд оны 1 дүгээр улиралд аливаа эерэг болон сөрөг мэдээлэлд мэдрэг бус байж 4 дүгээр сард уналт үзүүлж эхэлсэн. Гэсэн хэдий ч “Санхүүгийн системийн эрсдэлийн зураглал”-аас үзэхэд үл хөдлөх хөрөнгө болон хөрөнгийн зах

Дүрслэл 2.34 Дэлхийн ДНБ-ий өсөлтийн таамаг



Эх сурвалж: Дэлхийн банк

Дүрслэл 2.35 Зах зээлийн үнэлгээ /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

зээлийн үзүүлэлтүүд тогтвортой түвшинд байна Дүрслэл (2.41). Зах зээлийн үнэлгээ 2020 оны эхэн үеэс 6 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар 9.5 хувиар буурч, ДНБ-тэй харьцуулахад 6.6 хувьтай тэнцэж байна.

2020 оны 5 дугаар сард зах зээлийн нийт арилжааны хэмжээ 4.5 тэрбум төгрөгтэй тэнцэж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 72 хувиар буурч, оны эхэн үетэй харьцуулахад 4.3 хувиар буурсан байна.


Олон улсын голлох индексүүд 2020 оны 3 дугаар сард хамгийн өндөр уналтыг үзүүлсэн бол Монгол Улсын хувьд 3 дугаар сарын эцэс хүртэл хувьцааны зах зээлийн төлөв байдлыг илэрхийлэх ТОП-20, MSE А болон MSE Б индексүүд харьцангуй тогтвортой байж, 4 дүгээр сарын сүүлээр уналттай байлаа. ТОП-20 индексийн хувьд 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар 2020 оны эхэн үеэс 16.5 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

MSE А болон MSE Б индексүүд 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар оны эхэн үеэс 15.6 болон 6.1 хувиар тус тус буурчээ.

ТОП 20 индексэд багтах уул, уурхай, аж үйлдвэр болон санхүүгийн зах зээлд үйл ажиллагаа явуулдаг ХК-уудын хувьцааны ханшийн өөрчлөлтийг доорх зураглалд харууллаа.

Зах зээлд тулгарч буй эрсдэл, түүний эсрэг хэрэгжүүлж буй арга хэмжээ. Монгол Улсын хөрөнгийн зах зээл дээрх компаниудын хувьцаа нь хувьцаа эзэмшигчдийн төвлөрөл өндөртэй, хоёрдогч зах зээлд арилжаалагддаг хувьцааны хэмжээ бага, зах зээлийн идэвх сул зэрэг шалтгааны улмаас зах зээл аливаа нөлөөнд мэдрэг бус байх хандлага ажиглагддаг. Тийм ч учраас корона

Дүрслэл 2.36 Зах зээлийн арилжаа /тэрбум төгрөг /




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Дүрслэл 2.37: ТОП 20 индекс



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Дүрслэл 2.38: MSE А индекс




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

вирусийн тархалт, хөл хорионы нөлөө олон улсын хөрөнгийн зах зээлд хамгийн хүчтэй нөлөө үзүүлж байх үе буюу 2020 оны 1 дүгээр улиралд манай улсын хөрөнгийн зах зээлийн үзүүлэлтүүд харьцангуй тогтвортой байсан бол 4 дүгээр сараас эхлэн голлох үзүүлэлтүүд буурч эхлээд байна.

Корона вирусийн халдвар, хөл хориог даган гадаад болон дотоод эдийн засгийн хүндрэлийн улмаас хувьцаат компаниудын үйл ажиллагаа, ашиг орлого доголдох томоохон эрсдэл хүлээгдэж байна. Мөн сүүлийн жилүүдэд сэргэлт ажиглагдаж эхлээд буй манай улсын хөрөнгийн зах зээлийн хувьд шинэ төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээний нийлүүлэлт чухал нөлөөтэй байдаг. Халдварт өвчин, эдийн засгийн хүндрэлийг даган бизнесийн орчинд эрсдэл үүсээд буй өнөө үед хөрөнгийн зах зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээний нийлүүлэлт хумигдах өндөр эрсдэл байгаа хэдий ч 2020 оны эхний хагас жилд шинэ төрлийн компанийн бонд болон үнэт цаас анхдагч зах зээлд амжилттай арилжаалагдлаа.

Дүрслэл 2.39: MSE Б индекс



Эх сурвалж: Дэлхийн банк

Халдварт өвчний тархалт, хорио цээрээс шалтгаалан хувьцаат компаниуд хувьцаа эзэмшигчдийн хурлаа хуралдуулах, ногдол ашиг тараах зэрэг хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхэд хүндрэл учирсан бөгөөд хувьцаат компаниуд нь хувьцаа эзэмшигчдийн хурлыг цахим хэрэгсэл ашиглан, онлайн орчинд хуралдуулж байна. Түүнчлэн Санхүүгийн зохицуулах хороо нь үйл ажиллагаандаа цахим шийдлийг нэвтрүүлэн, үнэт цаасны зах зээлд үйл ажиллагаа эрхлэх эрх олгох сургалтыг цахимаар зохион байгуулж, үнэт цаасны зах зээлд үйл ажиллагаа явуулах компаниудын хүсэлтийг цахимаар хүлээн авахаар ажиллаж байна.

Мөн цар тахлын үеэр дэд бүтцийн шинэчлэлтийг хийж, үнэт цаасны дараа төлбөр тооцооны T+2 горим, төлбөрийн эсрэг нийлүүлэлт зарчмыг 2020 оны 3 дугаар сарын 31-ний өдрөөр амжилттай нэвтрүүлсэн бөгөөд үүний үр дүнд гадаад, дотоод хөрөнгө оруулагчид манай хөрөнгийн зах зээлд оролцох идэвх нэмэгдэх, цаашид тус зах зээлийн хөрвөх

Дүрслэл 2.40: ТОП-20 д багтах зарим компаниудын хувьцааны ханшийн өөрчлөлт /оны эхэн үеэс 6 дугаар сарын 30-ны байдлаар/

Төвөн толгой	13.8% ↓	Мандал давтгал	23.1% ↓
Говь	29.3% ↓	Би ди сек	16.5% ↑
АПУ	11.0% ↓	Ард санхүүгийн нэгдэл	29.4% ↓
СҮҮ	7.4% ↓	МИК холдинг	13.3% ↓
ЛЭНД	23.3% ↓	Шарын гол	27.3% ↑
Монгол Базальт	17.5% ↓		

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

чадвар сайжрах эерэг үр дүнгүүд хүлээгдэж байна.

Даатгалын зах зээлийн төлөв

Олон улсын зах зээл. Дэлхийн эдийн засгийн уналт, түүнээс үүдэлтэй хүүгийн түвшний бууралт нь даатгалын компаниуд тэр дундаа урт хугацаат даатгалын бүтээгдэхүүн зах зээлд нийлүүлдэг компаниудын үйл ажиллагааны тогтвортой байдал, төлбөрийн чадварт сөргөөр нөлөөлж байна.

Корона вирусийн тархалт, хөл хорио нь даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээний эрэлт буурах, даатгалын компаниуд хөрвөх чадвар болон төлбөрийн чадварын эрсдэлд өртөх, нөхөн төлбөрийн зардал нэмэгдэх зэрэг сувгуудаар даатгалын зах зээлд сөрөг нөлөө үзүүлж байгаа хэдий ч даатгалын салбар нь түр зуурын уналт, гэнэтийн эрсдэлийг хаах чадамжтай хэвээр байна гэж судлаачид тооцоолжээ. Гэсэн хэдий ч корона вирусийн үргэлжлэх хугацаа тодорхой бус байгаагаас шалтгаалан урт хугацаанд даатгалын салбарын хөрөнгө, өр төлбөрийн үзүүлэлтүүд хэрхэн өөрчлөгдөх нь тодорхой бус байна.

Зах зээлийн уг тодорхой бус байдлыг даган улс орнуудын бодлого гаргагчид гэнэтийн эрсдэлд бэлэн байх, хөрөнгийн чадавхаа хадгалах зорилгоор ногдол ашгийн хуваарилалт, хувьцааны худалдан авалтыг хойшлуулах, үйл ажиллагааны бодлогодоо анхаарал хандуулан тэвчиж болох зардлыг тодорхойлон хэмнэлтийн горимд шилжин нөөц сангаа нэмэгдүүлэхийг даатгалын компаниудад зөвлөж байна.

Түүнчлэн дэлхийн олон улс оронд даатгалын компаниуд бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжих, эрсдэл өндөртэй хүн

амын бүлэгт чиглэсэн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрүүлэх зэргээр цар тахалтай тэмцэхэд хувь нэмэр оруулан нийгмийн хариуцлагын бодлого хэрэгжүүлж буй сайн туршлага олон байна. Тухайлбал БНХАУ, Сингапур, Хонг Конг, Итали зэрэг улсын зарим төрлийн даатгалын компаниуд корона вирусийн эмчилгээний зардлыг нөхөн төлөх заалтыг эрүүл мэндийн даатгалынхаа гэрээнд нэмэлтээр тусгах замаар халдварт өвчний эрсдэлээс хэрэглэгчдээ хамгаалж байна.

Монгол Улсын даатгалын зах зээл.

Даатгалын салбарын хөгжлийн гол хэмжүүр болох даатгалын гүнзгийрэлт буюу ДНБ-д эзлэх хураамжийн орлогын хувь хэмжээ манай улсын хувьд олон улсын түвшинтэй харьцуулахад нэлээдгүй доогуур байдаг.

2020 оны 1 дүгээр улиралд даатгалын гүнзгийрэлт 0.44 хувьд хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.01 хувиар буурсан байна. Харин салбарын нийт хөрөнгийн хэмжээ тайлант улиралд өмнөх оны мөн үеэс 6.8 хувиар өсөж, өмнөх улирлаас 4.3 хувиар буурч 350 тэрбум төгрөгт хүрлээ.

Ердийн даатгалын компаниудын нийт хөрөнгийн жилийн өсөлт бусад даатгалын төрөлтэй харьцуулахад 15.1 хувиар өсөж 286.4 тэрбум төгрөгт хүрч, салбарын нийт хөрөнгийн 81.8 хувийг эзэлж байна.

Давхар даатгалын компаниудын нийт хөрөнгө өмнөх оны мөн үетэй харьцуулахад 22.4 хувиар буурч, 54.1 тэрбум төгрөгт хүрсэн нь салбарын нийт хөрөнгийн 15.5 хувийг эзэлж байна. 2020 оны 1 дүгээр улирлаас давхар даатгалын үйл ажиллагаа эрхлэх 1 тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосонтой

холбоотойгоор нийт хөрөнгийн өсөлт өмнөх үетэй харьцуулахад буурсан байна.


Урт хугацааны даатгалын компанийн нийт хөрөнгийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 3.5 хувиар өсөж, 9.4 тэрбум төгрөгт хүрч, салбарын 2.7 хувийг эзэлж байна.

Ердийн болон урт хугацааны даатгалын компаниуд 2020 оны 1 дүгээр улиралд нийт 40.7 тэрбум төгрөгийн даатгалын хураамжийг төвлөрүүлжээ. Үүнээс: ердийн даатгалын компаниуд 40.3 тэрбум төгрөг буюу 99.1 хувь, урт хугацааны даатгалын компани 0.4 тэрбум төгрөг буюу 0.9 хувийг бүрдүүлжээ.

Даатгалын компаниудын нийт нөхөн төлбөрийн зардал 2020 оны 1 дүгээр улиралд 15.6 тэрбум төгрөгт хүрч, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нөхөн төлбөрийн зардал 24.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Үүнээс ердийн даатгалын компаниудын нөхөн төлбөр 99.1 хувийг бүрдүүлжээ.


Тайлант хугацаанд давхар даатгагчийн хариуцсан нөхөн төлбөрийн хэмжээ 2.9 дахин өсөж 1.3 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Дүрслэл 2.42 Даатгалын гүнзгийрэлтийн түвшин




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Дүрслэл 2.43 Даатгалын салбарын нийт хөрөнгө /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Дүрслэл 2.44 Даатгалын салбарын нийт хураамж /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо


Тайлант улиралд ердийн даатгалын компаниудын нийт нөөц сангийн хэмжээ өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 13.5 хувиар өсөж 129.3 тэрбум төгрөг, урт хугацааны даатгалын компанийн нөөц сан 12.4 хувиар өсөж 2.4 тэрбум төгрөг, давхар даатгалын компанийн нөөц сан 1.6 хувиар өсөж 26.1 тэрбум төгрөг болов.

Хохирол нөхөлтийн харьцаа тайлант улиралд өнгөрсөн онтой харьцуулахад 5.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Хохирол нөхөлтийн харьцааг нөхөн төлбөрийн зардлыг орлогод тооцсон хураамжийн орлогод харьцуулан тооцдог бөгөөд нөхөн төлбөрийн зардлын өсөлт хураамжийн орлогын өсөлтөөс давсан нь уг харьцаа өсөхөд нөлөөлжээ.

Харин зардлын харьцаа өмнөх оны мөн үеэс 6.4 нэгжээр буурч 41.5 хувь болсон бол цэвэр ахиуц ашгийн харьцаа тайлант улиралд 3.5 нэгжээр буурч 11.0 хувьд хүрлээ.


Даатгалын компаниудын хувьд корона вирусийн өвчлөл, хөл хорионы энэ үед зардал талаас санхүүгийн даатгал, итгэлцлийн даатгал, эрүүл мэндийн даатгал зэрэг бүтээгдэхүүн, үйлчилгээний нөхөн төлбөрийн зардал тооцооллоос давах, орлого талаас гадаадад зорчигчдын даатгал, нийтийн зорчигч тээврийн даатгал, ачаа тээврийн даатгалын бүтээгдэхүүний борлуулалт бууран хураамжийн орлого буурах хамгийн өндөр эрсдэлтэй бүтээгдэхүүнүүд юм.

Дүрслэл 2.45 Даатгалын салбарын нийт нөхөн төлбөр /тэрбум төгрөг/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Дүрслэл 2.46 Даатгалын салбарын нийт нөөц сан /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Дүрслэл 2.47 Даатгалын салбарын голлох харьцаа




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Статистик мэдээллээс харахад тайлант хугацаанд дээрх бүтээгдэхүүн, үйлчилгээний хувьд хураамжийн орлого болон нөхөн төлбөрийн зардалд мэдэгдэхүйц өөрчлөлт гараагүй байна.

Зах зээлд тулгарч буй эрсдэл, түүний эсрэг хэрэгжүүлж буй арга хэмжээ. Корона вирусыг дагасан эдийн засгийн хүндрэлийн улмаас бизнесийн байгууллагуудын орлого буурах, иргэн, аж ахуй нэгж хэмнэлтийн горимд шилжих хандлага ажиглагдаж байна.

Даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээг төдийлөн ашиглаж хэвшээгүй манай улсын зах зээлийн хувьд даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээ нь хэмнэж болох зардал болж буй бөгөөд үүний үр дүнд даатгалын хураамжийн орлогын өсөлт саарах эрсдэл хүлээгдэж байна. Хэдийгээр 2020 оны 1 дүгээр улирлын байдлаар салбарын хураамжийн орлогын хэмжээ өсөлттэй байгаа хэдий ч нөхцөл байдал удаан үргэлжилбэл бүтээгдэхүүн, үйлчилгээний эрэлтэд сөргөөр нөлөөлж болзошгүй. Тухайлбал тайлант улиралд нийт

Дүрслэл 2.48 Даатгалын хураамжийн орлогын өсөлт, бүтээгдэхүүнээр



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

0.3 сая даатгалын гэрээ байгуулагдсан нь өмнөх оноос 32.5 мянгаар буурсан дүн юм.

Нийт байгуулагдсан даатгалын гэрээний 83.6 хувь нь буюу 274,788 хувь хүнтэй байгуулсан даатгалын гэрээ 16.4 хувь буюу 53,933 хуулийн этгээдтэй байгуулсан даатгалын гэрээ байна.

Даатгалын бүтээгдэхүүний хураамжийн орлого тасалдан, нөхөн төлбөрийн зардал давах, улмаар нөөц сангийн хэмжээ багасах зэрэг эрсдэлээс гадна манай улсын даатгалын компаниудын хувьд валютын ханшийн эрсдэлд өртөх магадлал өндөр.

Даатгалын компаниудын дийлэнх нь гадаад улсад давхар даатгуулдаг бөгөөд сүүлийн гурван жилийн хугацаанд жилд дунджаар 50 гаруй тэрбум төгрөгийг гадаадын давхар даатгалын үйлчилгээнд зарцуулсан нь салбарын нийт хураамжийн 32.1 хувьтай тэнцэж байна. Тийм учраас төгрөгийн ам.доллартой харьцах ханшийн сулрал нь даатгалын компаниудын хувьд төлбөрийн дарамтыг бий болгодог.

Дүрслэл 2.49 Даатгалын нөхөн төлбөрийн зардлын өсөлт, бүтээгдэхүүнээр



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо


Тайлант улиралд даатгалын компаниудын нийт хөрөнгийн 60.6 хувийг хөрөнгө оруулалт, үүний 87.8 хувийг хадгаламж, хадгаламжийн сертификат хэлбэрээр хийсэн хөрөнгө оруулалт бүрдүүлж байна. Хадгаламж, хадгаламжийн сертификат болон үнэт цаасаарх хөрөнгө оруулалтаас даатгалын компаниуд 2020 оны 1 дүгээр

улиралд нийт 5.8 тэрбум төгрөгийн хүүгийн орлого олсон нь даатгалын орлогын дүнгийн 31.8 хувийг эзэлжээ. Үүнийг задлан үзвэл ердийн даатгалын компаниудын хувьд хүүгийн орлого нь нийт даатгалын орлогын 24.9 хувь, урт хугацааны даатгалын компанийн 64.6 хувь, давхар даатгалын компанийн 99.1 хувийг бүрдүүлсэн байна.

Эндээс дүгнэхэд урт хугацааны болон давхар даатгалын компанийн хувьд орлогын дийлэнх хувь нь хүүгийн түвшнээс, өөрөөр хэлбэл хөрөнгө оруулалтын хүүгийн орлогоос хамааралтай болох нь харагдаж байна. Гэхдээ манай улсын хувьд хүүгийн түвшин харьцангуй өндөр, хэлбэлзэл бага тул одоогийн байдлаар хүлээгдэж буй эрсдэлийн түвшин доогуур байна.


Хэдийгээр корона вирусийн тархалт, хорио цээр нь даатгалын салбарт төдийлөн сөрөг нөлөө үзүүлээгүй ч эдийн засаг, санхүүгийн зах зээлд тодорхой бус байдал үүсээд буй өнөө үед Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх зорилгоор иргэдэд даатгалын салбарын ач холбогдлыг таниулах, сурталчлах ажиллагааг эрчимжүүлэн, ипотекийн зээлдэгчийн урт хугацааны даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэх чиглэлд анхааран даатгалын бүртгэл, зөвшөөрлийн үйл ажиллагаа,

Дүрслэл 2.50 Давхар даатгалын хураамж /тэрбум төгрөг/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Дүрслэл 2.51 Даатгалын нийт хөрөнгө оруулалт /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Дүрслэл 2.52 Чанаргүй активын эзлэх хувь



Эх сурвалж: S&P Global

даатгалын мэргэжлийн оролцогчдод эрх олгох сургалтыг цахим хэлбэрт шилжүүлэн ажиллаж байна.

Мөн салбарын оролцогчид даатгалын гэрээ байгуулах, даатгуулагчдад нөхөн төлбөр олгох зэрэг үйл ажиллагаандаа технологийн дэвшлийг ашиглаж эхлээд байна.

Өндөр эрсдэлтэй нөхцөлд ажиллаж буй улсын эмнэлгийн ажилтнууд, онцгой байдлын албан хаагчид болон төрийн тусгай албан хаагчдын амь нас, эрүүл мэндийг үнэ төлбөргүйгээр даатгах “Ковид-19 Амь нас, хөдөлмөрийн чадвар алдалтын даатгал”, корона вирусийн халдвар авч тусгаарлагдсаны улмаас тасалдах орлогоо үнэлгээний хязгаарын хүрээнд нөхөн төлбөр хэлбэрээр авах боломжтой “Ковид хүртээмжтэй даатгал” зэрэг шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ даатгалын зах зээлд нэвтрээд байна.

Бичил санхүүгийн зах зээлийн төлөв


Олон улсын зах зээл. Олон улсын байгууллагууд корона вирусийн тархалтын улмаас банк санхүүгийн байгууллагад учрах хамгийн том эрсдэл нь зээлийн эрсдэл ба чанаргүй зээлийн эзлэх хувь өссөнөөр зээлийн зардал өснө гэж үзэж байна. S&P

олон улсын үнэлгээний байгууллагаас гаргасан тооцооллоор Ази-Номхон далайн бүс нутгийн орнуудын банк, санхүүгийн байгууллагуудын зээлийн зардал ойролцоогоор 300 тэрбум ам.доллараар өсөж, чанаргүй активын хэмжээ 600 тэрбум ам.доллараар нэмэгдэнэ гэж тооцоолжээ.

Ази Номхон далайн бүс нутгийн орнууд хөрвөх чадварыг нэмэгдүүлэх, цар тахалд өртсөн бүс нутаг, салбарт чиглэсэн зээл олгох, бодлогын хүүг бууруулах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа бөгөөд ингэснээр богино хугацаан дахь шокийн нөлөөллийг бууруулж, түр хугацаагаар ажилгүй болсон иргэд, дампуурах эрсдэл бүхий бизнесийн ачааллыг багасгана гэж үзэж байна. Хэдийгээр эдгээр арга хэмжээг хэрэгжүүлсэн ч чанаргүй актив болон зээлийн зардал өсөх нь гарцаагүй үзэгдэл болоод байна.

Мөн бичил санхүүгийн байгууллагуудын хувьд банкны салбарын оролцогчдоос харьцангуй сул хөгжилтэй байдаг учир энэ хямралд илүү эмзэг байх нь гарцаагүйг судлаачид онцолж байна.

Дүрслэл 2.53 Чанаргүй актив болон зээлийн зардал /ам.доллараар/




Эх сурвалж: S&P Global

Банк бус санхүүгийн байгууллага (ББСБ)-ын зах зээл. 2020 оны 1 дүгээр улирлын байдлаар Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэйгөөр 540 ББСБ үйл ажиллагаа эрхэлж байгаа ба тэдгээрийн нийт хөрөнгө 1.8 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 381.3 тэрбум төгрөгөөр буюу 27.3 хувиар өссөн байна. Энэ өсөлт нь өмнөх оны мөн үеийн өсөлтөөс 6.0 нэгжээр буурсан үзүүлэлт юм.


Нийт зээл 2020 оны 1 дүгээр улиралд өмнөх оны мөн үеэс 295.9 тэрбум төгрөгөөр өсөж 1.3 тэрбум төгрөгт хүрсэн үзүүлэлттэй байна. Нийт зээлийн өсөлт 2019 оны 1 дүгээр

Дүрслэл 2.54: Зээлийн зардал /тэрбум ам.доллар/



Эх сурвалж: S&P Global

Дүрслэл 2.56: Нийт зээл ба зээлийн өсөлт




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

улиралд 38.0 хувь байсан нь 2020 оны 1 дүгээр улиралд 30.3 хувь болж буурсан байна.


Корона вирусийн улмаас иргэд, аж ахуй нэгжийн орлого тасалдах, зээлийн төлбөрөө хугацаанд нь барагдуулахад хүндрэл учрах, төлбөрийн дарамтад орох зэрэг эрсдэл өндөр байсан тул “ББСБ-уудын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж зарцуулах журам”-ыг түр хугацаанд өөрчлөлт оруулан зээлийн хугацааны ангиллыг сунгах бодлогыг хэрэгжүүлсэн. Тайлант хугацаанд салбарын чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь 8.4 байсан нь өмнөх оны мөн үеэс 0.7 нэгжээр буурсан үзүүлэлт юм. Харин хугацаа хэтэрсэн зээлийн эзлэх хувь нь 4.0 хувь болж

Дүрслэл 2.55: Нийт хөрөнгө ба хөрөнгийн өсөлт



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Дүрслэл 2.57: Зээлийн ангилал, чанаргүй зээлийн эзлэх хувь



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

өмнөх оны мөн үеэс 0.1 нэгжээр буурсан байна.

ББСБ-ууд нь зээлийн ангиллаас шууд хамааралтайгаар зээлийн эрсдэлийн санг байгуулж ажиллах ёстой байдаг ба тайлант улиралд зээлийн үйл ажиллагаа явуулж буй 495 байгууллагаас 94.9 хувь буюу 470 нь зээлийн эрсдэлийн санг бүрэн байгуулан ажиллав. Салбарын хэмжээнд нийтдээ зээлийн эрсдэлийн санг 102.7 хувиар байгуулсан үзүүлэлттэй байгаа нь тайлант улиралд зээлийн эрсдэлийг бүрэн нөхөх чадвартайг харууллаа.


Зээлдэгчдийн тоо өмнөх оны мөн үеэс 61.3 хувиар буюу 161.9 мянгаар өсөж 425.9 мянгад хүрсэн. Эдийн засгийн хүндрэлийн улмаас зээлийн бүтээгдэхүүний нийлүүлэлт хумигдах өндөр эрсдэл байдаг хэдий ч ББСБ-ын салбарын хувьд зээлийн үйлчилгээний нийлүүлэлтэд бууралт ажиглагдахгүй байна.

Салбарын хэмжээнд нэг зээлдэгчид ногдох зээлийн хэмжээ дунджаар 3.0 сая төгрөг болж буурсан байна. Нэг зээлдэгчид ногдох зээлийн хэмжээний бууралт нь нийт зээлийн өсөлт нь зээлдэгчдийн тооны өсөлтөөс бага байгаатай холбоотой бөгөөд салбарын хэмжээнд зээлийн өрийн дарамт багассаныг харуулах үзүүлэлт юм.

Харин ББСБ-уудын зээлийн жигнэсэн дундаж сарын хүү 2020 оны 1 дүгээр улиралд 3.0 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 0.4 нэгжээр буурлаа.


ББСБ-уудын үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах зорилгоор Санхүүгийн зохицуулах хорооноос зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг мөрдүүлдэг бөгөөд 2020 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт

Дүрслэл 2.58 Зээлийн зардал /тэрбум ам.доллар/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Дүрслэл 2.59 Зээлдэгчдийн тоо болон нэг зээлдэгчид ногдох зээлийн хэмжээ



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Дүрслэл 2.60 Зээлийн хүү



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

ББСБ-ын 81.7 хувь буюу 441 ББСБ зохистой харьцааг бүрэн хангаж ажилласан бол үлдсэн 18.3 хувь буюу 99 нь зохистой харьцааны 1 буюу түүнээс дээш үзүүлэлтийг хангаагүй байна. 1 зохистой харьцаа хангаагүй 88 ББСБ, 2 зохистой харьцаа хангаагүй 5 ББСБ, 3 зохистой харьцаа хангаагүй 5 ББСБ, 4 зохистой харьцаа хангаагүй 1 ББСБ байна.

Хүснэгт 2.4. Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт хангасан байдал

№	Үзүүлэлт	ББСБ-ын тоо	Эзлэх хувь
1	Зохистой харьцааг хангаж ажилласан ББСБ-ын тоо	441	81.70%
2	Нэг зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	88	16.30%
3	Хоёр зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	5	0.90%
4	Гурван зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	5	0.90%
5	Дөрөв буюу түүнээс дээш зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	1	0.20%
Нийт		540	100%


Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Z индекс нь ББСБ-ын дампуурах магадлалыг харуулдаг ба активын өгөөж болон өөрийн хөрөнгийн харьцааны нийлбэрийг активын өгөөжийн хэлбэлзэлд харьцуулж тооцдог.

Индексийн утга ашигт ажиллагаа болон өөрийн хөрөнгийн хөшүүрэг өндөр байх үед их гарах ба өгөөжийн хэлбэлзэл ихтэй үед буюу орлогын тодорхойгүй байдал их үед бага гарна. Өөрөөр хэлбэл индексийн их утга нь эрсдэл багатай, тогтвортой байдлыг илэрхийлдэг. ББСБ-ын салбарын Z индекс өмнөх оны мөн үеэс 2.0 нэгжээр буурч 26.1 болсон байна.


ББСБ-уудын зардал ба орлогын харьцаа 2020 оны 1 дүгээр улиралд 44.4 төгрөгт хүрсэн нь 100 төгрөгийн орлого олохын тулд дунджаар 44.4 төгрөгийн зардал гаргаж байна гэсэн үг юм. Тус үзүүлэлт өмнөх оны мөн үеэс 2.5 нэгжээр өсөж 41.9 хувьд хүрсэн үзүүлэлттэй байна.

Дүрслэл 2.61 Z индекс ба өгөөжийн стандарт хазайлт



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Дүрслэл 2.62 Зардал орлогын харьцаа



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Хүснэгт 2.5. ХЗХ-дын голлох статистик үзүүлэлтүүд /тэрбум төгрөг/

№	Үндсэн үзүүлэлтүүд	2020Q1	Банк
1	ХЗХ-дын тоо	254	
2	Гишүүдийн тоо	74,701	
3	Нийт актив	229.5	34,970.6
	Банкны салбарт эзлэх хувь	0.7%	
4	Нийт зээлийн өрийн үлдэгдэл	172.9	17,549.2
	Банкны салбарт эзлэх хувь	1.0%	
5	Нийт чанаргүй зээлийн үлдэгдэл	7.4	1,822.3
	Банкны салбарт эзлэх хувь	0.4%	
6	Нийт татан төвлөрүүлсэн хадгаламжийн үлдэгдэл	159.0	13,458.5
	Банкны салбарт эзлэх хувь	1.2%	
7	Нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн үлдэгдэл	43.2	2,958.1
	Банкны салбарт эзлэх хувь	1.5%	
8	Нийт хоршоологчдын өмчийн үлдэгдэл	24.6	
9	Өр төлбөр	24.0	
10	Нийт орлого	14.0	
11	Нийт зардал	11.8	
12	Тухайн үеийн ашиг, алдагдал	2.2	


Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Хадгаламж, зээлийн хоршоо (ХЗХ)-дын зах зээл. 2020 оны 1 дүгээр улирлын байдлаар 254 ХЗХ Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа эрхэлж байгаа ба тэдгээрийн 160 ХЗХ нь Улаанбаатар хотод, 94 ХЗХ нь хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант улиралд ХЗХ-дын нийт активын хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8.4 хувиар өсөж 229.5 тэрбум төгрөгт хүрэв.


Тайлант хугацаанд салбарын нийт зээлийн үлдэгдлийг өнгөрсөн оны мөн үетэй

Дүрслэл 2.63 ХЗХ-дын нийт зээл, зээлийн чанар



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Дүрслэл 2.65 ХЗХ-дын хүүгийн түвшин



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

харьцуулахад 10.4 хувиар өсөж 172.9 тэрбум төгрөгт хүрсэн ба нийт зээлийн багцын 92.2 хувийг хэвийн, 3.5 хувийг хугацаа хэтэрсэн, 4.3 хувийг чанаргүй зээл тус тус эзэлж байна. Чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 0.4 нэгж хувиар өсөж 4.3 хувьд хүрчээ.


Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад салбарын нийт олгосон зээл 12 хувиар буурч 106.6 тэрбум төгрөгт хүрэхэд “Машин мотоциклийн засвар үйлчилгээ”-ний зориулалтаар олгосон зээл 80.6 хувиар буурч, “Усан хангамж, бохир ус, хог хаягдлын

Дүрслэл 2.64 ХЗХ-дын төлөгдсөн, олгосон зээлийн бүтэц /хувиар/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Дүрслэл 2.66 ХЗХ-дын өр төлбөр ба өөрийн хөрөнгө /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа” мөн 75 хувиар буурч, “Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа”-ны зориулалтаар олгосон зээл 40.2 хувиар тус тус буурсан нь голчлон нөлөөлсөн байна.

ХЗХ-дын салбарын хувьд хадгаламжийн жигнэсэн дундаж хүү тогтвортой байгаа бол зээлийн жигнэсэн дундаж хүү өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 0.3 нэгжээр нэмэгдэж 3.1 хувьд хүрсэн.

ХЗХ-дын өөрийн хөрөнгийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 10.9 тэрбум төгрөг буюу 34.0 хувиар нэмэгдсэн бол өр төлбөрийн хэмжээ 3.3 тэрбум төгрөг буюу 16.1 хувиар өсжээ.

Татан төвлөрүүлсэн хадгаламжийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 2.1 хувиар өсөж 159.0 тэрбум төгрөгт хүрч нийт хөрөнгийн 69.3 хувийг эзэлж байгаа бөгөөд үүний 155.1 тэрбум төгрөг буюу 97.5 хувь нь хугацаатай хадгаламж бол 3.9 тэрбум төгрөг буюу 2.5 хувь нь хугацаагүй хадгаламж байна.

ХЗХ-дын эрсдэл, эмзэг байдлыг үнэлэхдээ тэдгээрийн тогтвортой байдлыг тодорхойлох үзүүлэлтүүдийг шинжлэх шаардлагатай. 2001 онд Олон улсын валютын сан (IMF)-аас санхүүгийн байгууллагуудын тогтвортой байдлын үзүүлэлтүүдийг гаргасан бөгөөд дэлхий даяар зохицуулагч байгууллагууд эдгээр үзүүлэлтүүдийг зайны хяналт шалгалтын үндсэн хэрэгсэл болгон ашиглаж санхүүгийн салбарын тогтвортой, эрүүл байдлыг хэмжиж байна.

Иймд дараах тогтвортой байдлыг үнэлэх үзүүлэлтүүдээр ХЗХ-дын эрсдэл эмзэг байдлыг шинжилье. Үүнд:

1. Өөрийн хөрөнгийн хүрэлцээ
2. Нийт хөрөнгийн чанар
3. Үр ашигт байдал
4. Хөрвөх чадвар

Өөрийн хөрөнгийн хүрэлцээ: 2020 оны 1 дүгээр улирлын байдлаар өөрийн хөрөнгө ба нийт хөрөнгийн харьцаа өмнөх оны мөн үеэс 3.6 нэгжээр өсөж 18.8 хувьд хүрчээ. Энэ нь ХЗХ-дын нийт хөрөнгө нэмэгдэхийн хэрээр эрсдэл даах чадвар бүхий өөрийн хөрөнгийн хүрэлцээг илтгэх харьцаа өссөнийг харуулж байна.

Хөрөнгийн чанар: Чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 0.4 нэгж хувиар өсөж 4.3 хувьд хүрсэн ч чанаргүй зээлийн ангилал дахь муу зээлийн харьцаа өмнөх оноос бууран 43.7 хувьд хүрч зээлийн эрсдэлийн сангийн зардлыг буурууллаа.

Үр ашигт байдал: Тайлант улиралд ХЗХ-дын өөрийн хөрөнгийн өгөөж нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.6 нэгжээр өсөж 6.4 хувьд хүрсэн бол нийт хөрөнгийн өгөөж нь 0.8 нэгжээр өсөж 1.1 хувьд хүрчээ. Энэхүү өгөөж нэмэгдэхэд зээлийн эрсдэлийн сангийн зардал буурч ашгийн хэмжээ нэмэгдсэн нь нөлөөлжээ.

Хөрвөх чадвар: Харин байгууллагын хөрвөх чадварыг илэрхийлэх үзүүлэлтүүд болох мөнгөн хөрөнгө болон нийт хөрөнгийн харьцаа, богино хугацаат хөрөнгө оруулалтын зээл болон нийт хөрөнгийн харьцааг доор тооцон үзүүлээ.


Эдгээр үзүүлэлтүүд нь хадгаламж эзэмшигч болон хөрөнгө оруулагч хөрөнгөө татах үед тухайн санхүүгийн байгууллага өөрийн хөрөнгөө мөнгөн хөрөнгөнд хэр түргэн хөрвүүлэх боломжтойг харуулдаг. ХЗХ-дын хувьд сүүлийн 5 жилийн хугацаанд нийт мөнгөн хөрөнгө болон нийт хөрөнгийн харьцаа дунджаар 19.1 хувьтай байсан бол тайлант улиралд 20.6 хувьтай байна. Харин

Дүрслэл 2.67 ХЗХ-дын өөрийн хөрөнгийн хүрэлцээ /хувиар/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Дүрслэл 2.69 ХЗХ-дын нийт хөрөнгийн ба өөрийн хөрөнгийн өгөөж /хувиар/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

богино хугацаат хөрөнгө оруулалт болон нийт зээлийн нийлбэрийг нийт хөрөнгөд харьцуулсан үзүүлэлт сүүлийн 5 жилийн хугацаанд дунджаар 76.4 хувьтай байсан бол тайлант улиралд тус үзүүлэлт 75.4 хувьтай байна.


Зах зээлд тулгарч буй эрсдэл, түүний эсрэг хэрэгжүүлж буй арга хэмжээ. Корона вирусийн тархалт, эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байдлын нөлөөнд хамгийн их өртөх санхүүгийн салбар бол зээлийн үйлчилгээ үзүүлдэг банк, санхүүгийн байгууллага гэж судлаачид үзэж байна. Монгол Улсын хувьд зээлийн зах зээлд арилжааны банкнаас гадна ББСБ, ХЗХ

Дүрслэл 2.68 ХЗХ-дын чанаргүй зээлийн ангилал /хувиар/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Дүрслэл 2.70 ХЗХ-дын хөрвөх чадварын харьцаа /хувиар/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

үйл ажиллагаа явуулдаг. Арилжааны банктай харьцуулахад ББСБ-ууд нь өөрийн хөрөнгийн эх үүсвэрээс харьцангуй бага дүнтэй, богино хугацаатай зээлийг олгодгоороо онцлогтой. Харин ХЗХ нь зөвхөн гишүүддээ үйлчилдэг.

2020 оны 1 дүгээр улирлын статистик мэдээллээс харахад ББСБ, ХЗХ-дын зах зээлд корона вирусийн дам нөлөөнөөс шалтгаалсан мэдэгдэхүйц өөрчлөлт, бууралт ажиглагдахгүй байна.

Зах зээлд тодорхой бус байдал үүссэн өнөө үед иргэдийн зээлийн төлбөрийн дарамтыг бууруулах, зээлийн мэдээллийн санд муу зээлдэгчээр бүртгэгдэхээс сэргийлэх зорилгоор Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайдын 2020 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн 122/58 дугаар хамтарсан тушаалаар “Банк бус санхүүгийн байгууллагын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”, “Хадгаламж, зээлийн хоршооны активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж зарцуулах журам”-д түр хугацаанд өөрчлөлт оруулсан. Уг тушаалаар зээлийн ангилал бууруулах хугацааг 0-120 хоног хүртэл

хугацаа хэтэрвэл хэвийн зээлийн ангилалд бусад ангиллын хувьд тус тус 60 хоногийн хугацаагаар сунгахаар зохицуулсан бөгөөд энэ зохицуулалт нь ББСБ, ХЗХ-дын зээлийн чанарт эерэгээр нөлөөлж байна.

Цар тахал, хөл хорионы улмаас зээлдэгчдийн төлбөрийн дарамтыг бууруулах, эрсдэлээс хамгаалах зорилгоор зээлийн зөөлөн бодлого баримтлан, орлого нь тасалдсан иргэд, аж ахуй нэгжийн зээлийн гэрээнд

өөрчлөлт оруулан, торгууль, алданги ногдуулахгүй байх чиглэлийг Санхүүгийн зохицуулах хорооноос ББСБ-уудад хүргүүлэн ажиллаж байгаа бөгөөд өнгөрсөн хугацаанд нийт 223 ББСБ 93.9 мянган зээлдэгчийн 120.7 тэрбум төгрөгийн зээлийн гэрээнд өөрчлөлт оруулаад байна.

Дүрслэл 2.71 Санхүүгийн нөхцөлийг тодорхойлогч үзүүлэлтүүд



Эх сурвалж: Монголбанк

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН САЛБАРЫН ГОЛЛОХ ЭРСДЭЛ, ЭМЗЭГ БАЙДАЛ

3

3.1 МОНГОЛ УЛСЫН САНХҮҮГИЙН САЛБАРЫН ЭРСДЭЛ, ЭМЗЭГ БАЙДАЛ


i. БАНКНЫ САЛБАРЫН ЭХ ҮҮСВЭРИЙН ДОЛЛАРЖИЛТ

Монгол Улсын арилжааны банкуудын активын долларжилт буурч, эх үүсвэрийн долларжилт нэмэгдэх хандлагатай байна. Монгол Улсын банкны салбарын активын долларжилтын хэмжээ сүүлийн жилүүдэд тасралтгүй буурч, 2020 оны 6 дугаар сарын байдлаар 9.5 хувьд хүрээд байна. Харин эх үүсвэрийн долларжилтын хэмжээ нэмэгдэх хандлагатай байгаа ба 2020 оны 6 дугаар сард харилцах, хадгаламжийн долларжилт өмнөх оны мөн үеэс 5.5 нэгж хувиар өсч, 33 хувьтай гарав¹⁰. Үүн дотроо харилцахын долларжилт 45.6 хувьтай байгаа бол хадгаламжийн долларжилт 28.6 хувь байна. Түүнчлэн харилцах, хадгаламжийн бодит долларжилт

25.9 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 3.6 нэгж хувиар өсөөд байна¹¹.


Валютын хадгаламжийн дийлэнх хувийг иргэдийн хадгаламж, валютын харилцахын дийлэнх хувийг ААН-ийн харилцах бүрдүүлж байна. 2020 оны 6 дугаар сарын эцсийн байдлаар гадаад валютын хадгаламж нь нийт хадгаламжийн 28.6 хувь буюу 4162.3 тэрбум төгрөг (1474.4 сая ам.доллар)-тэй тэнцэх хэмжээтэй байна. Үүнээс иргэдийн гадаад валютын хадгаламж 3519 тэрбум төгрөг (1246.5 сая ам.доллар), ААН-ийн¹² гадаад валютын хадгаламж 552 тэрбум төгрөг (195.5 сая ам.доллар), бусад

Дүрслэл 3.1 Гадаад валютын харилцах, хадгаламжийн хэмжээ /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Монголбанк

Дүрслэл 3.2 Нийт харилцах, хадгаламжийн хэмжээ /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Монголбанк

¹⁰ Иргэд, улсын байгууллага, хувийн байгууллага болон бусад байгууллагын харилцах, хадгаламжид үндэслэн тооцов.

¹¹ 2016 оны 1 дүгээр сарын дундаж ханшаар зэрэгцүүлэн ханшийн нөлөөг арилган бодит долларжилтыг тооцов.

¹² Хувийн болон улсын байгууллагын хадгаламж.


хадгаламж 23.9 тэрбум төгрөг (8.5 сая ам.доллар)-тэй тэнцүү байна.

Харин гадаад валютын харилцах нь нийт харилцахын 45.6 хувь буюу 2311.6 тэрбум төгрөг (818.8 сая ам.доллар) байна. Үүнээс иргэдийн гадаад валютын харилцах 312.1 тэрбум төгрөг (110.5 сая ам.доллар), ААН-ийн гадаад валютын харилцах 1937.3 тэрбум төгрөг (686.2 сая ам.доллар), бусад харилцах 54.5 тэрбум төгрөг (19.4 сая ам.доллар)-тэй тэнцүү байна.

Хувийн байгууллагаас татсан эх үүсвэр хамгийн өндөр долларжилттай байна.

Иргэдийн харилцах, хадгаламжийн долларжилтыг авч үзвэл ААН, байгууллагуудтай харьцуулахад бага түвшинд буюу 2020 оны 6 дугаар сарын байдлаар 26.3 хувьтай байна. Энэ нь оны эхнээс 2.1 нэгж хувиар, өмнөх оны мөн үеэс 5.9 нэгж хувиар өссөн үзүүлэлт юм. Иргэдийн валютын харилцах, хадгаламж нь 3831 тэрбум төгрөгтэй тэнцэх буюу нийт валютын харилцах хадгаламжийн хэмжээнд харьцуулбал 62.5 хувийг эзэлж байна.

Дүрслэл 3.3 Валютын хадгаламжийн задаргаа




Эх сурвалж: Монголбанк

Хувийн байгууллагын хувьд харилцах, хадгаламжийн долларжилт нь долларжилтын ерөнхий түвшин болон иргэдийнхээс харьцангуй өндөр буюу 55.8 хувьтай байна. Энэ нь оны эхнээс 3.3 нэгж хувиар, өмнөх оны мөн үеэс 7.2 нэгж хувиар өссөн үзүүлэлт юм. Хувийн байгууллагын валютын харилцах, хадгаламж нь 2154 тэрбум төгрөгтэй тэнцэх буюу нийт валютын харилцах хадгаламжийн хэмжээнд харьцуулбал 33.3 хувийг эзэлж байна.

Улсын байгууллагын хувьд харилцах, хадгаламжийн долларжилт нь хэлбэлзэл өндөртэй байна. Тус үзүүлэлт 2019 оны 8 дугаар сард 64.9 хувьд хүрч огцом өсөөд байсан бол 10 дугаар сараас хурдацтай буурч 2020 оны 6 дугаар сарын байдлаар 41.1 хувьтай байна. Улсын байгууллагын валютын харилцах, хадгаламжийн хэмжээ нь 401.8 тэрбум төгрөгтэй тэнцэх буюу нийт валютын харилцах хадгаламжийн хэмжээнд харьцуулбал 6.2 хувийг эзэлж байна.

Дүрслэл 3.4 Хадгаламжийн долларжилт, ангиллаар



Эх сурвалж: Монголбанк


I. Валютын хадгаламжийн задаргаа, долларжилт

Хувийн байгууллагын хадгаламжийн долларжилт өндөр түвшинд, хурдацтай өсч байна. Гадаад валютын хадгаламжийн үлдэгдлийн 84.5 хувь буюу 3519 тэрбум төгрөгийг иргэдийн валютын хадгаламж, 13.3 хувь буюу 552 тэрбум төгрөгийг хувийн байгууллагын хадгаламж, 1.6 хувь буюу 66.5 тэрбум төгрөгийг улсын байгууллагын хадгаламж тус тус бүрдүүлж байна.

2020 оны 6 сарын эцсийн байдлаар иргэдийн хадгаламжийн долларжилт 26.3 хувь, хувийн байгууллагын хадгаламжийн долларжилт 57.2 хувь, улсын байгууллагын хадгаламжийн хувьд 18.5 хувьтай байна.


Хадгаламжийн долларжилтын үзүүлэлтийг шинжилбэл 2018 оны 7 дугаар сараас 2019 оны 9 дүгээр сар хүртэл харьцангуй тогтворжсон хандлагатай байсан бол 2019 оны 10 сараас хойш тасралтгүй өсчээ. Тус үзүүлэлт 2020 оны 6 дугаар сарын эцсийн байдлаар 28.6 хувьтай буюу оны эхнээс 3.1 нэгж хувиар, өмнөх оны мөн үеэс 6.5 нэгж хувиар тус тус өссөн байна. Харин 2016 оны эхэн үеийн валютын ханшийг суурь болгон авч үзэж, валютын ханшийн нөлөөг цэвэрлэсэн хадгаламжийн бодит долларжилтын түвшин 21.4 хувьтай буюу оны эхнээс 2.0 нэгж хувиар, оны өмнөхөөс 3.6 нэгж хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Дүрслэл 3.5 Хадгаламжийн нэрлэсэн ба бодит долларжилт¹³




Эх сурвалж: Монголбанк

Дүрслэл 3.6 Хадгаламжийн долларжилтын өөрчлөлтийн бүтэц



Эх сурвалж: Монголбанк

Дүрслэл 3.7 Валютын харилцахын задаргаа



Эх сурвалж: Монголбанк

¹³ 2016 оны эхэн үеийн валютын ханшийг суурь болгон авч үзэж, валютын ханшийн нөлөөг цэвэрлэсэн бодит долларжилтын түвшин

Гадаад валютын хадгаламжийн өсөлт нь долларжилтын өөрчлөлтийг голлон тайлбарлаж байна.

Хадгаламжийн (нэрлэсэн) долларжилтын өөрчлөлтийн бүтцийг шинжилбэл 2019 онд валютын хадгаламжийн өсөлт нь долларжилтыг 2.7 нэгж хувиар өсгөх нөлөөтэй, ханшийн өөрчлөлт нь долларжилтыг 0.6 нэгж хувиар өсгөх нөлөөтэй, төгрөгийн хадгаламжийн өсөлт нь долларжилтын түвшинг 1.3 нэгж хувиар бууруулах нөлөөтэй байжээ. Улмаар хамтын нөлөө буюу нэрлэсэн долларжилтын түвшин 2019 онд 1.9 хувиар өссөн байна.

Харин 2020 оны 1-6 дугаар сард валютын хадгаламж 26.6 хувиар буюу 875.9 тэрбум төгрөгөөр өссөн нь долларжилтын түвшин оны эхнээс 4 нэгж хувиар нэмэгдэж, 28.6 хувьд хүрэхэд голлон нөлөөлжээ. (Зураг 6)

II. Валютын харилцахын задаргаа, долларжилт

Хувийн болон улсын байгууллагын харилцах дансны долларжилт өндөр түвшинд байсаар байна.

Гадаад валютын харилцахын үлдэгдлийн 69.3 хувь буюу 1602 тэрбум төгрөгийг хувийн байгууллагын валютын харилцах, 14.5 хувь буюу 335.3 тэрбум төгрөгийг улсын байгууллагын валютын харилцах, 13.5 хувь буюу 312.1 тэрбум төгрөгийг иргэдийн валютын харилцах тус тус бүрдүүлж байна. (Дүрслэл 3.7)

Харин 2020 оны 6 сарын эцсийн байдлаар хувийн байгууллагын харилцахын долларжилт 55.3 хувь, улсын байгууллагын

харилцахын долларжилт 54.2 хувь, иргэдийн харилцахын долларжилт 22.2 хувьтай байна. (Дүрслэл 3.8)

Харилцахын долларжилтыг 2017 оноос хойш шинжилбэл хэлбэлзэл өндөртэй байв. Тус үзүүлэлт нь 2019 оны 8-12 дугаар сард 50 орчим хувиас 42.4 хувьд хүрч эрчимтэй буурсан бол 2020 оны эхнээс эрчимтэй өсч 45.6 хувьд хүрээд байна. Энэ нь оны эхнээс 3.1 нэгж хувиар, өнгөрсөн оны мөн үеэс 5.8 нэгж хувиар тус тус өсчээ. Харин харилцахын бодит долларжилтын түвшин 37.4 хувьтай буюу оны эхнээс 2.1 нэгж хувиар, оны өмнөхөөс 4 нэгж хувиар өссөн үзүүлэлттэй байна. (Дүрслэл 3.9)

Төгрөгийн харилцахын хэмжээ буурч байгаа нь долларжилтын өөрчлөлтийг голлон тайлбарлаж байна. Харилцахын (нэрлэсэн) долларжилтын өөрчлөлтийн бүтцийг шинжилбэл 2017-2018 онуудад валютын болон төгрөгийн харилцах хоёулаа өсөлттэй, хэлбэлзэл өндөртэй байжээ. Харин 2019 оны 1-9 дүгээр сарын хоорондох долларжилтын огцом өсөлтөд валютын харилцах дансны өсөлт голчлон нөлөөлсөн бол 10-12 дугаар сард валютын харилцах 20.2 хувиар буурч, төгрөгийн харилцах 2.2 хувиар өссөн нь долларжилтын үзүүлэлтийг 6.1 нэгж хувиар огцом бууруулж, 42.4 хувьд хүргэжээ.

Харин 2020 оны 1-6 дугаар сард төгрөгийн харилцах 11.8 хувиар буюу 368.7 тэрбум төгрөгөөр буурсан нь долларжилтын түвшинг оны эхнээс 2.1 нэгж хувиар нэмэгдүүлж, 37.4 хувьд хүрэхэд голлон нөлөөлжээ. (Дүрслэл 3.10)


Хадгаламжийн долларжилт өндөр байхад ханшийн хөдөлгөөн чухал нөлөөтэй. Хадгаламжийн долларжилт нэмэгдэх, зээлийн долларжилт буурах үзэгдэл нь үндэсний мөнгөн тэмдэгтийн ханшийн үргэлжилсэн сулралтын үед явагдах хандлагатай байдаг. Учир нь төгрөгийн ханш суларснаар банкны хадгаламж эзэмшигчдийн төгрөгт итгэх итгэл буурах, ингэснээр валютын хадгаламжийг нэмэгдүүлдэг. Нөгөө талаас төгрөгийн ханшийн уналтаас үүдэн ирээдүйд төлөх төлбөрийн хэмжээ нэмэгдэх учир зээлдэгч нар валютын зээлийг сонирхохоо больж, валютын зээлийн хэмжээ буурахад хүргэдэг байна.

III. Санхүүгийн тогтвортой байдалд учруулж болзошгүй эрсдэлүүд

Эх үүсвэрийн долларжилт өндөр байгаа нь тодорхой сөрөг нөлөөг бий болгож байна. Санхүүгийн долларжилтын түвшин өндөр байх нь мөнгөний бодлого, түүний шилжих механизмын нөлөөг сулруулж, тогтворгүй, өндөр инфляци, ханшийн хэлбэлзлийг үүсгэх, хараат бус мөнгөний бодлого хэрэгжүүлэхэд хүндрэл учруулах, хүүний зөрүүг нэмэгдүүлэх, санхүүгийн системийг хямралд өртөмтгий, эмзэг болгох зэрэг сөрөг нөлөөтэй.


Бусад улс орнуудтай харьцуулахад эх үүсвэрийн долларжилт өндөр түвшинд байна. ОУВС-гийн судалгаанд¹⁴ дэлхийн улс орнуудын долларжилтын түвшинг хадгаламжийн долларжилтын түвшингээр

Дүрслэл 3.8 Харилцахын долларжилт, ангиллаар




Эх сурвалж: Монголбанк

Дүрслэл 3.9 Харилцах дансны нэрлэсэн ба бодит¹⁵ долларжилт



Эх сурвалж: Монголбанк

Дүрслэл 3.10 Харилцахын долларжилтын өөрчлөлтийн бүтэц



Эх сурвалж: Монголбанк

¹⁴ Mauro Mecagni, Rodolfo Maino et al. (2015). *Dollarization in Sub-Saharan Africa: experience and lessons*. IMF

¹⁵ 2016 оны эхэн үеийн валютын ханшийг суурь болгон авч үзэж, валютын ханшийн нөлөөг цэвэрлэсэн бодит долларжилтын түвшин

тодорхойлж, бага долларжилттай (10 хувь хүртэл), дунд долларжилттай (10-30 хувь), их долларжилттай (30 хувиас дээш) гэж 3 ангилсан ба энэ аргачлалаар Монгол улс 27.5 хувьтай буюу их долларжилттай ангилалд ойрхон байна. Мөн зүүн өмнөд Ази, Номхон далайн орнуудын дундаж долларжилтын түвшинтэй харьцуулахад Монгол улс 11.3 нэгж хувиар өндөр үзүүлэлттэй байна.

Долларжилт нэмэгдсэнээр санхүүгийн тогтвортой байдалд дараах эрсдэлүүд учруулна. Тухайлбал:

- Хөрвөх чадварын эрсдэл

Арилжааны банкуудын балансын пассивын бүтцэд зохистой хэмжээнээс давсан гадаад валют төвлөрсөн үед хөрвөх чадварын эрсдэл бий болдог. Тухайлбал тухайн орны болон банкны системийн эрсдэл нэмэгдэж байгаа үед хадгаламж эзэмшигчид болон зээлдүүлэгч нар өөрсдийн хадгаламж болон зээлийн эх үүсвэрээ гадаад валютад хөрвүүлэх, татаж авах эсвэл гадаадад байршуулж эхэлдэг. Энэ үед банкуудын хувьд валютын ТТГЧ муудаж, цаашлаад Төв банкны гадаад валютын нөөцөөс худалдаж авах шаардлага тулгарна.

Монголбанкны “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-ын дагуу гадаад валютын нээлттэй позиц болон өөрийн хөрөнгийн харьцаа нэгж валютын хувьд +/-15%, нийт валютын хувьд 30 хувиас хэтрэхгүй байх зохицуулалттай.

Эх сурвалж: Монголбанк


Банкны системийн хэмжээгээр уг харьцаа үзүүлэлтүүд Монголбанкнаас тогтоосон хязгаарлалтыг хангалттай хангаж байгаа боловч хэлбэлзэл өндөртэй байна.

- Төлбөрийн чадварын эрсдэл

Арилжааны банкуудын баланс дахь гадаад валютын нээлттэй позицын өсөлт¹⁶ болон үндэсний валютын ханшийн сулралтаас үүсэх өөрийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт нь төлбөрийн чадварын эрсдэлийг бий болгодог. Мөн үндэсний валютын ханш сулрахад банкны зээлдэгчдийн төлбөрийн чадвар буурч, энэ нь чанаргүй зээлийн хэмжээг өсгөх, улмаар дам байдлаар төлбөрийн чадварын эрсдэлийг нэмэгдүүлдэг¹⁷.

Монгол улсын хувьд сүүлийн жилүүдэд зээлийн долларжилтын түвшин буурсан хэдий ч төгрөгийн ханшийн сулралт нь валютын чанаргүй зээлийн хэмжээ, хадгаламжийн нэрлэсэн долларжилтыг

Дүрслэл 3.11 Гадаад валютын нээлттэй позиц болон өөрийн хөрөнгийн харьцаа (нэгж валютаар болон нийт валютаар)




¹⁶ Үндэсний валютын ханш огцом суларснаар валютын тэнцвэрт бус байдал (currency mismatch) бий болж, гадаад валютын нээлттэй позиц нэмэгддэг.

¹⁷ Үүнийг мөн валютаас шалтгаалсан зээлийн эрсдэл (currency-induced credit risk) гэж нэрлэдэг.

нэмэгдүүлэх, улмаар санхүүгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна.

Зээлийн долларжилтын түвшин 9.52 хувьтай байгаа бөгөөд гадаад валютаар олгосон зээлийн чанар муу байна. Зээлийн багцын чанарыг авч үзвэл гадаад валютаар олгосон зээлийн чанар, төгрөгийн зээлтэй харьцуулахад муу байна. 2020 оны 6 сарын байдлаар, төгрөгөөр олгосон нийт зээлийн 9.77 хувь чанаргүй, 4.3 хувь нь хугацаа хэтэрсэн ангилалтай байгаа бол валютаар олгосон нийт зээлийн 13.8 хувь нь чанаргүй, 11.4 хувь нь хугацаа хэтэрсэн

Дүрслэл 3.12 Чанаргүй зээлийн харьцаа /валютын төрлөөр/




Эх сурвалж: Монголбанк

ангилалд байна. Өөрөөр хэлбэл валютын эргэн төлөлтийн доголдолтой¹⁸ зээлийн хувь хэмжээ 28.3 хувьд хүрээд байна. Үүнд төгрөгийн ханшийн сулралтаас үүдэн валютын орлогогүй зээлдэгч нарын зээлийн төлбөрийн дарамт нэмэгдэж байгаа нь нөлөөлж байна.

Нийт валютын чанаргүй зээлийн хэмжээ 236.7 тэрбум төгрөг байгаагаас 27.1 хувь нь уул уурхайн салбар, 20.0 хувь нь боловсруулах үйлдвэрлэл, 14.8 хувь нь барилга, 9.8 хувь нь үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа, 6.5 хувь нь худалдааны салбарын чанаргүй зээл байна.

Дүрслэл 3.13 Валютын чанаргүй зээл /салбараар /



Эх сурвалж: Монголбанк


¹⁸ Хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн нийлбэр дүнгээр тодорхойлов.

ii. БАНКНЫ САЛБАРЫН ЭХ ҮҮСВЭРИЙН ТӨВЛӨРӨЛ

Монгол Улсын арилжааны банкуудын санхүүжилтийн гол эх үүсвэрийг иргэд, аж ахуйн нэгжүүдийн харилцах, хадгаламж бүрдүүлж буй бөгөөд уг санхүүжилтийн эх үүсвэр нь өндөр төвлөрөлтэй байна. 2020 оны 6 дугаар сарын байдлаар иргэд, аж ахуйн нэгжүүдийн харилцах, хадгаламжийн хэмжээ банкны салбарын нийт пассивын 62.8 хувийг эзэлж


байгаа ба үүний 43.3 нэгж хувийг иргэдийн хадгаламж, 4.6 нэгж хувийг иргэдийн харилцах, 3.2 нэгж хувийг хувийн байгууллагуудын хадгаламж, 9.5 нэгж хувийг хувийн байгууллагуудын харилцах, 1.2 нэгж хувийг улсын байгууллагын хадгаламж, 2.0 нэгж хувийг улсын байгууллагын харилцах, үлдсэн 0.7 нэгж хувийг бусад байгууллагын харилцах, хадгаламж тус тус бүрдүүлж байна.

Дүрслэл 3.14 Иргэдийн нийт харилцах, хадгаламжийн дүн /интервалаар/¹⁹




Эх сурвалж: Монголбанк.

Дүрслэл 3.16 Хувийн байгууллагын нийт харилцах, хадгаламжийн дүн /интервалаар/




Эх сурвалж: Монголбанк.

Дүрслэл 3.15 Иргэдийн нийт харилцах, хадгаламжийн дансны тоо /интервалаар/



Эх сурвалж: Монголбанк.

Дүрслэл 3.17 Хувийн байгууллагын нийт харилцах, хадгаламжийн дансны тоо /интервалаар/



Эх сурвалж: Монголбанк.

¹⁹ Тухайн интервалд багтах иргэдийн төгрөг (валют)-ийн харилцах (хадгаламж)-ын дүн болон дансны тоог иргэдийн нийт төгрөг (валют)-ийн харилцах

(хадгаламж)-ын дүн болон дансны тоонд харьцуулж тооцсон.

Гэвч уг санхүүжилтийн эх үүсвэр өндөр төвлөрөлтэй байгаа бөгөөд иргэд, хувийн байгууллагын харилцах, хадгаламжийн дансны 4.0 орчим хувьд нийт харилцах, хадгаламжийн 88.2 хувь байршиж байна.

Үүн дотроо иргэдийн төгрөгийн хадгаламжийн дансны 4.6 хувьд иргэдийн нийт төгрөгийн хадгаламжийн 77.9 хувь, иргэдийн валютын хадгаламжийн дансны 4.3 хувьд иргэдийн нийт валютын хадгаламжийн 86.4 хувь, хувийн байгууллагын төгрөгийн харилцахын 4.1 хувьд хувийн байгууллагын нийт төгрөгийн харилцахын 92.0 хувь, хувийн байгууллагын валютын харилцахын 4.2 хувьд хувийн байгууллагын нийт валютын харилцахын 97.5 хувь нь тус тус байршиж байна.

Монгол Улсын арилжааны банкууд зах зээлийн хүүнээс өндөр хүүтэй, тусгай нөхцөл бүхий харилцах, хадгаламжийн бүтээгдэхүүнүүдийг бий болгон

Дүрслэл 3.18 Херфиндал-Хиршманы индексээр тооцсон харилцах, хадгаламжийн төвлөрөл болон банкны салбарын шинээр татсан төгрөгийн хадгаламжийн жигнэсэн дундаж хүү




Эх сурвалж: Монголбанк

хадгаламж, харилцах татахын төлөө өрсөлдөж байна²⁰. Үүнд нэг талаас банкуудын олон улсын санхүүгийн зах зээлээс санхүүжилт татах боломж харьцангуй хязгаарлагдмал нөхцөл байдал, нөгөө талаас санхүүгийн хөрөнгийн дийлэнх хэсэг нь цөөн тооны иргэд, аж ахуйн нэгжүүдэд төвлөрсөн байдал нөлөөлж байна. 2019 оны 11 дүгээр сард хийгдсэн арилжааны банкуудыг хамарсан судалгааны үр дүнд банкны салбарын нийт төгрөгийн хадгаламжийн 29.9 хувь, гадаад валютын хадгаламжийн 44.1 хувь, төгрөгийн харилцах дансны 28.0 хувь, гадаад валютын харилцах дансны 48.1 хувь нь тус тус тусгай нөхцөлтэй байна.

Банкууд харьцангуй өндөр хүүтэй тусгай нөхцөл бүхий харилцах, хадгаламжийн бүтээгдэхүүнүүдийг бий болгон хадгаламжийн зах зээлд өрсөлдөж байгаа нь Монгол Улсад хадгаламжийн хүү өндөр

Дүрслэл 3.19 Хадгаламжийн нэрлэсэн хүү /хувь/



Эх сурвалж: Дэлхийн банк.

²⁰ Монголбанкнаас 2011 онд зохион байгуулсан хадгаламжийн хүүний санал асуулгаар нийт банкуудын 76.9 хувь, үүнээс том банкуудын 75 хувь, жижиг

банкуудын 86 хувь, дундаж банкуудын 67 хувь нь том хадгаламж эзэмшигчдийг татахын тулд өндөр хүү амлах тохиолдол гардаг хэмээн хариулсан байдаг.

тогтох, дорвитой буурахгүй байх нэг шалтгаан болж байна²¹.

Гэвч зээлийн хүүгийн энэхүү түвшинг Зүүн Ази, Номхон далайн орнуудын дундажтай харьцуулахад 9.2 нэгж хувиар, Латин Америк, Карибын орнуудын дундажтай харьцуулахад 3.4 нэгж хувиар, Ойрхи Дорнод, Хойд Африкийн орнуудын дундажтай харьцуулахад 8.8 нэгж хувиар тус тус өндөр байна.


Ийнхүү зээлийн нэрлэсэн хүүгийн түвшин өндөр байгаа нь эдийн засгийн өсөлт, хөгжилд сөргөөр нөлөөлж байна²².

Банкны салбарт хадгаламжийн төвлөрөл өндөр байгаагийн зэрэгцээ хадгаламжийн хугацаа богино байна. Энэ нь банкууд харьцангуй богино хугацаатай зээл гаргахад нөлөөлж байна. 2020 оны 6 дугаар сарын эцсийн байдлаар банкны нийт харилцах хадгаламжийн 43.3 хувийг харилцах болон хугацаагүй хадгаламж, 50.0 хувийг 1 жилээс бага үлдэгдэл хугацаатай хадгаламж тус тус бүрдүүлж байна.

Ийнхүү эх үүсвэрийн хугацаа харьцангуй богино байгаа нөхцөлд банкууд хөрвөх чадварын эрсдэлээ бага байлгах зорилгоор эдийн засгийн урт хугацааны хөгжлийг дэмжих шаардлагатай урт хугацаат зээлийг гаргах бус харин харьцангуй богино хугацаатай зээл олгохыг илүүд үзэж байна.


²¹ Үүнээс гадна банкуудын эх үүсвэрийн зардал өндөр байхад өндөр, тогтворгүй инфляци, түүнийг дагасан бодлогын хүүний өндөр түвшин, санхүүгийн салбар дахь долларжилт, төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн сулралт, дотоод эдийн засаг дахь мөнгөний нийлүүлэлтийн тогтвортой бус байдал, макро эдийн засгийн мөчлөг, хөрөнгийн зах зээлийн хөгжил зэрэг

Дүрслэл 3.20 Зээлийн нэрлэсэн хүү /хувь/



Эх сурвалж: Дэлхийн банк.

Дүрслэл 3.21 Банкны харилцах, хадгаламжийн бүтэц /хугацаагаар/




Эх сурвалж: Монголбанк.

хүчин зүйл нөлөөлж байна (“Зээлийн хүүг бууруулах стратеги 2018-2023”-ийн баримт бичиг).

²² Монголбанкны жижиг дунд үйлдвэрлэл (ЖДҮ)-ийн түүвэр судалгаануудаар ЖДҮ-ийг хөгжүүлэхэд учирч буй гол саад бэрхшээлийн нэг нь санхүүжилт, түүний зардал гэсэн нийтлэг үр дүн гарсан байдаг.

Тухайлбал, 2020 оны 6 дугаар сарын байдлаар банкны салбарын зээлийн нийт үлдэгдлийн 19.0 хувийг 1 хүртэлх жилийн (үлдэгдэл) хугацаатай зээл, 62.4 хувийг 3 хүртэлх жилийн хугацаатай зээл бүрдүүлж байна. Банкууд богино хугацаатай зээл илүүтэй гаргаж, хөрвөх чадварын эрсдэлийг бууруулж буй боловч банкны салбарт зээл, хадгаламжийн хугацааны нийцгүй байдал (maturity mismatch) өндөр хэвээр байна.

Дүрслэл 3.22 Банкны салбарын зээлийн бүтэц /хугацаагаар/



■ 0 - 6 сар ■ 6 сараас 1 жил ■ 1-3 жил ■ 3-аас дээш жил

Эх сурвалж: Монголбанк.

МОНГОЛБАНКНААС ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ МАКРО ЗОХИСТОЙ БОДЛОГЫН АРГА ХЭМЖЭЭ

4

Монголбанк нь санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хадгалах, банкны системийн эрсдэлээс сэргийлэх, системд үүссэн эмзэг байдлыг даамжруулахгүй байх, санхүүгийн зуучлалын тасалдлаас сэргийлэхэд чиглэсэн макро зохистой бодлогын арга хэмжээг мөнгөний бодлоготой хослуулан хэрэгжүүлж байна. Тухайлбал:


Банкны эх үүсвэрийн долларжилтыг бууруулах зорилгоор гадаад валютын заавал байлгах нөөцийн урамшууллыг харилцан адилгүй тооцож эхлэв.

Банкны салбарын зээлийн долларжилт буурсан ч эх үүсвэрийн долларжилт нэмэгдэх хандлагатай байгаа нь банкуудын баланс дахь валютын тэнцвэрт бус байдлыг нэмэгдүүлж, банк, санхүүгийн салбарт

эрсдэл хуримтлагдах нөхцөлийг бүрдүүлж байна. Иймд банкны эх үүсвэрийн долларжилтыг бууруулж, үндэсний валютаар эх үүсвэр татахыг дэмжих, нөгөө талдаа банкуудын зээлд гаргах боломжтой эх үүсвэрийг нэмэгдүүлж, зээлийн хүүг бууруулах, улмаар эдийн засаг дахь санхүүгийн зуучлалыг дэмжих зорилгоор банкны татан төвлөрүүлсэн эх үүсвэрт ногдуулах заавал байлгах нөөц төгрөгийн хувьд 8.5 хувь болгож бууруулсан бол гадаад валютын хувьд 15 хувьтай байна. Энэ нь төгрөг, гадаад валютын ЗБН-ийн зөрүүг нэмэгдүүлэхийн зэрэгцээ системийн хэмжээнд банкуудын 320 орчим тэрбум төгрөг заавал байлгах нөөцөөс чөлөөлөгдөв.


Түүнчлэн, Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2020 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн ээлжит хурлаар банкны

Дүрслэл 4.1 Банкны салбарын гадаад валютын харилцах, хадгаламжийн тархалт /хүүний интервалаар/



Эх сурвалж: Монголбанк

Дүрслэл 4.2 Хүү тооцогдож буй валютын харилцах болон ЖДХ-нээс өндөр хүүтэй хадгаламжийн тархалт /зөрүү хүүний интервалаар/



Эх сурвалж: Монголбанк

системийн тогтвортой байдлыг хангах, банкны эх үүсвэрийн долларжилтыг бууруулах, төгрөгийн харьцангуй өгөөжийг хадгалах зорилгоор өндөр хүүтэй гадаад валютын хадгаламж болон хүү төлж буй гадаад валютын харилцахын эзлэх хувиар банкинд олгох төгрөгийн заавал байлгах нөөцийн урамшууллыг бууруулан тооцох шийдвэрийг гаргалаа.


2020 оны 4 дүгээр сарын байдлаар банкны салбарын нийт гадаад валютын хадгаламжийн 23.3 хувь, гадаад валютын харилцахын 22.0 хувь нь харгалзах зах зээлийн жигнэсэн дундаж хүүнээс²³ нэгээс дээш нэгж хувиар өндөр хүүтэй байна. Банкууд гадаад валютын хадгаламжид гадаад валютын харилцахтай харьцуулахад харгалзах зах зээлийн жигнэсэн дундаж хүүнээс илүү өндөр хүү төлдөг байна. Иймд дээрх арга хэмжээг авч хэрэгжүүлснээр (i) гадаад валютын хадгаламжийн хүүг бууруулах, улмаар зээлийн хүү буурахад

дэмжлэг үзүүлэх; (ii) банкуудын харьцангуй өндөр хүүтэй гадаад валютын хадгаламж татах сэдэл буурч, улмаар хадгаламжийн долларжилт буурах эерэг нөлөөтэй.


Иргэдийн хэрэглээний зээлийн хувьд өр, орлогын харьцааны дээд хязгаарыг тогтоон, мөрдүүлж байна.

Өмнөх жилүүдэд хэрэглээний зээлийн хэт өндөр өсөлтийг тогтворжуулж, өрхийн зарлага нь орлогоосоо тогтмол давж байсан нь дотоод эрэлт, инфляцийг нэмэгдүүлж, цаашид орлого буурах тохиолдолд зээлийн чанарыг муутгах, хэрэглээг огцом хумих, түүнийг дагаад ДНБ-д үргэлжлэн сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байсан тул Монголбанк 2019 оноос иргэдийн хэрэглээний зээлийн хувьд өр, орлогын харьцааны дээд хязгаарыг тогтоон, мөрдүүлж байна. Макро зохистой бодлогын үр дүнд хэрэглээний зээлийн өсөлт 2019 оны эхнээс саарч, өрхийн өрийн дарамт болон түүнээс шалтгаалсан эрсдэл, эмзэг байдлыг буурууллаа.

Дүрслэл 4.3 Шинээр олгосон хэрэглээний зээл



Дүрслэл 4.4 Хэрэглээний зээлийн үлдэгдэл, өсөлт



²³ 2020 оны 4 дүгээр сарын байдлаар гадаад валютын харилцахын ЖДХ 1.2 хувь, гадаад валютын хадгаламжийн ЖДХ 4.57 хувь тус тус байна.

Ковид-19 цар тахлын нөлөөнд автсан хэрэглээний зээл

2020 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн байдлаар нийт иргэдийн зээлийн 20.2 хувь нь Ковид -19 цар тахлын нөлөөнд автсан байна. Энэ үзүүлэлт бизнесийн зээлийн хувьд 37 хувьтай байна.

2020 оны 6 дугаар сарын байдлаар банкуудын хэрэглээний зээлийн үлдэгдэл өмнөх сараас 1.5 хувиар, өмнөх оны мөн үеэс 18.9 хувиар буурч, 4,358.3 тэрбум төгрөгт хүрсэн нь банкны системийн нийт зээлийн 25.3 хувийг бүрдүүлж байна. Хэрэв тэтгэврийн зээлийн үлдэгдэлд гарсан нэг удаагийн шинжтэй нөлөөг²⁴ хасч тооцвол хэрэглээний зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 7.8 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Тэтгэврээс бусад хэрэглээний зээлийн үлдэгдэл 2020 оны 6 дугаар сарын байдлаар 4,199 тэрбум төгрөгтэй тэнцэж, өмнөх оны мөн үеэс 7.6 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Эргэн төлөлт нь хүндрэлд орсон зээлдэгчийн хэрэглээний зээлийн хугацааг 12 хүртэлх сараар сунгах шийдвэр гаргалаа.

Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2020 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн ээлжит бус хурлаар эргэн төлөлт нь хүндрэлд орсон зээлдэгчийн хэрэглээний зээлийн хугацааг 12 хүртэлх сараар сунгах шийдвэр гаргалаа. Энэхүү арга хэмжээ нь зээлдэгчдийн зээлийн сарын төлбөрийн дарамт буурч гар дээр үлдэх орлого

нэмэгдсэнээр хувийн хэрэглээг урамшуулах, улмаар үүсээд буй өнөөгийн хүндрэлийг зөөлрүүлэх, эдийн засгийн идэвхжлийг нэмэгдүүлэх нөлөөтэй юм.

Түүнчлэн хэрэглээний зээлд мөрдөгдөх өр, орлогын харьцаа (60%)-ны болон хугацаа (30 сар)-ны дээд хязгаараас шалтгаалан нөхцөл өөрчлөх боломжгүй байгаа, эргэн төлөлтийн хүндрэлд орчихсон байгаа хэрэглээний зээлийн хугацааг 12 хүртэлх сараар 1 удаа сунгах боломжийг банкууд болон зээлдэгчдэд олгов. Энэ шийдвэр нь 2020 оны 4-р сарын 14-ний өдрөөс эхлэн хэрэгжиж байна.

2020 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн байдлаар нийт хэрэглээний зээлийн багцын 13.5 хувь буюу 68,514 зээлдэгчийн 598.8 тэрбум төгрөгийн хэрэглээний зээлийн нөхцөлд өөрчлөлт оржээ. Нөхцөл өөрчилсөн зээлдэгчдийн 67.7 хувь нь 10 сая төгрөг хүртэл, 18.5 хувь нь 10-15 сая төгрөгийн, 13.8 хувь нь 15 сая төгрөгөөс дээш зээлийн үлдэгдэлтэй байна.

Төрөөс хэрэгжүүлж буй орон сууцны ипотекийн хөнгөлөлттэй хүүтэй зээлийн эргэн төлөлтийг түр хугацаагаар хойшлууллаа.

Ковид-19 цар тахалтай холбогдуулан зээлдэгчийн зээлийн эргэн төлөх нөхцөлийг дахин өөрчлөх, эргэн төлөлтийн доголдолтой зээлийн ангилал, зээлийн түүхийг түр хугацаанд муутгахгүй байх асуудлыг бие даан шийдвэрлэх боломжийг банкуудад олгож байна. Энэ арга хэмжээний хүрээнд Төрөөс хэрэгжүүлж буй орон сууцны

²⁴ “Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай” хуулийн хүрээнд

зээлдэгчийн зургаан сая төгрөг, түүнээс доош дүнтэй тэтгэврийн зээлийн төлбөрийг тэглэсэн.

ипотекийн хөнгөлөлттэй хүүтэй зээл авсан иргэдийг хамруулах зорилгоор Монголбанк, Сангийн яам, Монголын Ипотекийн Корпораци ОССК ХХК болон банкууд хамтран шийдвэр гаргав.

Үүнд орон сууцны ипотекийн 8 эсхүл 5 хувийн хүүтэй зээл авсан иргэн зээлийн эргэн төлөлтийн хуваарьт өөрчлөлт оруулах хүсэлт гаргасан тохиолдолд зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийг нэг удаа 6 хүртэлх сараар хойшлуулж, тухайн хугацаагаар зээлийн эргэн төлөлтийн хуваарийг уртасгах боломж олгов.

Нийт ипотекийн зээлийн багцын 43.5 хувь буюу 2039 тэрбум төгрөгийн 38270 зээлдэгчийн зээлийн нөхцөлд 6 дугаар сарын 19-ний байдлаар өөрчлөлт оржээ.

Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журамд түр хугацааны өөрчлөлт оруулав. КОВИД-19 вирусийн тархалттай холбоотойгоор Монгол Улсын эдийн засагт хүндрэл учирч, банкны салбарын зээлийн эргэн төлөлтөд доголдол үүсч байгаатай холбогдуулан Монголбанкнаас дараах журмуудын тодорхой зохицуулалтыг доорх нөхцөлтэйгээр түр хугацаагаар буюу 2020 оны 1 дүгээр сарын 31-ний өдрөөс 2020 оны 7 дугаар сарын 31-ний өдөр хүртэл мөрдүүлэхээр шийдвэрлэв.

1. “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-д:

- Ипотек, цалин, тэтгэвэр болон бусад хэрэглээний зээл хэлбэрээр иргэнд олгосон зээлд тогтоох хугацааны ангиллыг “Хэвийн” зээлийн хувьд 15 хүртэлх хоног байсныг 90

хүртэлх хоног болгож, “Анхаарал хандуулах” зээлийн хувьд 91-120 хүртэлх хоног, “Чанаргүй” зээлийн хувьд 121-ээс дээш хоног байхаар тус тус тогтоож мөрдөх;

- Хэрэглээний болон бизнесийн зээлийн бүтцийг өөрчилж, холбогдох гэрээнд өөрчлөлт оруулсан тохиолдолд уг зээлийг бүтэц өөрчлөгдсөн активт тооцохгүйгээр, эцсийн ангиллыг хэвээр тогтоох;

- Хэрэглээний зээлд 2020 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн байдлаар тогтоосон чанарын ангиллыг тушаал мөрдөгдөх хугацаанд хэвээр мөрдөх;

2. “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-д:

- Өөрийн хөрөнгийг хамгаалах нөөц зөрчигдөхөд авч хэрэгжүүлэх арга хэмжээг түдгэлзүүлэх;

- Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааг 20 хувиар тогтоох;

Эдгээр зохицуулалт нь КОВИД-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээнээс үүдэн зээлийн эргэн төлөлтөө хийхэд хүндрэл учирч буй зээлдэгчид нь зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрөө түр хугацаагаар эргүүлэн төлөх боломжгүй тохиолдолд тухайн зээлдэгчийн зээлийн ангиллыг хэвээр үлдээж, ангилал бууруулахгүй байх боломжийг бүрдүүлж байна. Ингэснээр хүндрэлд орсон зээлдэгчдэд зээлийн тасалдал үүсэхгүйгээр санхүүгийн хүртээмж хэвийн үргэлжлэх бололцоо бүрдэв.

Төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг дэмжих, ханшийн эрсдэлийг бууруулах зорилгоор гадаад валютын своп хэлцлийг тогтмол хийж байна.

Банкуудын богино хугацааны төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хангахад дэмжлэг үзүүлэх, валютын ханшийн эрсдэлээс хамгаалах, төгрөгийн ханшийн тогтвортой

байдлыг зорилгоор Монголбанк төгрөг-ам.долларын своп хэлцлийг банкуудтай тогтмол хийж байна. Цэвэр дүнгээр тооцвол оны эхнээс 6-р сарын 30 хүртэлх хугацаанд урт хугацаат своп хэлцлээр 498.4 тэрбум төгрөг, богино хугацаат своп хэлцлээр 377.8 тэрбум төгрөгийн нөөцийг банкуудад нийлүүлсэн байна.

ХАВСРАЛТ 1. ДЭЛХИЙН УЛС ОРНУУДАД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ МАКРО ЗОХИСТОЙ БОДЛОГЫН АРГА ХЭМЖЭЭНҮҮД

Ковид-19 цар тахлын сөрөг нөлөөллийн улмаас санхүүгийн системд үүсч болзошгүй эрсдэлийг хязгаарлаж, санхүүгийн системийн тогтвортой байдлыг хамгаалах зорилгоор дэлхийн улс орнуудад макро зохистой бодлогыг түгээмэл ашиглаж байна. Улс орнуудад авч хэрэгжүүлж буй макро зохистой бодлогын голлох арга хэмжээнүүдийг багцлан авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

а. Өөрийн хөрөнгийн нөөц (capital buffer)-ийг ашиглах

Өөрийн хөрөнгийн нөөцийн шаардлагыг сулруулах, хуримтлагдсан нөөц хөрөнгийг чөлөөлөх (release buffer) зэрэг макро зохистой бодлогын арга хэмжээг түгээмэл авч хэрэгжүүлж байна. Тухайлбал, Базел III стандартын дагуу мөчлөг сөрсөн өөрийн хөрөнгийн нөөц (countercyclical capital buffer) шаардлага тавьж буй орнуудад нөөц шаардлагын хувь хэмжээгээ бууруулж байна. Мөн Оман, Малайз, Словак зэрэг орнуудад хөрөнгө хамгаалах нөөц сан (capital conservation buffer)-гийн хувь хэмжээг бууруулах арга хэмжээ авчээ. Түүнчлэн Ковид-19 цар тахал тохиохоос өмнөх хугацаанд мөчлөг сөрсөн өөрийн хөрөнгийн нөөц бүрдүүлсэн зарим орнууд (Герман, Литва г.м)-д холбогдох нөөц хөрөнгийг чөлөөлөх шийдвэрийг гаргасан байна.

Латви, Норвеги, Швед зэрэг орнуудад хувьцаа эзэмшигчдэд тараах ногдол ашгийг хязгаарлаж, ирээдүйд учирч болзошгүй алдагдлыг шингээхэд шаардлагатай нөөц хөрөнгийг бүрдүүлэх чиглэлийг эрх бүхий байгууллагуудын зүгээс банк, санхүүгийн байгууллагуудад өгсөн байна.

б. Чанаргүй зээлийн асуудлыг шийдвэрлэх

Ковид-19 цар тахлын сөрөг нөлөөгөөр зээлийн эргэн төлөлт нь түр хугацаанд хүндэрсэн зээлдэгчдийн хүндрэлийг шийдвэрлэхэд чиглэсэн макро зохистой бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Тухайлбал, зарим эрх бүхий байгууллагаас зээлийн хөнгөлөлт үзүүлэх (loan forbearance) тодорхой аргачлалыг боловсруулан мөрдүүлж байна. Түүнчлэн зарим оронд Ковид-19 цар тахалтай холбоотойгоор зээлийн эргэн төлөлтөө хийх боломжгүй болсон зээлдэгчдийн зээлийн ангиллыг тодорхой хугацаанд бууруулахгүй, хэвээр хадгалах бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна.

в. Хөрвөх чадварын нөөц (liquidity buffer)-ийг ашиглах

Банкуудад тавигдах хөрвөх чадварын нөөцийн шаардлагыг сулруулах нь түгээмэл байна. Ингэхдээ зарим оронд (Швед, Солонгос г.м) валютын төрлөөс хамааруулан

хөрвөн чадварын харьцааны шаардлагыг ялгаатай байдлаар сулруулах бодлогын шийдвэрийг гаргажээ.

Түүнчлэн олон орны төв банкуудаас заавал байлгах нөөцийн шаардлагыг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. Заавал байлгах нөөцийн шаардлага нь уламжлалт мөнгөний бодлогын хэрэгсэлд тооцогддог. Гэвч Ковид-19 цар тахлын сөрөг нөлөөгөөр санхүүгийн нөхцөл байдал чангарч, зээлийн тасалдал үүсч, санхүүгийн тогтвортой байдал алдагдах эрсдэл үүссэн энэ цаг үед заавал байлгах нөөцийн шаардлагыг бууруулах нь банкны хөрвөх чадвар болон зээл олголтыг дэмжих гол бодлогын арга хэрэгсэл болж байна. Иймд Иелийн их сургуулийн “Ковид-19 Financial Response Tracker” мэдээллийн санд уг арга хэрэгслийг макро зохистой бодлогын хэрэгсэлд хамруулж үзсэн байна.

d. Бусад арга хэмжээ

Эрх бүхий байгууллагуудын зүгээс банкууд болон зээлдэгчдэд тулгарч буй хүндрэлийг шийдвэрлэхэд чиглэсэн бусад төрлийн макро зохистой бодлогын арга хэрэгслийг өргөнөөр ашиглаж байна. Жишээлбэл, Шведийн Санхүүгийн зохицуулагч байгууллагаас ипотекийн зээлд тавигдах зээл ба үнэлгээний харьцааны хязгаарлалтыг түр хугацаанд сулруулаад байна.

Түүнчлэн, эрх бүхий байгууллагуудаас тодорхой бодлогын арга хэмжээний хэрэгжиж эхлэх хугацааг хойшлуулах, зарим төрлийн зардлыг бууруулах замаар банк, санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагааг дэмжиж байна. Тухайлбал, Базелийн хорооноос Базел III стандартыг мөрдүүлж эхлэх хугацааг хойшлуулав. АНУ-ын Холбооны Нөөцийн банкнаас банкуудад хийх хяналт шалгалтын үйл ажиллагааг багасган, зарим тайлангийн хугацааг хойшлуулаад байна. Мөн зарим оронд банк, санхүүгийн байгууллагуудад хязгаарлагдмал нөөц хөрөнгөө зээл олгох, хүндрэлд орсон зээлдэгчдийг дэмжих үйл ажиллагаанд зарцуулах боломжийг олгох хүрээнд комплаенсын зардлыг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлжээ.

Доорх хүснэгтүүдэд улс орнуудын макро зохистой бодлогын арга хэмжээг тоймлон харуулав.

ХҮСНЭГТ 1. МӨЧЛӨГ СӨРСӨН ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ШААРДЛАГА /МСӨХШ/

Улс орнууд	Өөрчлөлт оруулсан хугацаа	Өөрчилсөн хувь/хэмжээ	Тайлбар
Европын Холбооны улс орнууд			
Болгар	2020.04.01	0.5 хувиас 1 хувь болгон нэмэгдүүлэх төлөвлөгөөг цуцалсан.	МСӨХШ-ыг 2020 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс 1 хувь болгон нэмэгдүүлэх, 2021 онд 1-1.5 хувь хүргэх төлөвлөгөөг цуцлах шийдвэр гаргасан. Ингэснээр МСӨХШ 0.5 хувьд хэвээр хадгалагдаж байна. Дээрх шийдвэр нь нийт санхүүгийн системийн оролцогчдыг хамарч байна.
Чех улс	2020.04.01	1.75 хувиас 1 хувь болгон бууруулсан	Энэхүү шийдвэр нь зөвхөн банкны салбарт хамаарах бөгөөд ингэснээр банкууд бодит эдийн засгийг санхүүжүүлэхэд дэмжлэг үзүүлэх болно.
Исланд	2020.03.18	2 хувиас 0 хувь болгон бууруулсан	Энэхүү шийдвэр нь зөвхөн банкны салбарт хамаарах бөгөөд ирэх 12 сард өөрчлөлт оруулахгүй гэж харж байна.
Ирланд	2020.04.01	0 хувь	Энэхүү шийдвэр нь зөвхөн банкны салбарт хамаарна. 2021 онд мөчлөг сөрсөн өөрийн хөрөнгийн шаардлагыг нэмэгдүүлэхээр зарласан.
Литва улс	2020.04.01	1 хувиас 0 хувь болгон бууруулсан	Энэхүү шийдвэр нь зөвхөн банкны салбарт хамаарах бөгөөд 2021 оны 4 дүгээр сарын 1 хүртэл үргэлжилнэ гэж харж байна. Урьдчилан чөлөөлөгдсөн өөрийн хөрөнгө нь банкуудын зээл олголтыг 1 тэрбум еврогоор нэмэгдүүлж, улмаар Ковид-19 шокын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг тодорхой хэмжээнд бууруулна гэсэн хүлээлттэй байна.

Улс орнууд	Өөрчлөлт оруулсан хугацаа	Өөрчилсөн хувь/хэмжээ	Тайлбар
Норвеги	2020.03.13	2.5 хувиас 1 хувь болгон бууруулсан	Энэхүү шийдвэр нь зөвхөн банкны салбарт хамаарна.
Швед	2020.03.16	2.5 хувиас 0 хувь болгон бууруулсан	Уг шийдвэр нь 1 жилийн хугацаанд хэрэгжинэ.
Белги	2020.03.27	0 хувь	Энэхүү шийдвэр нь зөвхөн банкны салбарт хамаарах бөгөөд 2021 оны 3 дугаар сарын 31-ний өдөр хүртэл үргэлжилнэ.
Герман	2020.04.01	0 хувь	Энэхүү шийдвэр нь зөвхөн банкны салбарт хамаарна. Түүнчлэн хуримтлагдсан нөөц хөрөнгийг чөлөөлөх шийдвэрийг эрх бүхий байгууллагаас гаргаад байна.
Дани	2020.03.12	1 хувиас 0 хувь болгон бууруулсан	Энэхүү шийдвэр нь зөвхөн банкны салбарт хамаарах бөгөөд мөчлөг сөрсөн өөрийн хөрөнгийн нөөцийг бүрэн чөлөөлсөн байна.
Франц	2020.04.02	0.25 хувиас 0 хувь болгон бууруулсан	Энэхүү шийдвэр нь зөвхөн банкны салбарт хамаарах бөгөөд 0.25 хувиас 0.5 хувь болгон нэмэгдүүлэх шийдвэрийг цуцлан, 0 хувь болгон бууруулсан байна.
Америк тивийн улс орнууд			
АНУ	2020.03.15	-	Эдийн засгийн хүндрэлийн эсрэг иргэд, ААН-үүдэд зээлийн үйлчилгээ болон бусад төрлийн дэмжлэг үзүүлэхэд банкуудыг уриалж, өөрийн хөрөнгийн болон хөрвөх чадварын нөөц (buffer)-өө ашиглахыг зөвлөв.

Улс орнууд	Өөрчлөлт оруулсан хугацаа	Өөрчилсөн хувь/хэмжээ	Тайлбар
	2020.03.19	-	Банкуудыг өөрийн хөрөнгийн нөөцөө ашиглахыг дэмжих, урамшуулах зорилгоор Холбооны нөөцийн зөвлөл, ХДК, Валютын хяналтын байгууллагын хамтарсан шийдвэрээр банкны хуримтлагдсан ашиг (eligible retained income) тооцох аргачлалыг өөрчлөв.
	2020.04.09	-	Ковид-19 цар тахлын эсрэг хэрэгжүүлж буй MMLF, PPPLF санхүүжилтийн хөтөлбөрийн хүрээнд барьцаанд орох актив нь өөрийн хөрөнгийн шаардлагыг нэмэгдүүлэхгүй байх зохицуулалт тусгав.
Канад	2020.03.13	2.25 хувиас 1 хувь болгон бууруулсан	Дотоодын системийн ач холбогдолтой банкуудын нөөц өөрийн хөрөнгийн шаардлага (domestic stability buffer requirement)-ыг эрсдэлээр жигнэсэн активын 1.25 хувьтай тэнцэх хэмжээгээр бууруулж 1 хувьд хүргэв. Энэхүү шаардлагыг сулруулснаар банкуудын зээл олгох чадавх 300 орчим тэрбум доллараар нэмэгдэнэ.
Ази тивийн улс орнууд			
ХонгКонг	2020.03.16	МСӨХШ-ыг 2 хувиас 1 хувь хүртэл бууруулсан.	
Энэтхэг	2020.04.01	МСӨХШ-ыг мөрдүүлж эхлэх хугацааг 1 жилээр хойшлуулсан.	
Израйл	2020.03.19/ 2020.04.22	1 дүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээний шаардлагыг 1 нэгж хувиар бууруулсан. Ингэснээр том банкуудын хувьд тус харьцаа үзүүлэлт 10 хувиас 9 хувьд, дунд болон жижиг банкуудын хувьд 9 хувиас 8 хувьд хүрч буурсан.	
Сингапур	2020.04.07	Зээл олгоход дэмжлэг үзүүлэх зорилгоор өөрийн хөрөнгийн нэмэлт шаардлагыг сулруулсан.	

Улс орнууд	Өөрчлөлт оруулсан хугацаа	Өөрчилсөн хувь/хэмжээ	Тайлбар
Арабын нэгдсэн улс	2020.03.14/ 2020.04.05	Өөрийн хөрөнгийн нэмэлт шаардлагыг сулруулсан.	

ХҮСНЭГТ 2. ХӨРӨНГӨ ХАМГААЛАХ НӨӨЦ САН /CAPITAL CONSERVATION BUFFER/

Улс орнууд	Арга хэмжээ
Унгар	Ковид-19 цар тахлын сөрөг үр дагаврыг бууруулах, банкны салбарын хөрөнгийн нөөцийг ашиглах замаар зах зээлд зээлийн нийлүүлэлтийг нэмэгдүүлэн эдийн засгийн өсөлтийг дэмжих зорилгоор ХХНС-гийн шаардлагыг зөрчсөн зээлийн байгууллагад шийтгэл оногдуулахгүй байх шийдвэр гаргасан.
Итали	Европын холбооны улс орнуудын банкны салбарт учруулах Ковид-19-ийн сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор ЕВА болон ЕСВ-ээс холбогдох хэвлэлийн мэдээг гаргасан. Үүнтэй уялдуулан Италийн Төв банкнаас журам, зааварт өөрчлөлт оруулан илүү уян хатан болгож банкны үйл ажиллагааны ачааллыг бууруулах шийдвэрүүдийг авч эхлээд байна. Энэ хүрээнд ТТГЧ-ын харьцаа болон ХХНС-гийн түвшинг Р2G-ийн тодорхойлсон хөрөнгийн түвшингээс түр хугацаагаар бага байх боломжийг банкуудад олгоод байна. Энэхүү шийдвэр нь эрсдэлээс урьдчилан сэргийлэх, зээлийн хямралаас урьдчилан сэргийлэхийн тулд банкуудын зохицуулалтын хязгаарлалтыг багасгах зорилготой байна.
Словак	Төв банкнаас Ковид-19 нөхцөл байдалтай холбоотойгоор ХХНС-гийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг бууруулж 2.5 хувьд хүргээд байна. Энэ нь Европын Төв банкнаас зарласан арга хэмжээтэй уялдаж байгаа бөгөөд нийт банкны салбарыг хамарч байна.
Бразил	Санхүүгийн системийн ТТГЧ-ыг нэмэгдүүлэх зорилгоор ХХНС-гийн шаардлагыг эрсдэлээр жигнэсэн активын 2.5 хувиас 1.25 хувьд хүргэж бууруулав.

Улс орнууд	Арга хэмжээ
Малайз	ХХНС-гийн хувь хэмжээг 2.5 нэгж хувиар бууруулсан.
Оман	ХХНС-гийн хувь хэмжээг 2.5 хувиас 1.25 хувьд хүргэж бууруулсан.
Шри-Ланк	ХХНС-гийн хувь хэмжээг системийн ач холбогдолтой банкны хувьд 1 нэгж хувиар, системийн ач холбогдолгүй банкны хувьд 0.5 нэгж хувиар бууруулсан.

ХҮСНЭГТ 3. ЗААВАЛ БАЙЛГАХ НӨӨЦИЙН ХУВЬ ХЭМЖЭЭ

Улс орнууд	Өөрчлөлт оруулсан хугацаа	Тайлбар
БНХАУ	2020.03.17/ 2020.04.03	Хотод төвтэй бөгөөд зөвхөн орон нутагт үйл ажиллагаа явуулдаг банкууд, мөн орон нутагт үйл ажиллагаа явуулдаг зээлийн хоршоод, арилжааны банкууд, орон нутгийн банкуудын хувьд ЗБН-ийн хувь хэмжээг 1 нэгж хувиар бууруулсан.
ХонгКонг	2020.04.03	ЗБН-ийн хэмжээг 50 хувиар бууруулснаар 200 тэрбум Хонконг долларын зээлийн эх үүсвэр чөлөөлөгдсөн.
Индонез	2020.03.02/ 2020.04.14	Гадаад худалдааны үйл ажиллагаа санхүүжүүлдэг банкуудын дотоодын валютын ЗБН-н хувь хэмжээг 0.5 нэгж хувиар бууруулсан бол гадаад валютын ЗБН-н хувь хэмжээг 8 хувиас 4 хувьд хүргэсэн. Ийнхүү гадаад валютын ЗБН-н хувь хэмжээг бууруулснаар банкны системийн хөрвөх чадвар 3.2 тэрбум ам.доллараар нэмэгдэхийн зэрэгцээ гадаад валютын зах зээл дэх дарамт буурна гэж тус улсын төв банкнаас мэдэгдсэн байна. Түүнчлэн уламжлалт банкны үйл ажиллагаа эрхэлж буй банкуудын дотоодын валютын ЗБН-н хувь хэмжээг 2 нэгж хувиар бууруулсан бол Исламын банкны хувьд 0.5 нэгж хувиар бууруулсан.

Улс орнууд	Өөрчлөлт оруулсан хугацаа	Тайлбар
Филиппин	2020.03.24/ 2020.04.16	ЗБН-ийн хувь хэмжээг 4 хүртэлх нэгж хувиар бууруулсан.
Шри-Ланк	2020.03.17	ЗБН-ийн хувь хэмжээг бууруулж 4 хувьд хүргэсэн.
Турк	2020.03.07/ 2020.03.17	Гадаад валютын ЗБН-ийн хувь хэмжээг 5 нэгж хувиар бууруулсан. Дотоодын валютын ЗБН-д төлөх урамшууллын хувь хэмжээг бууруулсан. Ингэхдээ 2019 оны 8 дугаар сард гаргасан шийдвэртэй нийцтэй байдлаар буюу зээлийн өсөлттэй банкуудын ЗБН-ийн урамшууллын хувийг 10 хувиас 8 хувьд хүргэж бууруулсан. Харин 2019 оны 8 дугаар сард гаргасан шийдвэртэй нийцтэй бус зээлийн өсөлттэй банкуудын ЗБН-ийн урамшууллын хувийг 0 хувь болгосон.
Арабын нэгдсэн улс	2020.04.05	ЗБН-ийн хувийг 14 хувиас 7 хувьд хүргэж бууруулсан.
АНУ	2020.03.15	Иргэд, ААН-үүдэд олгох зээлийн урсгалыг дэмжих зорилгоор банкны ЗБН-ийн хувь хэмжээг 2020.03.26-ны өдрөөс эхлэн 0 хувьд хүргэж бууруулсан.
Бразил	2020.02.20	Санхүүгийн системийн ТТГЧ-ыг нэмэгдүүлэх зорилгоор хугацаатай хадгаламжийн ЗБН-ийн хувь хэмжээг 31 хувиас 25 хувьд хүргэж бууруулсан.
Колумб	2020.04.14	Банкны пассив /үүнд харилцах, хадгаламжийн данс зэрэг орно/-ын ЗБН-ийн хувь хэмжээг 11 хувиас 8 хувьд хүргэж бууруулсан.
Аргентин	2020.03.19	Зээл олголтыг дэмжих зорилгоор бичил бизнес болон ЖДҮ-үүдэд тусгай зээлийн санхүүжилт санал болгож буй банк, санхүүгийн байгууллагуудад ногдуулах ЗБН-ийн шаардлагын хувь хэмжээг бууруулсан.

Улс орнууд	Өөрчлөлт оруулсан хугацаа	Тайлбар
Перу	2020.03.26	Дотоодын валютаарх ЗБН-ийн хувь хэмжээг 5 хувиас 4 хувьд хүргэж бууруулсан. Харин 2 жилээс бага хугацаатай гадаад валютаарх хэрэгслийн ЗБН-ийн хувийг 50 хувиас 9 хувьд хүргэж бууруулсан. Гадаад валютаарх зээлийн хувьд ногдуулдаг нэмэлт ЗБН-ийг 2020 оныг дуустал тооцохгүй байхаар шийдвэрлэв. Эдгээр шийдвэрүүд нь зээл олголтыг дэмжих зорилготой байна.

ХҮСНЭГТ 4. СИСТЕМИЙН ЭРСДЭЛИЙН НӨӨЦ ХӨРӨНГӨ (SYSTEMIC RISK BUFFER)

Улс орнууд	Өөрчлөлт оруулсан огноо	Арга хэмжээ
Австри	2020.03.25	Банкуудад өөрийн хөрөнгийн нөөцийг шаардлагатай үед зөв зохистой ашиглах талаар сануулга, зөвлөмж өгсөн.
Эстон	2020.05.01	Банкны салбарт зээлийн алдагдлыг нөхөх, шинэ зээл олгох уян хатан байдлыг нэмэгдүүлэх зорилгоор СЭНХ-ийн хувийг 1 хувиас 0 хувь болгон бууруулсан.
Финланд	2020.04.06	Цар тахлын банкны нийт хөрөнгө болон банкны зээлийн чадавхад үзүүлэх нөлөөллийг хязгаарлах зорилгоор СЭНХ-ийн шаардлагыг түдгэлзүүлсэн.
Унгар	2020.03.18	СЭНХ-ийн ерөнхий шаардлагыг түтгэлзүүлэх шийдвэр гарсан. Тодруулбал 2020 онд СЭНХ-ийн шаардлагыг өөрчлөхгүй бөгөөд одоогийн 0 хувийн СЭНХ-ийн шаардлага хүчин төгөлдөр үйлчилнэ.
Ирланд	2020.03.18	СЭНХ-ийн шаардлагыг нэвтрүүлэх ажлыг хойшлуулсан.
Недерланд	-	3 хувийн СЭНХ-ийн шаардлагыг сулруулж ING-д 2.5 хувь, Rabo-д 2 хувь, ABN-д 1.5 хувиар тус тус тогтоосон.

Польш	2020.03.19	СЭНХ-ийн шаардлагаас чөлөөлсөн.
-------	------------	---------------------------------

ХҮСНЭГТ 5. СИСТЕМИЙН АЧ ХОЛБОГДОЛТОЙ САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДАД ЧИГЛЭСЭН АРГА ХЭМЖЭЭ

Улс орнууд	Системийн хувьд ач холбогдолтой санхүүгийн байгууллагад авах арга хэмжээ	Гол зорилго
Финланд	Тус улсын Төв банкнаас системийн ач холбогдолтой санхүүгийн байгууллага болох ОР группийн системийн эрсдэлийн нөөц шаардлагын хэмжээг 2 хувиас 1 хувь болгон бууруулаад байна.	Ковид-19-ийн нөлөөллийг бууруулж, банкны салбарын тогтвортой байдлыг хадгалах, зээлийн чадавхыг нэмэгдүүлэх зорилгоор авч хэрэгжүүлсэн.
Унгар	Төв банкнаас системийн ач холбогдолтой санхүүгийн байгууллагуудын хөрөнгийн нөөцийг 2020 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс чөлөөлөх шийдвэр гаргасан бөгөөд 2022 оноос эхлэн хэвийн түвшинд хүрнэ гэж харж байна.	Энэхүү хөрөнгийг чөлөөлснөөр банкны салбарын зээлийн үйл ажиллагаа болон эдийн засгийн өсөлтийг дэмжих зорилготой. Мөн ингэснээр зээл олгох зорилгоор 4,500 тэрбум HUF хөрөнгө чөлөөлөгдөх тооцоололтой байна.
Недерланд	Төв банкнаас нөөц хөрөнгийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг 2 хувиас 1 хувь болгон бууруулах шийдвэрийг гаргасан байна.	Ингэснээр санхүүгийн байгууллагуудын заавал биелүүлэх ачааллыг бууруулах зорилготой.
АНУ	Коронавирусын эсрэг хэрэгжүүлж буй “Paycheck Protection Program” хөтөлбөрийн хүрээнд санхүүжүүлэгдэх зээлийн эрсдэлийн жинг 0 хувь байхаар тогтоов.	Коронавирус-ийн сөрөг нөлөөг бууруулах
	Банкны холдинг компаниудын хувьд нэмэлт хөшүүргийн харьцаа (supplementary	Үнэт цаасны зах зээл дэх дарамтыг бууруулах, банкны

Улс орнууд	Системийн хувьд ач холбогдолтой санхүүгийн байгууллагад авах арга хэмжээ	Гол зорилго
	leverage ratio)-г тооцох аргачлалд түр хугацааны өөрчлөлт оруулж, нийт активт Сангийн яамны үнэт цааснууд болон ХНБ дахь хадгаламжийг оруулахгүй байхаар шийдвэрлэв. Энэхүү зохицуулалт 2021.03.31-ний өдөр хүртэл хэрэгжинэ.	салбарын зээл олголтыг дэмжих
	Орон нутгийн банк (community bank)-ны хөшүүргийн харьцааг түр хугацаанд буюу 2020 оны 2 дугаар улирлаас оны эцэс хүртэл 8 хувь байхаар бууруулав. Харин 2021 онд 8.5 хувь, 2022 оноос хойш 9 хувь байхаар тогтоов. Түүнчлэн 2020 оны 2 дугаар улирлаас оны эцэс хүртэл 8 хувиас доошгүй хөшүүргийн харьцаа болон бусад шалгуур нөхцөлүүдийг хангах банк нь орон нутгийн банкны хөшүүргийн харьцааны зохицуулалтыг сонгон, хэрэгжүүлж болно.	Орон нутгийн банк (community bank)-уудад дэмжлэг үзүүлэх

ХҮСНЭГТ 6. ТТГЧ-ЫН ХАРЬЦААТАЙ ХОЛБООТОЙ АРГА ХЭМЖЭЭНҮҮД

Улс орнууд	Өөрчлөлт оруулсан хугацаа	Тайлбар
Энэтхэг	2020.03.27	Цэвэр тогтвортой санхүүжилтийн харьцаа (NSFR)-г мөрдөж эхлэх хугацааг 6 сараар хойшлуулсан. Түүнчлэн ТТГЧ-ын харьцааг 100 хувиас 80 хувь хүртэл бууруулсан.
Индонез	2020.04.14	Макро зохистой бодлогын хүрээнд хөрвөх чадварын хамгаалалтыг уламжлалт банкны хувьд 2 нэгж хувиар, Исламийн банкны хувьд 0.5 нэгж хувиар нэмэгдүүлсэн.
Малайз	2020.03.25	NSFR-г 80 хувиар тогтоож, 2020 оны 7 дугаар сараас эхлэн мөрдөнө. 2020 оны 9 дүгээр сараас эхлэн тус харьцаа 100 хувь хүртэл нэмэгдэнэ. Түүнчлэн банкуудад ТТГЧ-ын харьцааны

		шаардлагыг хангахгүйгээр үйл ажиллагаа явуулах боломж бүрдсэн.
Сингапур	2020.04.27	NSFR-ийн шаардлагыг сулруулсан.
Солонгос	2020.03.26	Гадаад валютын хувьд ТТГЧ-ын зохистой харьцааг 80 хувиас 70 хувь хүртэл бууруулсан.
Арабын нэгдсэн улс	2020.04.05	ТТГЧ-ын зохистой харьцааг 70 хувь хүртэл бууруулсан.

ХҮСНЭГТ 7. ЗЭЭЛДЭГЧИД СУУРИЛСАН АРГА ХЭМЖЭЭ

Улс орнууд	Өөрчлөлт оруулсан огноо	Арга хэмжээ
БНЧУ	2020.04.01	Төв банкны удирдах зөвлөлөөс шинээр олгох ипотекийн зээлийн үнэлгээг зөөлрүүлсэн байна. Зээл-үнэлгээний-харьцааны хязгаарыг 80 хувиас 90 хувь болгон өөрчилсөн ч энэ шийдвэр нь хөрөнгө оруулалтын ипотекийн зээлд хамаарахгүй болно. Түүнчлэн өрийн үйлчилгээ ба орлогын харьцаа (DSTI)-г 45 хувиас 50 хүртэл нэмэгдүүлсэн бол өр ба орлогын харьцаа (DTI)-ны хязгаарыг цуцалсан байна. Зээл хүсэгчийн авах зээлийн хэмжээ нь жилийн цэвэр орлогоос нь 9 дахин ихгүй байх өр ба орлогын харьцааны шаардлага мөрдүүлж байсан байна.
Португаль	2020.04.01	Төв банкны шийдвэрээр 2020 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс 9 дүгээр сарын 30-ны өдрийн хооронд олгосон 2 жил хүртэлх хугацаатай, өрхийн хөрвөх чадварын хомсдолыг бууруулах зорилготой зээлүүдэд DSTI харьцааны шаардлага тавигдахгүй болсон.
Швед	2020.04.14	Шинэ болон хуучин ипотекийн зээлийн үндсэн болон хүүний төлбөрийг тодорхой хугацаагаар чөлөөлсөн байна.

Египет	2020.03.15/ 2020.04.16	Жижиг дунд үйлдвэр эрхлэгчид болон иргэдийн (хэрэглээний болон хувийн ипотекийн зээл) зээлийн сарын төлбөрийг 6 хүртэлх сарын хугацаагаар хойшлуулах шийдвэрийг гаргасан.
ХонгКонг	2020.04.03	800 сая Хонконг доллар болон түүнээс бага бараа эргэлтийн хэмжээтэй бөгөөд 30 хүртэлх хоногийн хугацаанд зээлээ төлөөгүй ААНБ-ын хувьд зээлийн үндсэн төлөлтийг 6 сар хүртэлх хугацаагаар хойшлуулах шийдвэр гаргасан. Мөн ямар нэгэн материал бүрдүүлэх шаардлагагүйгээр ЖДҮ эрхлэгчдийн зээлийн үндсэн төлбөрөөс чөлөөлөх эсвэл зээлийн хугацааг сунгах чиглэлийг банкуудад өгсөн. Үүнээс гадна ипотекийн зээлийн төлбөрийг 12 хүртэлх сараар хойшлуулах, улмаар зээлийн үлдэгдэл хугацааг 12 хүртэлх сараар сунгахыг банкууд болон санхүүгийн байгууллагуудад зөвшөөрсөн.
Энэтхэг	2020.03.17/ 2020.04.27	Зээлийн сарын төлбөрийг 3 хүртэлх сараар хойшлуулах шийдвэрүүдийг гаргасан.
Малайз	2020.03.25/ 2020.04.30	Зээлийн сарын төлбөрийг 6 хүртэлх сараар хойшлуулах шийдвэрүүдийг гаргасан.
Оман	2020.03.18/ 2020.04.23	Бүх төрлийн зээлийн төлбөрийг 3 хүртэлх сараар хойшлуулах шийдвэр гаргасан. Мөн корона вирусын нөлөөгөөр орлого буурсан ЖДҮ эрхлэгчдийн зээлийн сарын төлбөрийг 6 хүртэлх сараар хойшлуулсан.
Саудын Араб	2020.03.14/ 2020.04.30	Ямар нэгэн нэмэлт төлбөр, шимтгэл авахгүйгээр бүх төрлийн зээлийн сарын төлбөрийг 3 сараар хойшлуулсан.
Сингапур	2020.03.31/ 2020.04.30	Ипотекийн зээлийн үндсэн төлбөр болон нийт төлбөрийг хойшлуулах боломжтой болсон. Мөн 2020 оны 12 дугаар сар хүртэл ЖДҮ эрхлэгчдийн зээлийн сарын төлбөрийг хойшлуулах боломжтой болсон.
Шри-Ланка	2020.03.24/ 2020.05.01	Цар тахлын нөлөөнд автсан бизнесийн зээлийн сарын төлбөрийг 6 сараар хойшлуулсан. Мөн таксины үйлчилгээ эрхэлдэг иргэдийн автомашины зээлийн сарын төлбөрийг 6

		сараар, 1 сая рупигээс бага дүнтэй лизингийн зээлүүдийн сарын төлбөрийг 3 сараар хойшлуулсан.
Тайланд	2020.03.25/ 2020.04.07	Тээврийн хэрэгсэл, ипотека болон ЖДҮ эрхлэгчдийн зээлийн сарын төлбөрийг 3-6 сараар хойшлуулах эсвэл хүүний хөнгөлөлт үзүүлсэн.

ХҮСНЭГТ 8. БУСАД МАКРО ЗОХИСТОЙ БОДЛОГЫН ХҮРЭЭНД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ АРГА ХЭМЖЭЭ

Улс орнууд	Өөрчлөлт оруулсан огноо	Арга хэмжээ
Европын Холбооны улс орнууд		
Франц	2020.03	Хөрөнгийн зах зээлийн үйл ажиллагааг хэвийн үргэлжлүүлэх зорилгоор хувьцаа эзэмшигчдийн хурлыг цахим хэлбэрээр санал хураахыг дэмжиж байгаагаа мэдэгдсэн.
Латви	2020.03.26	Банкуудын ногдол ашиг хуваарилалтыг хойшлуулах эсвэл цуцлах шаардлагатай талаар Санхүүгийн болон хөрөнгийн зах зээлийн комиссоос олон нийтэд мэдэгдээд байна.
Нидерланд	2020.03.17	Ипотекийн зээлийн эрсдэлийн жинг нэвтрүүлэх хугацааг түр хойшлуулаад байна.
Азийн улс орнууд		
Малайз, Сингапур	2020.03.25	Кредит картын үлдэгдэл төлбөрийг бага хүүтэй, богино хугацаатай зээлийн бүтээгдэхүүн рүү шилжүүлэх боломжийг бүрдүүлсэн.
	2020.04.07	Зарим төрлийн тайлан авах хугацааг уян хатан болгосон.
Шри-Ланка, Тайланд	2020.03.24/ 2020.03.25	Кредит картын сарын төлбөрийн доод хэмжээг багасгасан.

Улс орнууд	Өөрчлөлт оруулсан огноо	Арга хэмжээ
Турк	2020.03.28	Кредит картын хүүний хэмжээнд дээд хязгаар тогтоосон. Тодруулбал, дотоодын валютын кредит картанд 1.25 хувь, гадаад валютын кредит картанд 1 хувиар тогтоосон.
Филиппин	2020.04.10	Банк, санхүүгийн үйл ажиллагаа хэвийн үргэлжлэх талаар олон нийтэд мэдээлэл хүргэсэн.
	-	Цар тахлын нөлөөтэй зээлүүдийн хувьд 1 жилийн хугацаанд зээлийн ангиллыг бууруулахгүй байх, хянан шалгалтын тайлан мэдээг хоцроосон тохиолдолд торгохгүй байх, тодорхой зээлүүдийн хувьд эрсдэлийн сан байгуулахгүй байх зэрэг шийдвэрүүд гаргасан.
Египет, Индонез, Израйл, Филиппин, Саудын араб, Сингапур	2020.03.15/ 2020.04.13	Банкны үйлчилгээг цахимаар авах үйл ажиллагааг дэмжсэн. Тухайлбал, цахимаар гүйлгээ хийх хэмжээг нэмэгдүүлэх, цахимаар гүйлгээ хийхэд тавигддаг хягаарлалтуудыг сулруулах зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн.
Сингапур	2020.04.30	Хөрөнгө оруулалтын зориулалт бүхий үл хөдлөх хөрөнгийн зээлийн бүтцэд өөрчлөлт оруулахдаа өр, орлогын харьцааг тооцохгүй болсон.
БНХАУ	2020.04.07	Илүүдэл нөөцөд төлөх хүүний хэмжээг 2008 оноос хойш анх удаа бууруулж 0.72 хувиас 0.35 хувьд хүргэсэн байна. Уг арга хэмжээг авч хэрэгжүүлснээр банкууд хөрөнгийн эх үүсвэрээ илүү үр ашигтай (efficient) ашиглах хөшүүрэг болно гэж Хятадын ардын банкнаас мэдэгджээ.
Оман, Саудын араб, Вьетнам	2020.03.18/ 2020.03.29	Шимтгэлийг бууруулах арга хэмжээ авах талаар банкуудад хүсэлт тавьсан.

Улс орнууд	Өөрчлөлт оруулсан огноо	Арга хэмжээ
Энэтхэг	2020.03.30	Корпорацийн бонд дахь гадаадын хөрөнгө оруулагчдын хөрөнгө оруулалтад тавигддаг хязгаарыг нэмэгдүүлж, 15 хувьд хүргэв.
Оман	2020.03.18	Үйл ажиллагаа нь хэвийн үргэлжилж байгаа салбаруудад зээл олголтыг нэмэгдүүлэх зорилгоор “Зээл санхүүжилтийн харьцаа (lending/financing ratio)”-г 87.5 хувиас 92.5 хувьд хүргэж нэмэгдүүлсэн.
Япон	2020.04.08	Түр хугацаанд хөшүүргийн харьцааны хязгаарлалтыг сулруулсан.
БНСУ	2020.03.26	Санхүүгийн байгууллагуудын хадгаламжаас бусад (non-deposit) 1 хүртэлх жилийн хугацаатай гадаад валютын эх үүсвэр (liabilities)-т ногдуулах татварыг 2020 оны 4 сараас 6 сарын эцэс хүртэл буюу 3 сарын хугацаанд түр нэмэгдүүлэх шийдвэр гаргасан. Солонгос улсын эдийн засаг нь гадаад шокт ихээхэн эмзэг байсан бөгөөд 1997 оны Азийн хямрал, 2008 оны дэлхийн санхүү эдийн засгийн хямралын үед тус улсаас ихээхэн хэмжээний хөрөнгийн урсгал гэнэт гадагшилж, эдийн засагт нь хүндрэл учруулж байсан. Иймд хөрөнгийн урсгалын хэт өндөр хэлбэлзлийг бууруулах, банк, санхүүгийн байгууллагуудын хэт их гадаад зээл авалтыг хязгаарлах зорилгоор Солонгос улсын төв банкнаас 2011 оны 4 дүгээр сард хадгаламжаас бусад гадаад валютын эх үүсвэрт татвар ногдуулах макро зохистой бодлогын арга хэрэгслийг нэвтрүүлсэн бөгөөд 1 жил хүртэлх хугацаатай эх үүсвэрт 0.2 хувь, 1-3 жилийн хугацаатай эх үүсвэрт 0.1 хувь, 3-5 жилийн хугацаатай эх үүсвэр 0.05 хувь, 5-аас дээш жилийн хугацаатай эх үүсвэрт 0.02 хувийн татвар ногдуулж эхэлсэн байна.
	2020.04.20	Репо арилжааны оролцогчдын тоог нэмэгдүүлсэн.
Шри-Ланк	2020.04.09	Гадагшаа мөнгөн гуйвуулга хийхэд хязгаарлалт тогтоосон.

Улс орнууд	Өөрчлөлт оруулсан огноо	Арга хэмжээ
	2020.03.30	Тухайн банкны чанаргүй зээлийн харьцаа 30 хувиас давсан тохиолдолд зээлийн ангилал хийхийг түдгэлзүүлсэн.
Египет	2020.03.15	Цар тахлын улмаас хүндрэл учирч буй салбаруудын талаар судлах, тэдгээр салбаруудад үйл ажиллагаа явуулж буй компаниудад дэмжлэг үзүүлэх төлөвлөгөөг боловсруулах талаар банкуудад хүсэлт хүргүүлсэн.
Сингапур	2020.04.07	Газар дээрх хяналт шалгалтын үйл ажиллагааг түр зогсоосон. Мөн цар тахлын нөлөөнд өртсөн бизнесүүд хэрхэн үйл ажиллагаагаа явуулж буй талаар судалж эхэлсэн.
Америк тивийн улс орнууд		
Бразил	2020.03.27	Ирэх 6 сарын хугацаанд хэвийн зээлийг дахин санхүүжүүлэх тохиолдолд эрсдэлийн сан нэмж байгуулахаас чөлөөлөв. Санхүүгийн системийн ТТГЧ-ыг нэмэгдүүлэх зорилготой.
Канад	2020.03.16,	Санхүүгийн системийн хэвийн үйл ажиллагааг дэмжих болон банкны ТТГЧ-ыг дэмжих зорилготой байнгын санхүүжилтийн хэрэгсэл болох барьцаат зээлийн Төв банкны өдрийн доод балансыг 2020.03.16-ны өдөр 250 сая доллараас 1 тэрбум долларт, 2020.03.18-ны өдрөөс 2 тэрбум долларт хүргэв.
	2020.03.18	Банкуудын олгосон ипотекийн бус зээлийн багцыг 100 хувиар тооцон дээрх санхүүжилтийн хэрэгслийн барьцаанд бүртгэх түр хугацааны зохицуулалт хийсэн.
АНУ	2020.03.27	Банкуудын зээлийн эрсдэлийн үүсмэл хэрэгсэл (counterparty credit risk derivatives contract)-ийг үнэлэх аргачлалыг эрт нэвтрүүлэхийг зөвшөөрсөн. Банкуудын өөрийн хөрөнгийн тооцоонд зээлийн алдагдлыг тооцох шинэ НББ-ийн стандартад шилжих хугацааг хойшлуулах боломж олгохоор

<i>Улс орнууд</i>	<i>Өөрчлөлт оруулсан огноо</i>	<i>Арга хэмжээ</i>
		болов. Иргэд, ААН-үүдэд олгох зээлийн урсгалыг дэмжих зорилготой.

___ооо___

ХАВСРАЛТ 2. “САНХҮҮГИЙН СИСТЕМИЙН ЭРСДЭЛИЙН ЗУРАГЛАЛ” ДАХЬ ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ЖАГСААЛТ

№	Индикатор	Эх Сурвалж
I. Макро эдийн засгийн нөхцөл байдал		
1 (1).	Бодит ДНБ-ий өсөлт (жилийн)	ҮСХ
2 (2).	ХҮИ-ийн өөрчлөлтөөр хэмжсэн инфляци (жилийн)	ҮСХ
3 (3).	Төсвийн тэнцэл/ДНБ	ҮСХ
4 (4).	Ажиллагсдын өсөлт (жилийн)	ҮСХ
5 (5).	Төлбөрийн тэнцэл	Монголбанк
6 (6).	Гадаад өр/Урсгал дансны орох урсгал	Монголбанк
7 (7).	ГВАН/Богино хугацаат өр	Монголбанк
8 (8).	Худалдааны тэнцэл (Бараа+Үйлчилгээ)/ДНБ	Монголбанк
9 (9).	M2 мөнгөний өсөлт	ҮСХ
II. Гадаад сектор		
1 (10).	БНХАУ-ын эдийн засгийн өсөлт	Блумберг
2 (11).	Гадаадын шууд хөрөнгө оруулалт/ДНБ	Монголбанк
3 (12).	Гадаад өр/ДНБ	Монголбанк

4 (13).	ГВАН-ийн импортын хэрэгцээг хангах түвшин	ҮСХ
5 (14).	Нэрлэсэн ханшийн өөрчлөлт	ҮСХ
6 (15).	Экспорт/Импорт	ҮСХ
7 (16).	Экспортын биет хэмжээний өсөлт	ҮСХ
8 (17).	Импортын биет хэмжээний өсөлт	ҮСХ
9 (18).	Экспортын гол түүхий эдийн үнийн индекс (зэс, нүүрс, алт, төмрийн хүдэр)	ҮСХ, OANDA
10 (19).	Урсгал тэнцэл/ДНБ	Монголбанк
11 (20).	ЗГ-ын бондны өгөөжийн зөрүү	Блүмберг
III. Мөнгөний зах зээл		
1 (21)	Бодит бодлогын хүү	Монголбанк
2 (22).	Бодит зээлийн хүү	Монголбанк
3 (23).	Дотоодын зээлийн өсөлт	ҮСХ
4 (24).	Банк хоорондын захын хүү	Монголбанк
5 (25).	Зээл, хадгаламжийн хүүгийн зөрүү	Монголбанк
6 (26).	Шинээр олгосон зээлийн хүү	

IV. Хөрвөх чадвар, санхүүжилтийн үзүүлэлтүүд

1 (27).	Банкны нийт зээл, хадгаламжийн харьцаа	ҮСХ
2 (28).	Нэг жилээс бага хугацаатай ОУ-ын зээллэгийн өөрчлөлт	ҮСХ
3 (29).	Гадаад валютын хадгаламж, нийт хадгаламжийн харьцаа	Монголбанк
4 (30).	Гадаад валютын зээл, нийт зээлийн харьцаа	Монголбанк
5 (31).	Хөрвөх актив/Богино хугацаат өр төлбөр	ҮСХ
6 (32).	Төв банкнаас банкны системд олгосон зээл, санхүүжилт	ҮСХ

V. Банкны салбарын ашигт ажиллагаа, төлбөрийн чадварын үзүүлэлтүүд

1 (33).	Банкны активын өгөөж (ROA)	Монголбанк
2 (34).	Чанаргүй зээл/Нийт зээл (NPL ratio)	ҮСХ
3 (35).	Өөрийн хөрөнгийн хүрэлцээ (CAR)	Монголбанк

VI. Хөрөнгийн зах зээл

1 (36).	ТОП-20 индексийн өөрчлөлт	ҮСХ
2 (37).	Уул уурхайн голлох компаниудын хувьцааны үнийн өөрчлөлт	ҮСХ
3 (38).	Орон сууцны үнийн индекс	Монголбанк, ҮСХ

Санхүүгийн нөхцлийг тодорхойлогч үзүүлэлтүүд

Репо хэлцлийн хүү	Монголбанк
Инфляци	Монголбанк
Бодлогын зорилтоос хазайх хазайлт	Монголбанк, ҮСХ
Зээлийн хүү	Монголбанк
Орон сууцны үнийн индекс	Монголбанк